

**“БАРИВЧЛАХ ШИЙТГЭЛ ОНОГДУУЛСАН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ
ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ”**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны захиалагч:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын
харьяа Баривчлах төв

**Судалгааны багийн
гишүүд:**

Б.Алтангэрэл

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм
шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн
шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч,
хууль зүйн доктор /Ph.D/, дэд профессор,
хурандаа

М.Хүрэлбат

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн
эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хошууч

Өмнөх үг

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төв нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын болон түүний харьяа алба, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн захиалгаар эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, тулгамдсан асуудал, харьцуулсан судлалын чиглэлээр судалгаа-шинжилгээний ажил хийн, улмаар боловсронгуй болгохтой холбоотой зөвлөмж-санал боловсруулж ирлээ.

Энэхүү судалгааны тайлан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвийн захиалгаар “Баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ” сэдвийн хүрээнд хийгдэн, Монгол Улсын хэмжээнд 2004-2020 оны хооронд үйлдэгдсэн захиргааны зөрчил, түүнд шүүхээс оногдуулсан баривчлах шийтгэлийг гүйцэтгэх ажиллагааг тухайн үед мөрдөгдөж байсан олон улсын болон үндэсний хууль тогтоомжийн хүрээнийн хэрэгжилтэд хийсэн судалгааны бүтээл юм.

Баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилтэд эрх зүйн зохицуулалтын болон практикийн хүрээнд тулгамдаж асуудлыг тодорхойлсон судалгаа шинжилгээний ажил хомс байхын зэрэгцээ шинэчлэн батлагдсан Зөрчлийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хүрээнд уг шийтгэлийг хэрэгжүүлэх онол, арга зүйн судалгаа зайлшгүй шаардлагатай байгаа энэ цаг үед өөрийн орны баривчлах шийтгэл эдлүүлэх ажиллагааны нөхцөл байдлыг тоймлон харах боломжийг энэхүү дүн шинжилгээний тайлан олгоно гэдэгт итгэж байна.

Судалгаанд ашигласан статистик тоо баримт, үйл ажиллагааны мэдээлэл нь байгууллагын албан ёсны тайлан, мэдээнд тулгуурласан хэдий ч тус тайлан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын болон Баривчлах төвийн удирдлагын байр суурь болон бусад үйл ажиллагааны чиг хандлага, хэрэгжилтийн түвшинг илэрхийлээгүй, зөвхөн судлаачдын хөндлөнгийн судалгаа боловсруулалтын ажлын үр дүн болно.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд хамтран ажилласан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Баривчлах төв болон судалгааны мэдээлэл цуглуулахад үнэтэй хувь нэмэр оруулсан судлаач, практик ажилтнуудад талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн,

Б.АЛТАНГЭРЭЛ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛЫН ТӨВИЙН

ЭРХЛЭГЧ, ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР, ХУРАНДАА

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	4
Зураг, хүснэгтийн жагсаалт	5-6
Нэр томъёоны тайлбар	7
Баривчлах шийтгэл эдлүүлэх ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн жагсаалт	8-10
Удиртгал	11-15
НЭГ.БАРИВЧЛАХ ШИЙТГЭЛИЙН ХУУЛЬ ЗҮЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ	
1.1. Баривчлах шийтгэлийн ойлголт, шинж, хууль зүйн үр дагаварт хийсэн шинжилгээ	16-29
1.2. Баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагаанд хамаарах олон улсын болон үндэсний хууль тогтоомжид хийсэн шинжилгээ	30-44
ХОЁР.БАРИВЧЛАХ ШИЙТГЭЛ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ /2015-2020 /	
2.1. Баривчлах байрны чиг үүрэг, хэрэгжилтэд хийсэн шинжилгээ	45-50
2.2. Баривчлагдсан этгээдийн эрх зүйн байдалд хийсэн шинжилгээ	51-57
2.3. Баривчлагдсан этгээдүүдийн дунд явуулж буй нийгэмшүүлэх болон зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд хийсэн шинжилгээ	58-65
2.4. Баривчлагдсан этгээдэд үзүүлсэн эмнэлэгийн тусламж, үйлчилгээнд хийсэн шинжилгээ	66-67
2.5. Баривчлагдсан этгээдэд тавих хяналт, хамгаалалтын үйл ажиллагаанд хийсэн шинжилгээ	68-70
2.6. Баривчлах байрны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтад хийсэн шинжилгээ	71-79
2.7. Баривчлагдсан этгээдийн төлбөр төлөлтөд хийсэн шинжилгээ	80-84
ГУРАВ. ДҮГНЭЛТ-ЗӨВЛӨМЖ	
3.1. Дүгнэлт	85-88
3.2. Зөвлөмж	89
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	90

Товчилсон үгийн жагсаалт:

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
УДШ	Улсын Дээд Шүүх
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
УЕПГ	Улсын Ерөнхий Прокурорын газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХЯЭА	Хорих ял эдлүүлэх алба
ХӨТЯЭА	Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба
ШШГТХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
ЗХ	Зөрчлийн хууль
ЗХШХТХ	Зөрчлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
СЯБЦХШБТХ	Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль

Зураг, хүснэгтийн жагсаалт:

Зураг 1.	Судалгаанд оролцогчдын нас
Зураг 2.	Судалгаанд оролцогчдын хүйс
Зураг 3.	Судалгаанд оролцогчдын боловсрол
Зураг 4.	Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлт
Зураг 5.	Шүүхээс 2004-2020 оны хооронд шийдвэрлэсэн захиргааны зөрчлийн судалгаа
Зураг 6.	Алба хаагчдаас авсан шийтгэлийн зорилгын талаарх асуулгын дүн
Зураг 7.	Шүүхээс 2004-2020 оны хооронд баривчлах шийтгэл оногдуулсан судалгаа
Зураг 8.	Баривчлах төвд 2015-2019 оны хооронд саатуулагдсан этгээдүүдийн судалгаа
Зураг 9.	Баривчлах төвд 2015-2019 онд саатуулагдсан этгээдүүдийн хүйсийн судалгаа
Зураг 10.	Гадаад улсын харьяат саатуулагдсан этгээдүүдийн тоон үзүүлэлт
Зураг 11.	Саатуулагдсан этгээдүүдийн харьяат улсын судалгаа
Зураг 12.	Баривчлах төвд 2015-2020 оны хооронд саатуулагдсан насанд хүрээгүй этгээдийн судалгаа
Зураг 13.	Баривчлагдсан Улаанбаатар хотын харьяат иргэдийн дүүргийн судалгаа/2019 он/
Зураг 14.	Баривчлагдсан этгээдүүдийн давтан баривчлагдсан талаарх судалгааны дүн
Зураг 15.	Судалгаанд оролцогчдийн үйлдсэн зөрчлийн судалгаа
Зураг 16.	Баривчлагдсан этгээдээс авсан баривчлах шийтгэлийн үр нөлөөнд хийсэн судалгааны дүн
Зураг 17.	Алба хаагчаас авсан баривчлах шийтгэлийн үр нөлөөнд хийсэн судалгааны дүн
Зураг 18.	Баривчлагдсан этгээдүүдээс авсан эрхийн баталгааны чиглэлээрх судалгааны дүн
Зураг 19.	Баривчлагдсан этгээдүүдээс авсан баривчлах байрны нөхцөл, журмын талаарх судалгааны дүн
Зураг 20.	Баривчлагдсан этгээдүүдээс 2015-2019 онд ар гэртэйгээ түр уулзалт хийсэн судалгаа
Зураг 21.	Баривчлагдсан этгээдээс авсан хоолны чанар, хүртээмжийн талаарх судалгааны дүн
Зураг 22.	Баривчлагдсан этгээдүүдээс авсан алба хаагчдын харьцааны талаарх судалгаа
Зураг 23.	Баривчлах шийтгэл эдлүүлэхтэй холбоотой гаргасан өргөдлийн судалгаа /2015-2019/
Зураг 24.	Албадан сургалтын үр нөлөөний талаарх судалгаа
Зураг 25.	Албадан сургалтын үр дүнг дээшлүүлэх талаарх санал
Зураг 26.	Баривчлах төвөөс яаралтай түргэн тусламж 103 дугаарын утсанд холбогдсон дуудлагын тоо
Зураг 27.	Баривчлах төвөөс Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд дуудлага өгсөн тоо
Зураг 28.	Баривчлагдсан этгээдүүдэд эрүүл мэндийн тусламж үзүүлсэн тоо
Зураг 29.	Баривчлагдсан этгээдүүдээс гадна эмнэлэг хэвтсэн тоо
Зураг 30.	Баривчлагдсан этгээдээс нас барсан байдлыг улсын дундажтай харьцуулсан байдал

Зураг 31.	Баривчлах өрөөнд хувиарлах талаарх санал асуулгын дүн
Зураг 32.	Баривчлах төвд 2015-2020 оны хооронд хийгдсэн үзлэг, нэгжлэгийн судалгаа
Зураг 33.	Баривчлах төвд 2015-2020 оны хооронд хийгдсэн үзлэг, нэгжлэгийн хүрээнд хураагдсан хориотой эд зүйлсийн судалгаа
Зураг 34.	Баривчлах байрны төлбөрийн талаарх санал асуулгын дүн
Зураг 35.	Баривчлах шийтгэл эдлэгсдээс төлбөр төлсөн байдлын судалгаа
Зураг 36.	Төлбөр төлөлтийн хувь
Зураг 37.	Төлбөр төлөлтийн мөнгөн дүн
Зураг 38.	Төлбөр төлөөгүй этгээдүүдийн судалгаа
Зураг 39.	Төлбөр төлөөгүй мөнгөн дүнгийн судалгаа
Зураг 40.	Ажил, хөдөлмөр хийх хүсэл, сонирхлын судалгаа
Хүснэгт 1.	Захиргааны хариуцлагын тухай хуулийн /1992/ үйлчлэлийн хүрээнд баривчлах шийтгэл оногдуулж ирсэн зөрчил
Хүснэгт 2.	Монгол Улсын хэмжээнд 2015-2019 оны хооронд бүртгэгдсэн захиргааны зөрчлийн судалгаа
Хүснэгт 3.	Монгол Улсын хэмжээнд 2015-2019 оны хооронд баривчлах шийтгэл оногдуулсан судалгаа
Хүснэгт 4.	Зөрчлийн хуульд заасан шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл
Хүснэгт 5.	2017 оны Зөрчлийн хуульд баривчлах шийтгэл ногдуулахаар заасан зөрчилийн судалгаа
Хүснэгт 6.	Баривчлах шийтгэлд хамаарах Олон Улсын болон үндэсний хууль тогтоомжийн харьцуулалт
Хүснэгт 7.	Баривчлагдсан этгээдийн эрх, үүрэг холбогдох хууль, журамд туссан байдал
Хүснэгт 8.	Баривчлах байрны ахуй нөхцөл холбогдох хууль, журамд туссан байдал
Хүснэгт 9.	Зан үйлд нөлөөлөх сургалтын үйл ажиллагааны харьцуулалт
Хүснэгт 10.	Баривчлах төвд 2015-2020 оны хооронд хийгдсэн хяналт, шалгалт, түүнд илэрсэн зөрчил, дутагдлын судалгаа

Нэр томьёоны тайлбар

(баривчлах шийтгэл гүйцэтгэх чиглэлээрх зарим нэр томьёог тайлбарлав)

- 1. Зөрчил**

Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүй
- 2. Захиргааны акт**

Захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно.
- 3. Сахилгын зөрчил**

Мөрдөгдөж буй хууль тогтоомжид сахилгын хариуцлага хүлээлгэхээр заасан үйлдэл
- 4. Сахилгын хариуцлага**

Хөдөлмөрийн сахилга зөрчсөн буруутай ажилтнуудад байгууллагын захиргаа эсвэл тэдгээрийг удирдах дээд шатны эрх бүхий албан тушаалтнуудаас хүлээлгэх төрийн албадлагын төрөл, хэлбэр
- 5. Зан үйл**

Хүний өдөр тутмын амьдралын үйл ажиллагаанд хэвшмэл зуршил болсон үйлдэл
- 6. Албадан эмчлэх**

Сэтгэцийн болон согтуурах мансуурах донтой, халдварт өвчтэй болох нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон этгээдийг шүүхийн шийдвэрээр албадан эмчлэх ажиллагаа
- 7. Гэр бүлийн хүчирхийлэл**

Гэр бүлийн хуулийн үйлчлэлд хамаарах этгээд хамаарал бүхий хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг
- 8. Эрх хасах шийтгэл**

Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар хязгаарлах, эсхүл зөвшөөрлийг хүчингүй болгох
- 9. Торгох шийтгэл**

Шүүх, эрх бүхий албан тушаалтнаас хүнд арваас хорин мянган торгуулийн нэгж, хуулийн этгээдэд нэг зуугаас хоёр зуун мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг мөнгөн төлбөр оногдуулах
- 10. Баривчлах шийтгэл**

Зөрчил үйлдсэн хүнийг долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар тусгай зориулалтын байранд саатуулах
- 11. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч**

шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаалтан, шийдвэр гүйцэтгэгч, хорих байгууллагын алба хаагчаас бүрдэнэ.

**БАРИВЧЛАХ ШИЙТГЭЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОХ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хууль, журмын нэр	Дугаар	Баталсан огноо
Нэг. Хууль			
1	Үндсэн хууль		1992-01-13
2	Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/		2017-05-11
3	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /шинэчилсэн найруулга/		2017-06-09
4	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /шинэчилсэн найруулга/		2016-12-22
5	Зөрчил шалган шийдвэрлэх тухай		2017-5-18
6	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/		2017-12-07
7	Сэжигтэн, яллагдагчийг баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай		1999-01-07
8	Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай		1994-06-13
Хоёр. Засгийн газрын тогтоол			
1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	204	2017-07-04
2	Хорих байгууллагын албан хаагчдад хоригдолтой ажилласны нэмэгдэл олгох журам	217	2002-10-23
3	Хорих байгууллагын алба хаагчдын ажлын онцгой нөхцлийн нэмэгдэл олгох журам	189	2011-06-22
4	Хорих байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байршил, хорих ангийн дэглэмийг батлах тухай	204	2017-07-04
5	МУ-ын Засгийн газрын 258-р тогтоол-Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай	258	2018-08-22
6	МУ-ын Засгийн газрын 2017 оны 10 сарын 26-ны өдрийн 01 албан даалгавар-Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай	01	2017-10-26
Гурав. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал			
1	Хуулийн байгууллагын ажилтнуудын сахилга, хариуцлагыг сайжруулах тухай	87/111/ 118	2011-06-23
2	Баривчлах байрны дотоод журам	A/246	2017-09-29
3	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн тангараг өргөх ёслолын журам	A/194	2017-07-21
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бэлгэ тэмдэг, тугны загвар, хэрэглэх журам	A/187	2017-07-16
5	Хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдлыг хангах аюулгүйн тойрог тогтоох журам	A/192 A/81	2017-07-18
6	Хорих ангийн харуул хамгаалалтын журам	A/197	2017-07-25
7	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан галт зэвсэг хэрэглэсэн тухай илтгэх, мэдээллэх журам	A/225 a/101	2017-09-06
8	Галт зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлийг хураан авч хадгалах, устгах, шилжүүлэх журам	A/233 A/100	2017-09-07

9	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журам	A/260 A/112	2017-10-18
10	Хууль зүй, дотоод хэргийн сайдын шагналын журам	A/87	2017-04-13
11	Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам	A/73	2017-04-04
12	Сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл, журам	A/236 A/104	2017-09-07
13	Жишиг норматив шинэчлэн батлах тухай	A/247	2017-09-29
14	ШШГБ-д ажиллаж буй цэргийн жинхэнэ алба хаагаагүй цэргийн насны алба хаагчдад цэргийн бэлтгэл эзэмшүүлэх хөтөлбөр батлах тухай	A/448	2017-10-20
15	Хоригдлын нормын хувцас, ахуйн хэрэглэлийн нэр төрөл, тоо, эдэлгээний хугацааг тооцох журам	A/18	2018-02-01
16	ШШГБ-ын алба хаагчийн алба хаах хугацааг сунгах журам	A/29	2018-02-15
17	Нэгдсэн эмнэлэг, мэргэжлийн эмнэлгийн дэглэм	A/127 A/69	2018-06-29
18	Хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийх журам	A/130	2018-07-30
19	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны сахилга, ёс зүйн дүрэм /Шинэчилсэн/	A/183	2018-09-27
20	Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дугаар хамтарсан тушаал "Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад эмчлэх, цагдан хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх журам"	A/142, A/47	2019-3-29
21	"ШШГБ-ын алба хаагчийн хэрэглэх техник хэрэгсэл, галт зэвсэг, сумыг бүртгэх, олгох, буцаан авах, хадгалах журам"	A/52	2019-4-04
Дөрөв. ШШГЕГ-ын даргын тушаал			
1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм	A/32	2008-02-18
2	Нийгмийн ажилтны аргачилсан заавар	A/129	2018-07-03
3	Сэтгэл зүйн ажлын заавар	A/110	2019-06-07
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албаны шалгалт явуулах журам	A/34	2013-02-06
5	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйлчилгээний стандарт	A/81	2013-04-24
6	Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хяналт тавих журам	A/80	2013-04-24
7	ШШГБ-ын үйлчилгээний стандартыг батлах тухай	A/81	2013-04-24
8	ШШГБ-ын хөдөлмөрийн дотоод журам	A/82	2013-04-24
9	ШШГБ-ын ажилтны ёс зүйн дүрэм батлах тухай	A/51	2017-03-10
10	ШШГБ-ын бага бүрэлдэхүүний бодлогын баримт бичиг	A/96	2017-05-03
11	Зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалт явуулах журам	A/169	2017-08-31

12	ШШГБ-ын алба хаагчийн мэргэшлийн түвшин үнэлэх журам	A/178	2017-09-06
13	ШШГБ-ын хүний нөөцийн журам	A/192	2017-09-19
14	ШШГБ-ын алба хаагчийн дүрэмт хувцас, чимэг хэрэглэлийг хураан авах, тооцоо хийх журам	A/194	2017-09-20
15	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллагын хамтран ажиллах журам	A/260 A/242	2017-12-14
16	Ахлагчийн зөвлөлийн ажиллах журам	A/167	2018-09-25
17	"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-д нэмэлт өөрчлөлт	A/148	2018-08-31
18	"Хоригдлын өдөр тутмын болон ажлын хувцасны арчилгаа, ариутгал хийх заавар"	A/77	2019-4-22
19	"Сэтгэл зүйн ажлын заавар"	A/110	2019-6-07

Удиртгал

Төрийн үндсэн чиг үүргийн нэг нь иргэдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхолыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж хамгаалах, хууль зөрчигчдөд хариуцлага тооцох, хэрэг маргааныг таслан шүүх замаар нийгэмд шудрага ёс, дэг журмыг тогтооход оршдог. Тиймээс зөвхөн хууль, шүүх эрх мэдлийн байгууллагууд төдийгүй төрийн институтийн ямар ч байгууллага үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагааг явуулж байх ёстой.

Монгол Улсын Засгийн газрын 1923 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 11 дүгээр хурлаар “Цагдан сэргийлэхийн эрх хэмжээний дүрэм”, “Цагдан цээрлүүлсэнийг зөрчсөнийг яллах хууль”-ийг анх баталж байжээ. “Цагдан цээрлүүлсэнийг зөрчсөнийг яллах хууль”-д захиргааны журам зөрчсөн, тухайн үедээ эрүүгийн хэргийн шинжгүй зөрчилд арга хэмжээ авах анхны хууль бөгөөд захиргааны зөрчлийн хүнд, хөнгөнийг харгалзан 1-15 хоног хорих, 1-15 төгрөгөөр торгууль ногдуулахаар заасан хэв журам сахиулах, хэрэг зөрчилтэй тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн эрх зүйн акт байжээ.

Ийнхүү Цагдан сэргийлэх байгууллага анх захиргааны журмаар баривчлах, нийгмээс тодорхой хугацаагаар тусгаарлан шийтгэл оногдуулдаг үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хууль /1992.11.27/ батлагдан гарах хүртэл захиргааны хариуцлагыг янз бүрийн хууль тогтоомж, эрх зүйн актаар хариуцлага хүлээлгэж байсан иржээ.

Социалист нийгмийн үед дийлэнх үйлдэгдэж байсан захиргааны шинжтэй зөрчил нь архидан согтуурах явдал байсан ба тухайн зөрчилтэй тэмцэх чиглэлээр олон арга хэмжээ авч хэрэгжүүлж иржээ. Манай улс 1960-аад оны сүүлч үеэс архидан согтуурах явдалтай тэмцэхэд анхаарлаа хандуулж эрх зүйн төдийгүй үзэл суртал, эдийн засаг, зохион байгуулалтын арга хэрэгслийг өргөнөөр ашиглаж гэмт хэрэг, нийгмийн хэв журам зөрчих явдалтай хамтран тэмцэх ажлын үр нөлөөг сайжруулах, согтуурлаас урьдчилан сэргийлэхэд бүх нийтийн хүчийг төвлөрүүлэх хандлагыг бий болгосон төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байжээ. Тухайлбал, нийгмийн хэв журам зөрчигчид, танхайрагчидтай явуулах тэмцлийг хүчтэй болгох тухай Монгол Ардын Намын Төв Хорооны 1967 оны 263 тоот тогтоол гарган, уг тогтоолд “ууж согтууран хэрэг өдүүлэх явдалтай тэмцэх явдал бол нам, улс олон нийтийн үйлдвэр, албан газар, соён гэгээрүүлэх байгууллага, хөдөлмөрийн хамт олон, иргэн нэг бүрийн чухал зорилт, нэр төрийн хэрэг” гэж үзжээ.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн “Спирт, архи, дарс, пиво үйлдвэрлэлийг журамлах тухай” 1971 оны 101-р зарлигаар улс хоршооллын байгууллага, спирт, архи, дарс, пиво үйлдвэрлэх шаардлага гарвал зөвхөн БНМАУ-ын сайд, сайд нарын зөвлөл шийдвэрлэж байх журмыг тогтоож тус улсад архи, дарс, пиво үйлдвэрлэх онцгой эрхийг Хүнс үйлдвэрлэлийн яаманд олгож уг зарлигыг зөрчвөл 200-500 төгрөгөөр торгож шийтгэл оногдуулж байхаар заажээ. Түүнчлэн БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1973 оны 243-р зарлигаар батлагдсан Хөдөлмөрийн хуулийн 33-р зүйлд үйлдвэр албан газрын ажилчин, алба хаагч

ажилдаа согтуу ирсэн бол түүний хөдөлмөрийн гэрээг хугацаагүй буюу түр хугацаатай цуцалж болно гэж заажээ. Архидан согтуурахтай тэмцэх нийгмийн бодлогын цаашдын хөгжилд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1974 онд гаргасан согтууруулах явдалтай хийх тэмцлийг хүчтэй болгох тухай 120-р зарлиг онцгой байр суурь эзэлдэг. Уг зарлигийн 2-р зүйлд "ресторан, аймгийн төв, орон нутгийн гуанзнаас бусад нийтийн хоолны газар, үйлдвэр албан газар байгууллага, оюутан сурагчдын нийтийн байр, орон сууцны орц, хонгил, дэлгүүр, сургууль, эмнэлэг, гудамж талбай, цэцэрлэг, цэнгэлдэх хүрээлэн, зах зээлийн газар, галт тэрэгний болон авто зам, нисэх онгоцны буудал, үзвэр, үйлчилгээний зэрэг олон нийтийн газарт согтууруулах ундааны зүйл уухыг хориглосон ба энэ зүйлд заасныг зөрчсөн буюу согтууран хэвийн бус байдал гаргасан этгээдийг 25-2000 төгрөгөөр торгож байхаар заажээ.

Насанд хүрээгүй хүмүүсээс согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн бол захиргааны эрх зүйн зөрчилд тооцож энэ журмыг зөрчсөн ажил хөдөлмөр эрхэлдэг 16-18 насны хүмүүст зарлигийн 8-р зүйлд зааснаар 50 төгрөгөөр торгох, бусад насанд хүрээгүй хүмүүсийн эцэг, эх, асран хамгаалагчийг 50 хүртэл төгрөгөөр торгох буюу олон нийтийн арга хэмжээ авч байхаар заасан байна.

Согтууруулах ундааны зүйл уусан үедээ авто техник жолоодсон жолоочийг 50-300 хүртэл төгрөгөөр торгох, авто техник жолоодсон жолоочийг 50-300 хүртэл төгрөгөөр торгож, авто техник жолоодох эрхийг 6 сараас 2 жил хүртэл, урьд нь эрхээ хасуулсан жолооч уг хугацаа дууссанаас хойш 3 жилийн дотор согтууруулах ундаа уусан үедээ авто техник жолоодвол 200-500 төгрөгөөр торгож авто техник жолоодох эрхийг 2-3 жил хүртэл хугацаагаар хасах, авто техник жолоодох эрхгүй боловч согтууруулах ундааны зүйл уусан үедээ авто техник жолоодсон этгээдийг 200-500 хүртэл төгрөгөөр, авто техник жолоодож яваа хүнтэй хамтарч согтууруулах ундааны зүйл уусан этгээдийг 25-500 төгрөгөөр тус тус торгохоор зарлигийн 12-р зүйлд заасан байна.

Архидалттай тэмцэх ажлын хүрээнд олон нийтийн үүсгэл санаачлагын зарим байгууллагад хөдөлмөрийн хамт олноос нийгмийн хэв журам зөрчигчид эрх зүйн зөрчил гаргагчидтай эвлэршгүй тэмцэх нөхцлийг бүрдүүлэх олон нийтийн нөлөөллийн арга хэмжээг хэрэглэх эрх зүйн үндэслэлийг улам боловсронгуй болгох зорилгоор Ардын Их Хурлын Тэргүүлэгчид 1981 онд нийгмийн хэв журам хамгаалах ардын нөхөрлөл, хэв журам хамгаалах олон нийтийн дүрэм, 1982 онд олон нийтийн шүүхийн дүрэм, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлөөс 1981 онд эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн хамт олны зөвлөлийн дүрмийг тус тус батлан гаргасан нь архидалттай тэмцэх эрх зүйн баримт бичиг болсон байна.

Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1974 онд гаргасан согтуурах явдалтай хийх тэмцлийг хүчтэй болгох тухай 120-р зарлигт 1986 онд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Зарлигт нэмэлт өөрчлөлт оруулсан чиглэл нь архи, дарс, пиво, худалдах журмыг зохицуулах талаар орон нутгийн АИХ, түүний гүйцэтгэх захиргааны эрхийг өргөтгөж өөрийн орон нутагт байгаа хүн амын тархалт байршилтад тохируулан тухайн цаг үеийн байдалтай холбоотойгоор түүнийг худалдах цэг, цагийг тогтоох боломж олгосон явдалд оршиж байв. Дээрх эрх зүйн зохицуулалтууд нь архидан согтуурах

явдалтай гол эрх зүйн акт байсан бөгөөд орчин цагт архидан согтуурах явдалтай тэмцэх хууль тогтоомжийн үндсэн эх сурвалж юм.

Монгол Улсад 1990 онд өрнөсөн ардчилсан хувьсгалын үр дүнд улс төр, нийгэм, эдийн засгийн харилцаа бүхэлдээ өөрчлөгдөн шинэчлэгдэж гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг өөр арга хэлбэрээр зохицуулах шаардлага бий болжээ.

Зөрчлийн тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон хүний эрх, эрх чөлөө, хувийн өмч зэрэг үнэт зүйлс, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хууль зөрчсөн аливаа үйлдэл, эс үйлдэхүйд хүлээлгэх хариуцлагыг ялгамжтай оногдуулах, хууль зүйн хариуцлагын тогтолцоог сайжруулах зорилгоор¹ баталжээ. Зөрчлийн тухай хууль нь нийгмийн тодорхой төрлийн харилцааг зохицуулж буй 230 гаруй хуулиар тогтоосон зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон хэм хэмжээг төрөлжүүлэн нэгтгэсэн² анхны хууль болсон.

Шүүхээс сүүлийн 15 жилийн байдлаар шийдвэрлэсэн захиргааны зөрчлийг судлан үзвэл жилд дунджаар 10,000-20,000 орчим хэрэг шийдвэрлэн, 6000-8000 орчим хүнд баривчлах шийтгэл ногдуулдаг байна.

Судалгааны багийн гишүүдээс дээрх олон улсын болон үндэсний хууль тогтоомжийн хүрээнд шүүхээс оногдуулсан баривчлах шийтгэлийг гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, тулгамдсан асуудлыг нээн илрүүлж, цаашид боловсронгуй болгохтой холбоотой дүгнэлт-зөвлөмж боловсруулахад шаардагдах судалгааны материалыг бий болгохыг зорин энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэсэн болно.

Судалгааны ажлын зорилго, зорилт:

Бид судалгааны ажлын хүрээнд Шүүхээс зөрчил үйлдсэн этгээдэд баривчлах шийтгэл оногдуулж буй байдалд дүн шинжилгээ хийн, 2015-2020 оны хооронд баривчлах шийтгэлийг эдлүүлж ирсэн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, практикт тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэх, улмаар тухайн асуудлыг шийдвэрлэхтэй холбогдсон дүгнэлт-зөвлөмж гаргах зорилгыг өмнөө тавин ажиллалаа.

Зорилгоо хангах хүрээнд дараах дэд зорилтуудыг дэвшүүлсэн болно.

1. Шүүхээс 2004-2020 оны хооронд шийдвэрлэсэн захиргааны зөрчил, оногдуулсан шийтгэлийн бүтцэд дүн шинжилгээ хийх;

2. Баривчлах шийтгэлийг эдлүүлэх үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх;

3. 2015-2020 оны хоорондын ШШГЕГ-ын харьяа Баривчлах төвийн хуулиар хүлээсэн чиг үүрэг, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх зэрэг болно.

Судалгааны ажлын арга зүй:

Судалгааны ажлыг явуулахад нийгмийн шинжлэх ухааны нийтлэг судалгааны арга болох диалектикийн аргыг иш үндэс болгон түүхчлэх, харьцуулах, бичиг баримтад дүн шинжилгээ хийх, анкетын болон ярилцлагын аргыг ашигласан болно.

¹ “Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал”, <http://forum.parliament.mn/projects/75>


² Мөн тэнд

Түүнчлэн Баривчлах төвийн үйл ажиллагаа, хэрэгжилтэд хийсэн нөхцөл байдлын судалгаа нь Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоол, Хууль зүйн сайдын 2014 оны А/01 дугаар тушаалаар баталсан "Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт, шинжилгээ, үнэлгээний аргачлал"-ийг эх үндэс болгосон бөгөөд эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудлыг тодорхойлохдоо эрдэм шинжилгээ, судалгаа-боловсруулалтын ажлын нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, статистик мэдээнд дүн шинжилгээ хийх, ажиглалт болон ярилцлагыг ашиглаж боловсруулалт хийсэн болно.

Баривчлах шийтгэл эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн талаар 452 баривчлагдсан этгээдээс анкетын аргаар судалгаа хийн энэхүү судалгааг гүйцэтгэсэн. Энэхүү судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллээр нь ангилан авч үзвэл:


1.Насны хувьд:16-20 насны 9 хүн буюу 1,9%, 21-25 насны 37 хүн буюу 8,1%, 26-30 насны 56 хүн буюу 12,3%, 31-35 насны 78 хүн буюу 17,2%, 36-40 насны 72 хүн буюу 15,9%, 41-45 насны 64 хүн буюу 14,1%, 46-50 насны 66 хүн буюу 14,6%, 50-аас дээш насны 70 хүн буюу 15,4% хамрагдлаа.

Зураг.1.Судалгаанд оролцогчдын нас




2.Хүйсний хувьд: Судалгаанд эрэгтэй 437 хүн буюу 96,6%, эмэгтэй 15 хүн буюу 3,3% байв.

Зураг.2.Судалгаанд оролцогчдын хүйс




3.Боловсролын хувьд: боловсролгүй-18 хүн буюу 3,9%, бага боловсролтой-15 хүн буюу 3,3%, бүрэн бус дунд боловсролтой-79 хүн буюу 17,4%, бүрэн дунд боловсролтой-236 хүн буюу 52,2%, дээд боловсролтой-103 хүн буюу 22,7% байв.

Зураг.3.Судалгаанд оролцогчдын боловсрол



4.Хөдөлмөр эрхлэлтийн хувьд: хувиараа хөдөлмөр эрхэлдэг гэх-187 хүн буюу 41,3%, эрхэлсэн тодорхой ажилтай-113 хүн буюу 25%, суралцдаг-13 хүн буюу 2,8%, ажилгүй-132 хүн буюу 29,2% байв.

Зураг.4.Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлт



Түүнчлэн баривчлах төвд ажиллаж буй 41 алба хаагчаас баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлын талаар тодруулах ярилцлага хийсэн болно.

НЭГ.БАРИВЧЛАХ ШИЙТГЭЛИЙН ХУУЛЬ ЗҮЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

1.1.Баривчлах шийтгэлийн ойлголт, шинж, хууль зүйн үр дагаварт хийсэн шинжилгээ

Баривчлах шийтгэлийн тухай асуудлыг авч үзэхийн өмнө зөрчил, түүний шинжийг тодорхойлох нь онолын болон практикийн чухал ач холбогдолтой юм.

Нэг.Зөрчил, түүний шинж:

Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 11-ны өдөр батлан гаргаж, мөн оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 2.1 дүгээр зүйлд “хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэнэ” гэж заажээ. “Хууль зөрчих” гэж хууль, Захиргааны ерөнхий хууль, бусад хуульд заасан журмын дагуу хүчин төгөлдөр болсон захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнийг ойлгоно.

Онолын талаас нь “Зөрчил” гэх ойлголтыг хууль зүйн доктор, дэд профессор Ч.Нямсүрэн “Эрх зүйн зөрчил гэж эрх зүйн хэм хэмжээний шаардлагыг зөрчсөн буюу түүний эсрэг чиглэсэн, нийгэмд хор аюултай, хуульд зааснаар хүлээх тусгай хариуцлага хүлээх эрх зүйн чадамжтай этгээдийн зан үйл” хэмээн бүтээлдээ³ тэмдэглэжээ. Тиймээс захиргааны зөрчил нь захиргааны журам зөрчсөнөөс үүдэн гардаг⁴. Нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон зан үйлийн горим, эрх зүйн хэм хэмжээг захиргааны журам гэнэ⁵. Захиргааны хариуцлага хүлээлгэх бодит үндэслэл нь захиргааны зөрчил гаргасан явдал юм. Мөн эрх зүйн зөрчлийг гэмт хэрэг, захиргааны эрх зүйн зөрчил, иргэний эрх зүйн зөрчил, сахилгын зөрчил, олон улсын эрх зүйн зөрчил гэсэн төрлүүдтэй хэмээн үзжээ.

Зөрчлийн тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд зөрчлийн шинжийг харгалзан хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийтгэл оногдуулна гэж заасан байна. Зөрчил нь дараах хууль зүйн шинжийг агуулдаг. Үүнд:

1. Эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн байх;
2. Нийгэмд хор уршигтай байх;
3. Гэм буруутай үйл ажиллагаа байх;
4. Хууль тогтоомжид заасан шийтгэл хүлээх үйлдэл, эс үйлдэл гэсэн шинжүүдтэй байна.⁶

Эндээс үзэхэд зөрчлийг тодорхойлох дараах шинж байна гэж үзэж байна.Үүнд:

1.Зөрчил нь үйлдэл ба эс үйлдэхүйгээр илэрнэ.

Хүний идэвхтэй (үйлдэл) буюу идэвхгүй (эс үйлдэл) зан үйлээр дамжин илэрдэг. Үйлдэл хийх гэдэг нь хүний идэвхитэй байдал, үйл хөдлөлөөр илэрхийлэгддэг бол эс үйлдэхүй нь тухайн хүн тодорхой нөхцөлд өөрийн хийх ёстой байсан буюу

³ Ч.Нямсүрэн, “Эрх зүйн онол” ерөнхий анги, УБ., 2016, 385 дахь тал.

⁴ Ж.Сүхбаатар, “Захиргааны эрх зүй”, УБ., 2005, 35 дахь тал.

⁵ Мөн тэнд.

⁶ С.Долгорсүрэн, “Захиргааны хариуцлага”, УБ., 2005, 47 дахь тал.

гүйцэтгэх үүрэгтэй байсан үйлдлийг хийгээгүйгээс нийгэмд аюултай хор уршиг бий болгоно.

Түүнчлэн тодорхой үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцсоныг мэдээгүй нь тухайн зөрчлийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг шийтгэл, албадлагын арга хэмжээ хэрэглэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Зөрчил болон гэмт хэргийн хоорондын ялгаатай шинжийн асуудал чухал сэдвийн нэг юм. Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хууль тогтоомжийн уялдаа холбооны нэг чухал асуудал бол гэмт хэрэг, зөрчил нь нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээгээрээ ялгагдах хэдий боловч харилцан бие биенийгээ нөхөх замаар хоорондоо харилцан нөхцөлдсөн байдаг явдал юм. Учир нь гэмт хэргийн нийгэмд аюултай шинж нь байнга хувьсан өөрчлөгдөж байдаг ойлголт бөгөөд үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2.1 дүгээр зүйлийн 3-т “Энэ хуулийн тусгай ангид заагаагүй үйлдэл, эс үйлдэхүй, хохирол, хор уршиг, гэм буруугийн шинжийг төсөөтэй хэрэглэж гэмт хэрэгт тооцохгүй” гэсэн заалт нь гэмт хэрэг, зөрчлийн ялгааг хуульчилсан нийтлэг хэм хэмжээ болох юм. Зөрчлийн тухай хууль ба захиргааны хариуцлагын хэм хэмжээ тогтоосон бусад хууль тогтоомжийн заалтыг үзэхэд гэмт хэрэг, захиргааны зөрчлийн ялгааг “... хэрэв эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол” гэсэн ерөнхий үг хэллэгээр заагласан нь бий.

Зөрчлийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журмыг зөрчихөөс хамгаалахын тулд тодорхой төрлийн захиргааны зөрчлүүд, тэдгээрийн бүрэлдэхүүн, зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх захиргааны шийтгэлийн төрөл хэмжээг хуульчлах замаар зорилт хэрэгжинэ.

Хүн, хуулийн этгээд нь хууль, захиргааны хэм хэмжээний актыг биелүүлэх боломжтой байсан боловч түүнийг биелүүлэх зохих арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол зөрчил үйлдсэнд тооцдог.

2.Зөрчил нь эрх зүйн хэм хэмжээний эсрэг чиглэсэн, эсвэл зөрчсөн байна.

Хууль нь төрийн эрх барих дээд байгууллагаас нийт улсын хэмжээнд бүх нийтийг заавал дагаж мөрдүүлэхээр баталсан албан ёсны дүрэм, журам бол захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно.

Зөрчлийн тухай хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журмыг зөрчсөн тодорхой төрлийн захиргааны зөрчлүүд, тэдгээрийн бүрэлдэхүүн, зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх захиргааны шийтгэлийн төрөл, хэмжээг хуульчилсан.

Өмнө мөрдөгдөж байсан 1992 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр батлагдсан Захиргааны хариуцлагын тухай хуулийн үйлчлэлийн хүрээнд дараах зохицуулалттай байжээ. Үүнд:

1.Захиргааны зөрчил нь Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журам санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй юм.

2.Зөрчил гаргасан этгээдэд дараахь захиргааны шийтгэл ногдуулна:
 а/торгох;
 б/тусгайлан олгосон эрх хасах /тээврийн хэрэгсэл жолоодох/;
 в/хууль бусаар олсон орлого, эд зүйл буюу зөрчил гаргахад ашигласан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, байрыг хураах;
 г/баривчлах.

3.Торгох, баривчлах шийтгэлийг үндсэн, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэлийг үндсэн болон нэмэгдэл, хууль бусаар олсон орлого буюу эд зүйлийг хураах шийтгэлийг нэмэгдэл шийтгэлийн хэлбэрээр хэрэглэнэ.

4.Зөрчил гаргасан иргэнийг торгох шийтгэл 100-50000, албан тушаалтныг торгох шийтгэл 1000-60000, байгууллага, аж ахуйн нэгжийг торгох шийтгэл 50000-250000 төгрөгийн хэмжээтэй, баривчлах шийтгэл 7-30 хоног, тусгайлан олгосон эрх хасах шийтгэл 6 сараас 2 жил хүртэл хугацаатай байна.

5.Баривчлах шийтгэлийг шүүгч ногдуулна.

6.Танхайрах, согтуурах, галт зэвсэг болон амьсгал боогдуулах, нулимс асгаруулах бодис хууль бусаар олж авах, авч явах, хадгалах, хүйтэн зэвсэг хууль бусаар авч явах, албан дайчилгаанаас зайлсхийх зөрчил гаргасан иргэнд баривчлах шийтгэлийг сумын Засаг дарга ногдуулж болно гэж заажээ.

Хүснэгт.1.Захиргааны хариуцлагын тухай хуулийн /1992/ үйлчлэлийн хүрээнд баривчлах шийтгэл оногдуулж ирсэн зөрчил

д/д	Зүйл, заалт	Захиргааны зөрчил
1.	21 дүгээр зүйл. Танхайрах	Гудамж, талбай, орон сууц, нийтийн тээвэр, үзвэр, үйлчилгээний болон олон нийтийн бусад газар хэрүүл маргаан, зодоон үүсгэсэн, бусдыг өдөөн хоргоосон, айлган сүрдүүлсэн, иргэдийн амгалан тайван байдал алдагдуулсан, олон нийтийг үл хүндэтгэсэн, үйлчилгээний болон дарааллын журам зөрчсөн бол 15000 хүртэл төгрөгөөр торгох, эсхүл 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна.
2.	22 дугаар зүйл. Согтуурах	Архидан согтуурч удаа дараа эрүүлжүүлэгдсэн бол 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна.
3.	23 дугаар зүйл. Галт зэвсэг болон амьсгал боогдуулах, нулимс асгаруулах бодис хууль бусаар олж авах, авч явах, хадгалах	Галт зэвсэг болон амьсгал боогдуулах, нулимс асгаруулах бодисыг хууль бусаар олж авсан, авч явсан, хадгалсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол уг зүйлийг хурааж 3000-10000 төгрөгөөр торгох, эсхүл 10-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна.
4.	24 дүгээр зүйл. Хүйтэн зэвсэг хууль бусаар авч явах	Ажил, үйлдвэрлэлийн зайлшгүй шаардлагатай нөхцөл, ёс заншлын дагуу хэрэглэж байгаагаас бусад тохиолдолд хутга, мэс, бусад хүйтэн зэвсгийг хот, суурин газарт зэвсгийн чанартайгаар биедээ авч явсан бол уг зүйлийг хурааж 5000 хүртэл төгрөгөөр торгох, эсхүл 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна.

5.	25 дугаар зүйл. Хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих	6.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон тохиолдолд 7-30 хоног баривчлах шийтгэл ногдуулна.
6.	30 дугаар зүйл. Шүүхийг үл хүндэтгэх	1.Шүүгдэгч, гэрч, хохирогч, нэхэмжлэгч, хариуцагч, шинжээч, орчуулагч болон шүүн таслах ажиллагаа хэрэгжүүлэхтэй холбогдуулан шүүхэд дуудагдсан этгээд хүрэлцэн ирэхээс зориуд зайлсхийсэн, түүнчлэн тогтоосон журам илтэд үл хүндэтгэсэн бол 5000-25000 төгрөгөөр торгох, эсхүл 7-14 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна.
7.		4. Шүүн таслах ажиллагаа хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан шүүгч, иргэдийн төлөөлөгчийг заналхийлсэн, доромжилсон нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 5000-15000 төгрөгөөр торгох, эсхүл 7-21 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна.
8.	30 ¹ дүгээр зүйл. Прокурорыг үл хүндэтгэх	Бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь прокурорт санаатайгаар саад учруулсан, түүнчлэн хууль бус шийдвэр гаргуулахаар тулган шаардсан, заналхийлсэн, шахалт үзүүлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 5000-15000 төгрөгөөр торгох, эсхүл 7-14 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна.
9.	30 ² дугаар зүйл. Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх, цагдаагийн байгууллагад худал мэдээлэл өгөх	1.Цагдаагийн алба хаагч, туслах ажилтны хууль ёсны шаардлагыг зориуд үл биелүүлсэн, биелүүлэхгүй байхыг уриалсан, эсэргүүцсэн, албан үүргээ биелүүлэхэд нь санаатайгаар саад учруулсан, албан үүрэгтэй нь холбогдуулан цагдаагийн алба хаагч, түүний гэр бүлийн гишүүн болон чөлөөнд гарсан цагдаагийн ажилтныг доромжилсон, гүтгэсэн, заналхийлсэн, хүч хэрэглэсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 5000-20000 төгрөгөөр торгох, эсхүл 7-14 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна.
10.	30 ⁴ дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтны хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх	2.Албан үүргээ гүйцэтгэхэд нь санаатайгаар саад учруулсан, эсэргүүцсэн, албан үүрэгтэй нь холбогдуулан доромжилсон, гүтгэсэн заналхийлсэн, хүч хэрэглэсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 5000-25000 төгрөгөөр торгох, эсхүл 7-14 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна.
11.	30 ⁶ дугаар зүйл. Тагнуулын ажилтны хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх	Тагнуулын ажилтны хууль ёсны шаардлагыг зориуд үл биелүүлсэн, биелүүлэхгүй байхыг уриалсан, эсэргүүцсэн, албан үүргээ биелүүлэхэд нь санаатайгаар саад учруулсан, албан үүрэгтэй нь холбогдуулан тагнуулын ажилтныг доромжилсон, гүтгэсэн, заналхийлсэн, хүч хэрэглэсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 5000-20000 төгрөгөөр торгох, эсхүл 7-14 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна.
12.	31 дүгээр зүйл. Төрийн байгууллагын ажилтны	Төрийн байгууллагын ажилтны нэр барьж хууран мэхлэх үйл ажиллагаа явуулсан нь эрүүгийн хариуцлага

	нэр барих	хүлээлгэхээргүй бол 1000-20000 төгрөгөөр торгох, эсхүл 30 хүртэл хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна.
13.	32 дугаар зүйл. Төрийн төлөөлөгчийн хууль ёсны шийдвэрийг биелүүлэхгүй байх, эсэргүүцэх	3.Төрийн төлөөлөгчийн хууль ёсны шийдвэрийг биелүүлэхгүй байх, төрийн төлөөлөгчийг албан үүргээ гүйцэтгэхэд нь саад хийх буюу биед нь халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 5000-20000 төгрөгөөр торгох, эсхүл 7-14 хоног баривчлах шийтгэл ногдуулна.

Зөрчлийн тухай хууль батлагдахаас өмнө Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй бие даасан 387 хууль байснаас захиргааны хариуцлага ногдуулсан хэм хэмжээ бүхий зүйл, заалттай 177 хуулиас 14 хуульд нь “хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ” гэж ерөнхий байдлаар зааж байсан байна. Захиргааны хариуцлагын тухай хууль нь материаллаг хууль төдийгүй мөн нэг зэрэг процессын хуулийн шинжийг давхар агуулдаг ба 1992 онд батлагдснаас хойш 1995, 1997, 2004, 2006 онуудад нийт 20 гаруй удаа нэмэлт өөрчлөлт оруулж байсан бөгөөд зарчмын шинжтэй шинэчлэлт огт хийгдээгүй, эрх зүйн зөрчилтэй холбоотой асуудлыг Захиргааны хариуцлагын тухай хуулиар бүрэн зохицуулж чадаагүй, хэм хэмжээний хоорондын зөрчил, давхардал бий болгосон зэрэг нь ард иргэдийн дунд хууль тогтоох байгууллагын ажилтнуудыг хардах, гаргасан шийдвэрийг хууль бус гэж үзэхэд хүргэж байснаас Зөрчлийн тухай хуулийг батлан гаргах шаардлагыг бий болгосон байна.

Зөрчлийн тухай хууль нь 240 орчим хуулиар хориглож, хязгаарласан 1800 орчим үйлдэл, эс үйлдэхүйг нэгтгэсэн Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журмыг зөрчсөн тодорхой төрлийн захиргааны зөрчлүүд, тэдгээрийн бүрэлдэхүүн, зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх захиргааны шийтгэлийн төрөл, хэмжээг хуульчилж өгчээ.

Хүснэгт 2. Монгол Улсын хэмжээнд 2015-2019 оны хооронд бүртгэгдсэн захиргааны зөрчлийн судалгаа⁷

д/д	Аймаг	2015	2016	2017	2018	2019
1.	Архангай	10197	9069	16003	22332	32539
2.	Баян-Өлгий	6639	7115	8245	10760	14146
3.	Баянхонгор	12494	7741	12179	21188	29352
4.	Булган	11109	9227	13374	21578	31461
5.	Говь-Алтай	6155	4761	6098	9456	15624
6.	Говьсүмбэр	10965	14178	17188	18779	24769
7.	Дархан-Уул	21959	22008	34860	49216	63852
8.	Дорноговь	17101	12275	18251	19671	33016
9.	Дорнод	18761	19041	14425	18198	20002
10.	Дундговь	10242	8384	14546	17727	21591
11.	Завхан	9668	5621	7805	9613	17635
12.	Орхон	17744	15095	22948	23791	31660
13.	Өвөрхангай	9036	8846	20753	24905	43498

⁷ ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны, шинжилгээний газрын тайлан.

14.	Өмнөговь	11388	12493	25131	40219	19311
15.	Сүхбаатар	7639	5138	5623	5278	9438
16.	Сэлэнгэ	22094	15791	23417	23436	26499
17.	Төв	23033	28266	49233	47029	56902
18.	Увс	10216	7320	8803	11880	16442
19.	Ховд	7883	6203	15169	13690	19080
20.	Хөвсгөл	12826	11257	14232	16227	21331
21.	Хэнтий	14139	7262	15868	19383	30763
22.	Улаанбаатар	1.151.800	733.830	962.866	1.253.822	1.596.914
Нийт		1.423.088	1.037.970	1.327.017	1.698.178	2.175.825

3.Зөрчил үйлдэгч нь гэм буруутай зан үйлтэй байна.

Энэ нь санаатай буюу болгоомжгүй гэсэн хоёр үндсэн хэлбэртэй байна. Эрх зүйн зарим зөрчил нь бэлтгэлт завдалтын үедээ, зарим нь тодорхой бодит хор уршиг учруулснаар төгс үйлдэгдсэнд тооцогдоно.

Хүснэгт 3.Монгол Улсын хэмжээнд 2015-2019 оны хооронд баривчлах шийтгэл оногдуулсан судалгаа⁸

д/д	Аймаг	2015	2016	2017	2018	2019
1.	Архангай	260	34	180	225	404
2.	Баян-Өлгий	167	72	212	221	265
3.	Баянхонгор	409	102	413	466	395
4.	Булган	184	46	126	179	277
5.	Говь-Алтай	149	18	140	114	185
6.	Говьсүмбэр	140	18	92	108	131
7.	Дархан-Уул	395	162	184	251	317
8.	Дорноговь	284	58	217	278	284
9.	Дорнод	605	412	452	235	311
10.	Дундговь	219	33	129	139	112
11.	Завхан	300	55	221	197	288
12.	Орхон	797	378	700	809	922
13.	Өвөрхангай	433	215	635	981	1286
14.	Өмнөговь	230	49	220	274	203
15.	Сүхбаатар	130	52	81	131	160
16.	Сэлэнгэ	472	215	519	427	398
17.	Төв	432	101	336	496	528
18.	Увс	220	38	195	224	251
19.	Ховд	245	29	296	338	374
20.	Хөвсгөл	277	30	163	272	326
21.	Хэнтий	406	296	603	554	487
22.	Улаанбаатар	6420	2967	5231	4062	7392
Нийт		13174	5380	11345	10981	15296

4.Зөрчлийн үндсэн гол шинж болох нийгэмд хор аюултай байна.

Зөрчил нь нийтээр дагаж мөрдвөл зохих хууль, эрх зүйн хэм хэмжээний актыг зөрчсөнөөрөө нийгэмд тодорхой хор уршиг учруулах шинжийг агуулж байдаг.

⁸ ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны, шинжилгээний газрын тайлан.

5.Зөрчил нь хууль зүйн хариуцлага хүлээлгэхээр хууль тогтоомжид заасан үйлдэл, эс үйлдэхүй байна.

Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд дараахь шийтгэл, албадлагын арга хэмжээ оногдуулна:

Хүснэгт 4. Зөрчлийн хуульд заасан шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл

Д/д	Шийтгэл	Албадлагын арга хэмжээ
1.	<p>Торгох шийтгэл:</p> <p>Зөрчлийн хуулийн тусгай ангид заасан хэмжээгээр шүүх, эрх бүхий албан тушаалтнаас мөнгөн төлбөр оногдуулахыг торгох шийтгэл гэнэ. Торгох шийтгэлийн хэмжээ нь хүнд арваас хорин мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, хуулийн этгээдэд нэг зуугаас хоёр зуун мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байх ба нэг торгуулийн нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна.</p> <p>Шүүх, эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэгчийн хөрөнгө, цалин хөлс, бусад орлогыг харгалзан торгох шийтгэлийг нэг жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэж болно. Зөрчлийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хөрөнгө, орлого, нөхөн төлбөр, хохирлын тодорхой хувиар тооцсон хэмжээгээр торгох шийтгэлийг оногдуулах ба хэсэгчлэн төлүүлэх арга хэмжээ хамаарахгүй.</p> <p>Торгох шийтгэлийг сонгож оногдуулахаар заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол эрх бүхий албан тушаалтны саналаар шүүх баривчлах шийтгэлээр солино.</p>	<p>Хөрөнгө, орлогыг хураах, шилжүүлэх:</p> <p>Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулж, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураана. Хураасан хөрөнгө, орлогыг хохирол нөхөн төлөхөд зарцуулах, эсхүл устгах, шилжүүлэх эсэхийг холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ. Хөрөнгө, орлогоос хохирол нөхөн төлөхөд зарцуулж, үлдсэн хэсгийг улсын төсөвт төвлөрүүлнэ.</p> <p>“Зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж зөрчил үйлдэн олж авсан мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг арилжаалж бий болгосон бусад эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг түрээслэх, ашиглах замаар олсон бүх төрлийн орлогыг ойлгоно.</p>
2.	<p>Баривчлах шийтгэл:</p> <p>Зөрчил үйлдсэн хүнийг долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар тусгай зориулалтын байранд саатуулахыг баривчлах шийтгэл гэнэ. Баривчлах шийтгэлийг шүүгч оногдуулна. Баривчлах шийтгэл эдлүүлэх журмыг хуулиар тогтооно. Шүүх баривчлах шийтгэлийг жирэмсэн эмэгтэй, арван дөрөв хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эх, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүнд оногдуулахгүй ба энэ тохиолдолд нэг хоногийг арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тооцож торгох шийтгэл оногдуулж болно. Хуульд заасан тохиолдолд</p>	<p>Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах:</p> <p>Зөрчлийн хуульд заасан тохиолдолд эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, зэвсэг, хэрэгслийг хураана. Зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналгыг хураах, эсхүл түүний үнийг гаргуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл нь зөрчил үйлдсэн хүний амьжиргааны эх үүсвэр болсон эд зүйл, хэрэгсэл бол тэдгээрийг</p>

	баривчлах шийдвэр биелүүлэхийг хойшлуулж болно. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үед саатуулагдсан хугацааг баривчлах шийтгэл эдлүүлэх хугацаанд оруулан тооцно. Хэд хэдэн зөрчилд оногдуулсан баривчлах шийтгэлийн нийт хугацаа гурван сараас хэтрэхгүй байна.	хураахгүй. Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл гэдэгт зөрчил үйлдэхдээ ашигласан зэвсэг, хэрэгсэл, эд зүйл, тээврийн хэрэгсэл, уналга, зөрчилтэй бараа, бүтээгдэхүүн, эд зүйлийг ойлгоно.
3.	<p>Эрх хасах шийтгэл:</p> <p>Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар хязгаарлах, эсхүл зөвшөөрлийг хүчингүй болгохыг эрх хасах шийтгэл гэнэ. Хууль, захиргааны хэм хэмжээний актад заасан журмын дагуу тооцсон онооны бүртгэлийг үндэслэж эрх хасах шийтгэлийг оногдуулж болно. Зөрчлийн хуульд заасан тохиолдолд эрх хасах шийтгэлийг торгох шийтгэл дээр нэмж оногдуулна. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тусгайлан олгогдсон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах, эрхээ хэрэгжүүлэх хууль, захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон журмыг байнга, эсхүл ноцтой зөрчсөн, эсхүл тусгайлан олгогдсон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах, эрхээ хэрэгжүүлэх журмыг зөрчсөн зөрчилд нь оногдуулсан шийтгэлийг биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн бол эрх хасах шийтгэлийг үндсэн шийтгэл дээр нэмж оногдуулна.</p>	<p>Хохирол, нөхөн төлбөр гаргуулах:</p> <p>Зөрчлийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдээс учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, зөрчлийн улмаас учирсан хохирол барагдуулах, хор уршгийг арилгах арга хэмжээнд зарцуулж, үлдсэн хэсгийг улсын төсөвт төвлөрүүлнэ.</p> <p>Тайлбар: Энэ бүлэгт заасан “эрх бүхий албан тушаалтан” гэж зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтныг ойлгоно.</p>
4.		<p>Албадан эмчлэх:</p> <p>Зөрчил үйлдсэн хүн донтох сэтгэцийн эмгэгтэй болох нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон бол шүүх түүнийг албадан эмчилгээнд хамруулахаар шийдвэрлэж болно. Албадан эмчлэхтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.</p>
5.		<p>Албадан сургалт:</p> <p>Зөрчлийн хуулийн тусгай ангид өөрөөр заагаагүй бол шүүх баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэн хүнд албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээг хэрэглэж</p>

		болно. Албадан сургалтыг баривчлах шийтгэлийг эдэлж байх хугацаанд эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ. Албадан сургалт арван цагаас тавин цагийн хугацаатай байна. Албадан сургалттай холбоотой харилцааг хуулиар зохицуулна.
--	--	--

Торгох, баривчлах шийтгэлийг үндсэн, эрх хасах шийтгэлийг нэмэгдэл шийтгэлийн хэлбэрээр оногдуулна. Зөрчлийн хуульд заасан тохиолдолд эрх бүхий албан тушаалтан зөрчлийн үр дагаврыг арилгах, учирч болзошгүй хохирол, хор уршгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна. Тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол зөрчил илэрсэн өдрөөс үйл ажиллагааг зогсооно.

Тээврийн хэрэгсэл ашиглан зөрчил үйлдсэн нь автомат ажиллагаатай зураг-дүрс бичлэгийн техник, хэрэгслээр бэхжүүлэгдсэн бол тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигчид шийтгэл оногдуулна. Тээврийн хэрэгслийг өөр хүн эзэмшиж, эсхүл ашиглаж байсан нь тогтоогдсон бол өмчлөгч, эзэмшигчийг шийтгэлээс чөлөөлж, зөрчил үйлдсэн хүнд шийтгэл оногдуулна.

6.Зөрчил нь хууль зүйн хариуцлага хүлээх чадамжтай этгээдийн хууль бус үйлдэл, эс үйлдэл мөн.

Зөрчлийн хуульд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэж болохоор хуульчилжээ.

1.Зөрчил үйлдсэн хүн:

а.Зөрчил үйлдсэн, зөрчил үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүнд хуульд заасан шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

Б.Зөрчил үйлдсэн арван дөрвөөс арван найман насны хүний хувийн байдал, зөрчлийн шинж, зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдлыг харгалзан шийтгэлээс чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

В.Гадаад улсын дипломат эрх ямба, дархан эрх эдэлж байгаа хүнд шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх эсэхийг Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Г.Арван дөрвөөс арван зургаа хүртэл насны хүн нь:

-5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг /мансуурах/

-5.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг /танхайрах/

-5.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг/жагсаал, цуглаан зохион байгуулах журам зөрчих/

-8.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг /хулгайлах/

-14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт /замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих/ заасан зөрчил үйлдсэн бол шийтгэл хүлээлгэнэ.

2.Зөрчил үйлдсэн хуулийн этгээд:

а.Хуулийн этгээдэд түүний төрөл, хэлбэр, өмч хөрөнгө, оршин байгаа газар, үйл ажиллагааны чиглэлээс үл хамааран Зөрчлийн хуульд заасан тохиолдолд шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

Б.Зөрчил үйлдсэн хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан, түүнийг санаатайгаар дампууруулсан, татан буулгасан бол доор дурдсан журмаар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ:

-бусад хуулийн этгээдтэй нийлүүлэн нэг хуулийн этгээд үүсгэсэн бол шинээр бий болсон хуулийн этгээдэд;

-бусад хуулийн этгээдэд нэгтгэсэн бол нэгтгэж авсан хуулийн этгээдэд;

-хуваах, тусгаарлах замаар өөр хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол үйлдсэн зөрчилд холбогдох эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг, үйл ажиллагааг шилжүүлэн авсан хувь хэмжээгээр нь зохих хуулийн этгээдэд;

-хуулийн этгээдийн зохион байгуулалтын төрөл, хэлбэр, үндсэн зорилгоо өөрчлөх замаар өөрчлөгдсөн бол тухайн өөрчлөгдөн зохион байгуулагдсан хуулийн этгээдэд;

-компани нь толгой компани, түүний үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлын үүднээс зөрчил үйлдсэн нь тогтоогдсон бол толгой компанид;

-зөрчлийн хэргийг шалган шийдвэрлэх явцад хуулийн этгээдийг санаатайгаар татан буулгасан бол торгох шийтгэл, хохирол, хор уршиг нөхөн төлүүлэх албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг эд хөрөнгө хуваарилагдсан хувьцаа эзэмшигчид;

-аливаа хэлбэр, арга, хэрэгслээр эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийг үндэслэлгүйгээр тухайн хуулийн этгээдээс шилжүүлэн авсан нэгдмэл сонирхолтой этгээдэд, эсхүл эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийг хариу төлбөргүйгээр шилжүүлэн авсан бусад хуулийн этгээдэд шилжүүлэн авсан хөрөнгийн хувь хэмжээгээр.

-Хуулийн этгээдэд шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэх нь шийтгэлийн зорилгыг хангах боломжгүй бол шүүгч зөрчил үйлдэгдэх үед тухайн зөрчилд холбогдох эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг, үйл ажиллагааг бүхэлд нь хариуцаж байсан хуулийн этгээдэд шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

-хуулийн этгээд өөрчлөн байгуулагдахаас өмнө тухайн зөрчлийн талаар мэдсэн эсэхээс нь үл хамааран шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

-Гадаад улсын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар Монгол Улсын нутаг дэвсгэрт зөрчил үйлдсэн бол хуулийн этгээдийн нэгэн адил шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.


-Хуулийн этгээдийг төлөөлөн, түүний ашиг сонирхлын төлөө энэ хуульд заасан зөрчил үйлдсэн бол хуулийн этгээдэд шийтгэл оногдуулна.

-Хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ хэрэглэсэн нь тухайн зөрчлийг үйлдсэн хүнийг эрүүгийн хариуцлага, шийтгэл, албадлагын арга хэмжээнээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

-Зөрчил үйлдсэн хүнд шийтгэл оногдуулсан нь тухайн зөрчлийг үйлдсэн хуулийн этгээдийг шийтгэл, албадлагын арга хэмжээнээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Шүүхээс сүүлийн 15 жилийн байдлаар шийдвэрлэсэн захиргааны зөрчлийг судлан үзвэл жилд дунджаар 10,000-20,000 орчим хэрэг шийдвэрлэдэг байна.

Зураг 5. Шүүхээс 2004-2020 оны хооронд шийдвэрлэсэн захиргааны зөрчлийн судалгаа⁹



Хоёр.Баривчлах шийтгэлийн ойлголт, онцлог:

Зөрчлийн тухай хуулийн 3.1.1-т зааснаар “шийтгэлийн зорилго нь хүн, хуулийн этгээдийг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, зөрчил үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, шударга ёсыг тогтооход оршино” гэжээ.

Хүснэгт 5. 2017 оны Зөрчлийн хуульд баривчлах шийтгэл ногдуулахаар заасан зөрчилийн судалгаа


д/д	Зөрчлийн хуулийн холбогдох зүйл, заалтын нэр	Агуулга
1.	5.1 дүгээр зүйл.Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах	3.Мансуурсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
2.	5.2 дугаар зүйл.Танхайрах	1.Олон нийтийн газарт, эсхүл орон байранд: 1.1.хэрүүл маргаан үүсгэж; 1.2.бусдыг өдөөн хатгаж; 1.3.бусдын амгалан тайван байдал алдагдуулж; 1.4.олон нийтийг үл хүндэтгэж; 1.5.үйлчилгээний болон дарааллын журам зөрчиж биеэ авч явах нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг зөрчсөн, эсхүл аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
3.	5.4 дүгээр зүйл.	4.Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг:

⁹ ШЕЗ-ын тайлан, мэдээ

	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	<p>4.1.зодсон;</p> <p>4.2.хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан;</p> <p>4.3.бусадтай харилцахыг хязгаарласан;</p> <p>4.4.хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.</p>
4.	5.8 дугаар зүйл.Жагсаал, цуглаан зохион байгуулах журам зөрчих	6.Жагсаал цуглааныг зохион байгуулагч, оролцогч зэвсэг, хорт бодис, тэсэрч дэлбэрэх бодис, орчин тойрон, хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болохуйц аливаа зүйл, амьтан авч явсан бол зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулах, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5.	6.20 дугаар зүйл.Хүүхдийн эрхийг зөрчих	6.Тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээр сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
6.	6.26 дугаар зүйл.Бэлгийн дарамт учруулах	1.Бусдад ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, сэтгэл санааны үр дагавар үүсгэж бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийх сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
7.	8.6 дугаар зүйл. Хулгайлах	1.Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг албадан сургалтад хамруулж долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
8.	8.7 дугаар зүйл.Хөрөнгө завших	1.Бусдын итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг завшсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
9.	14.7 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих	5.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

Баривчлах байрны 41 алба хаагчаас шийтгэлийн зорилго нь юу вэ? гэсэн асуултанд 20 алба хаагч буюу 48,7% нь “хүн, хуулийн этгээдийг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, зөрчил үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, шударга ёсыг тогтоох” гэж зөв, 12 алба хаагч буюу 29,2% нь “тодорхой зорилго байхгүй”, 6 алба хаагч буюу 14,6% нь “иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсэн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх” гэж эрүүгийн хариуцлагын зорилготой адилтгасан, 3 алба хаагч буюу 7,3% нь “зөрчил үйлдсэн этгээдийг цээрлүүлэх” гэж тус тус хариулсан байна. Эндээс харахад судалгаанд оролцогчдын тал хувь нь “шийтгэл”-ийн үндсэн зорилгын талаар буруу хариулсан нь шийтгэлийн зорилго, агуулгын талаарх мэдлэг алба хаагчдад учир дутагдалтай байгааг харуулж байна.

Зураг 6. Алба хаагчдаас авсан шийтгэлийн зорилгын талаарх асуулгын дүн



Зөрчлийн тухай хуульд зөрчил үйлдсэн тохиолдолд торгох, баривчлах, эрх хасах гэсэн шийтгэл оногдуулахаар зохицуулсан ба 931 торгох, 9 баривчлах, 16 эрх хасах, мөн торгох, баривчлах үндсэн шийтгэл дээр нэмэгдүүлэн эрх хасах шийтгэлийг оногдуулахаар заажээ.

Зөрчлийн шийтгэл гэдэг нь зөрчлийн хуульд заасан хэм хэмжээг санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн гэм буруутай этгээдэд хүлээлгэж байгаа албадлагын арга хэмжээ юм. Зөрчлийн шийтгэл нь хууль зүйн бусад хариуцлагын нэгэн адил нийтлэг шинж, зарчмыг агуулахын зэрэгцээ доор дурьдсан өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой байдаг Үүнд:

- Шийтгэлийг хуулиар эрх олгосон байгууллага, албан тушаалтан хүлээлгэнэ;
- Зөрчил нь нийгмийн хор аюул, учруулсан хохирлын хувьд гэмт хэргийн шинжгүй байна;
- Зөрчлийн шийтгэл хүлээлгэх журмыг хуулиар тогтооно;
- Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байна.

Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд зөрчлийн шинжийг харгалзан энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийтгэл оногдуулна.

Баривчлах гэсэн нэр томъёоны хувьд авч үзвэл Арест буюу Arrestum /шүүхийн тогтоол/ гэсэн латин үг. Үгийн дээрх утгаас авч үзэхэд баривчлах гэдэг ойлголт нь хүний эрх, эрх чөлөөг ямар нэгэн хэлбэрээр хязгаарлаж, нийгмээс тусгаарлах гэсэн үг.

Баривчлах шийтгэлийн онцлог:

1.Зөрчил үйлдсэн хүнийг долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар тусгай зориулалтын байранд саатуулахыг баривчлах шийтгэл гэнэ.

Баривчлах шийтгэлийн агуулга нь зөрчил үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой нөхцөл, журам бүхий байранд саатуулахад оршино. Энэ шийтгэл нь нийгмээс тусгаарлах агуулгатай байдаг онцлогтой.

Хэдийгээр зөрчил үйлдэн баривчлах шийтгэлээр шийтгэгдсэн этгээд нь түр хугацаанд тусгаарлагдан хоригдож байгаа ч хэвлэл мэдээллийн хэрэгслэл үзэх, ашиглах, холбогдох зардлаа өөрөө хариуцах, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл түүрвх, өөрт холбогдох асуудлаар аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах, найз нөхөд болон өмгөөлөгчтэйгөө түр уулзах, захидал харилцаа, сонин сэтгүүл захиалах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зэрэг эрхээр бүрэн хангагдсан байдаг учраас нийгмээс бус олон нийтээс тусгаарлагдсан гэж ойлгох нь зүйтэй гэж үзэж байна.

2.Баривчлах шийтгэлийг шүүгч оногдуулна.

Шүүх баривчлах шийтгэлийг жирэмсэн эмэгтэй, арван дөрөв хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эх, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүнд оногдуулахгүй. Энэ тохиолдолд баривчлах шийтгэл нэг хоногийг арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тооцож торгох шийтгэл оногдуулж болно.


3.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үед саатуулагдсан хугацааг баривчлах шийтгэл эдлүүлэх хугацаанд оруулан тооцно.

Түүнчлэн баривчлах шийдвэр биелүүлэхийг хойшлуулж болно. Хэд хэдэн зөрчилд оногдуулсан баривчлах шийтгэлийн нийт хугацаа гурван сараас хэтрэхгүй байна.

4.Баривчлах шийтгэл эдлүүлэх журмыг хуулиар тогтооно.

Өнөөдрийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Баривчлах шийдвэр биелүүлэх журмаар зохицуулж байна.

Зураг 7. Шүүхээс 2004-2020 оны хооронд баривчлах шийтгэл оногдуулсан судалгаа



1.2.Баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагаатай холбоотой олон улсын болон үндэсний хууль тогтоомжид хийсэн шинжилгээ

Шүүхийн журмаар хүнийг баривчлах нь ямар ч улс орны хувьд хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны тухай асуудал хөндөгдөж байдаг эмзэг асуудал билээ. Судалгааны ажлын хүрээнд Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”, “Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц”¹⁰ гэсэн нийтлэг хэм хэмжээний хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль, Зөрчлийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Баривчлах байрны дотоод журмын хүрээнд харьцуулан судлан үзье.

Хүснэгт 6.Баривчлах шийтгэлд хамаарах Олон Улсын болон үндэсний хууль тогтоомжийн харьцуулалт

Д/д	Олон Улсын баримт бичигт туссан байдал	Үндэсний хууль тогтоомжид туссан байдал
1.	<p>Хүний эрхийн түгээмэл тунхаглал¹¹</p> <p>-3 дугаар зүйл “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй”.</p> <p>-5 дугаар зүйл “Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй”.</p> <p>-7 дугаар зүйл “ Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчилалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй”.</p> <p>-9 дүгээр зүйл “Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй.</p>	<p>Үндсэн хууль:</p> <p>Арван дөрөвдүгээр зүйл.</p> <p>1.Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.</p> <p>2.Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.</p> <p>Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:</p> <p>1/амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно;</p> <p>13/халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ.</p>

¹⁰ ХЭҮК.”Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол, шийдвэрийн эмхэтгэл” УБ.,2014.УБ

¹¹ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/А/III/ тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ.

		<p style="text-align: center;">Зөрчлийн тухай хууль:</p> <p>1.3 дугаар зүйл.Шударга ёсны зарчим 1.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байна.</p> <hr/> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль:</p> <p>4 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зарчим 4.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуульд зааснаар хязгаарлах, энэрэнгүй, шуурхай байх зарчмыг баримтална. 5 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл 5.1.Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна. 7 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага 7.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоож болно. 7.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч бусдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрийг нь доромжлох, албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцыг хууль бусаар ашиглах, зохих зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулахыг хориглоно.</p> <hr/> <p style="text-align: center;">Баривчлах байрны дотоод журам:</p> <p>1.3.Баривчлах шийтгэлийг эдлүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийг гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал,</p>
--	--	---

		шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүй байх зарчмыг баримтална.
2.	<p>Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт¹²</p> <p>-7 дугаар зүйл. Хэнд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно.</p> <p>-9 дүгээр зүйл.</p> <p>1.Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасч болохгүй.</p> <p>2.Баривчлагдсан шалтгааныг хүн бүрт баривчлах үед нь мэдэгдэхийн зэрэгцээ буруутгаж байгаа аливаа үндэслэлийг даруй мэдэгдэнэ.</p> <p>4.Баривчлагдаж эсхүл цагдан хоригдож эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр ийнхүү хорьж саатуулсан нь хууль ёсны эсэхийг шүүхээр даруй тогтоолгох, хууль бусаар хорьсон бол суллуулах шийдвэр гаргуулах эрхтэй.</p> <p>5.Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй.</p> <p>-10 дугаар зүйл</p> <p>1. Эрх чөлөөгөө хасуулсан бүх хүнтэй хүнлэг харьцаж, угаас заяасан нэр төрийг нь хүндэтгэнэ.</p> <p>2.(а) онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд буруутнаар татагдсан этгээдийг ял шийтгүүлсэн этгээдээс тусгаарлаж, шийтгэгдээгүй этгээдийн эрх зүйн байдалд тохирсон жич дэглэмд байлгана. (b) буруутнаар татагдсан насанд хүрээгүй этгээдийг насанд хүрсэн этгээдээс</p>	<p>Үндсэн хууль:</p> <p>13/халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй.</p>
	<p>Зөрчлийн тухай хууль:</p> <p>1.3 дугаар зүйл.Шударга ёсны зарчим</p> <p>1.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байна.</p>	<p>Зөрчлийн тухай хууль:</p> <p>1.3 дугаар зүйл.Шударга ёсны зарчим</p> <p>1.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байна.</p>
	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль:</p> <p>5.1.Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна.</p> <p>7.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч бусдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрийг нь доромжлох, албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцыг хууль бусаар ашиглах, зохих зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулахыг хориглоно.</p>	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль:</p> <p>5.1.Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна.</p> <p>7.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч бусдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрийг нь доромжлох, албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцыг хууль бусаар ашиглах, зохих зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулахыг хориглоно.</p>
<p>Баривчлах байрны дотоод журам:</p> <p>1.3. Баривчлах шийтгэлийг эдлүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүй байх зарчмыг баримтална.</p>	<p>Баривчлах байрны дотоод журам:</p> <p>1.3. Баривчлах шийтгэлийг эдлүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүй байх зарчмыг баримтална.</p>	

¹² Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200A(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон*.

	тусгаарлаж хэргийг нь аль болох богино хугацаанд шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлнэ.	
3.	<p>Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц¹³</p> <p>2 дугаар зүйл.</p> <p>1.Оролцогч улсууд харьяа нутаг дэвсгэртээ эрүүдэн шүүх аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй хууль тогтоох, захиргааны, шүүхийн болон бусад арга хэмжээг авна.</p> <p>10 дугаар зүйл.</p> <p>1.Оролцогч улсууд аливаа хэлбэрээр баривчлагдсан, саатуулагдсан, хоригдсон этгээдийг харгалзах, байцаах, харьцах, хууль сахиулах, энгийн, цэргийн болон эмнэлгийн бүрэлдэхүүн, төрийн албан тушаалтан, бусад хүмүүсийн сургалтад эрүүдэн шүүхийг хориглох тухай сургалтын материал, мэдээллийг бүрэн тусгана.</p> <p>2.Оролцогч улсууд ийнхүү хориглосон заалтыг аливаа этгээдийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны журам, зааварт тусгана.</p>	<p>Үндсэн хууль:</p> <p>13/халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй.</p>
		<p>Зөрчлийн тухай хууль:</p> <p>1.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд энэ хуулиар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.</p>
		<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль:</p> <p>7.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч бусдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрийг нь доромжлох, албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцыг хууль бусаар ашиглах, зохих зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулахыг хориглоно.</p>
		<p>Баривчлах байрны дотоод журам:</p>
4.	<p>Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц¹⁴ /1988 он/</p> <p>1 дүгээр зарчим. Аливаа нэг хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон бүх этгээд өөртэйгээ энэрэнгүй харьцах, хүний хувьд заяасан нэр хүндээ хүндэтгүүлэх эрх эдлэх ёстой.</p>	<p>Үндсэн хууль:</p> <p>2.Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.</p>
		<p>Зөрчлийн тухай хууль:</p> <p>2.Баривчлах шийтгэлийг шүүгч оногдуулна.</p> <p>3.Баривчлах шийтгэл эдлүүлэх журмыг хуулиар тогтооно.</p>

¹³ 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Нью-Йорк хотноо баталж, 1987 оны оны 6 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

¹⁴ Ерөнхий Ассамблейн 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 43/173 дугаар тогтоолоор батлав.

<p>2 дугаар зарчим. Баривчлах, саатуулах, түүнчлэн хорих ажиллагааг хуулийн заалтад чанд нийцүүлж эрх бүхий албан тушаалтан буюу хуулиар бүрэн эрх олгосон этгээд явуулах ёстой.</p> <p>4 дүгээр зарчим. Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийн эрхийг хөндсөн бүх арга хэмжээнүүд хийгээд аливаа хэлбэрээр саатуулах болон хорих ажиллагаа нь шүүхийн болон эрх бүхий бусад байгууллагын тогтоолоор хийгдэх бөгөөд тэдгээрийн үр нөлөөтэй хяналтад байх ёстой.</p> <p>6 дугаар зарчим. Саатуулагдсан буюу хоригдсон нэг ч хүнийг эрүүдэж шүүх буюу хэрцгий хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэж болохгүй.</p> <p>8 дугаар зарчим. Саатуулагдсан хүмүүсийг шийтгэгдээгүй хүмүүсийн байдалд тохирох дэглэмд байлгана. Үүнтэй холбогдуулан боломжтой үед тэдний хоригдож байгаа этгээдээс ямагт тусад нь байлгана.</p> <p>9 дүгээр зарчим. Бусдыг баривчилж, саатуулж эсхүл хэрэгт мөрдөн байцаалт явуулж байгаа албан тушаалтан буюу байгууллага зөвхөн хуулиар олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэх бөгөөд энэ бүрэн эрхийг хэрэгжүүлэх бөгөөд энэ бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон гомдлыг шүүхийн болон хуульд заасан бусад байгууллагад гаргаж болно.</p>	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль:</p> <p>7.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоож болно.</p> <p>7.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх тохиолдолд үндэслэлийг тухайн хүн, хуулийн этгээдэд мэдэгдэх, уг ажиллагаатай холбогдон үүсэх эрх, үүргийг тайлбарлах, хүндэтгэлтэй харьцах, өөрийн шаардлагыг үндэслэлтэй, ойлгомжтой хэлбэрээр илэрхийлэх үүрэгтэй.</p> <p>7.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч бусдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрийг нь доромжлох, албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцыг хууль бусаар ашиглах, зохих зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулахыг хориглоно.</p> <p>Баривчлах байрны дотоод журам:</p> <p>1.2.Баривчлах шийтгэлийг эдлүүлэх үйл ажиллагаанд Үндсэн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль Монгол Улсын олон улсын гэрээ, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон энэхүү журмыг удирдлага болгоно.</p>
--	---

Гадаадын зарим оронд захиргааны зөрчил гэж юу болох, түүнд ямар шийтгэл ногдуулдаг, шийтгэл ногдуулах, хяналт тавих процесс нь хэрхэн явагддаг талаар харьцуулсан судалгаа хийж үзлээ.

Нэг. Унгар улс

Унгар Улс 2012 онд Зөрчил, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хууль¹⁵ баталсан байна. Энэ хууль нь 31 бүлэг, 254 зүйлээс бүрдсэн ба уг хуулийн 1-5 дугаар бүлэгт зөрчлийн тухай ерөнхий зохицуулалт, 6-21 дүгээр бүлэгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны журам, 22 дугаар бүлэгт шийдвэр гүйцэтгэл болон зөрчлийн бүртгэлийн тогтолцооны талаарх зохицуулалт, 23-31 дүгээр бүлэгт бусад зөрчил буюу Зөрчлийн хуулийн тусгай ангийн зохицуулалтуудыг агуулжээ.

Унгар Улсын Зөрчил, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хуульд зааснаар “зөрчил гэж энэ хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно” гэж тодорхойлсон байна. Түүнчлэн энэ хуульд “Үндсэн хуульд заасан төр, нийгэм, эдийн засгийн тогтолцоог, мөн хувь хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн статусгүй байгууллагуудын эрх ашгийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх хэмжээнээс бага хэмжээгээр зөрчсөн, эсхүл аюул учруулж болзошгүй нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйд хэрэглэнэ” гэж тусгажээ.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаан дахь хөөн хэлэлцэх хугацаа 6 сар байна. Зөрчил үйлдсэнээс хойш 2 жил өнгөрсөн бол зөрчил үйлдсэн этгээдэд хариуцлага хүлээлгэхгүй.

Зөрчилд дараах төрлийн шийтгэл оногдуулдаг. Үүнд:

-баривчлах /1-60 хоног/;

-торгууль ногдуулах /5000-150000 форинт, хэрэв баривчлах шийтгэл оногдуулах хэмжээний зөрчил гаргасан бол 300000 форинт хүртэл/;

-нийтэд тустай хөдөлмөр хийлгэх /6-180 цаг/;

Зөрчлийн улмаас оногдуулсан шийтгэлийн ялтай байх хугацаа 2 жил байна. Энэ хугацаа нь давтан үйлдсэн зөрчилд хүндрүүлэх нөхцөл болдог. Үүнээс гадна эрх хасах, эд хөрөнгө хураах, хориглох, сануулах арга хэмжээ авах боломжтой байдлаар зохицуулсан.

Тус хуульд өсвөр насны хүүхэд, цэргийн алба хаагчдад хүлээлгэх шийтгэлийн төрөл, хэмжээг тусгайлан зохицуулсан.

Зөрчил гаргасан этгээдэд шийтгэл хүлээлгэх эрх бүхий байгууллага:

-нийслэл, аймгийн Засгийн газрын алба;

-хуулиар олгосон эрхийн хүрээнд Цагдаагийн байгууллага, Үндэсний татвар, гаалийн алба;

-захиргааны баривчлах шийтгэл оногдуулах зөрчилд орон нутгийн шүүх;

-хуулиар зөрчил үйлдсэн этгээдэд газар дээр нь торгууль ногдуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтны жагсаалтад орсон байгууллага, албан тушаалтан багтана.

Унгар Улсын зөрчил, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хуулийн 43 дугаар зүйлд зөрчилтэй холбоотой маргааныг шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын оролцоог зохицуулсан байна. Прокурор Зөрчлийн албаны үйл ажиллагаа, авч буй арга хэмжээ хууль тогтоомжид

¹⁵ 2012. évi II. törvény A szabálysértésekről, a szabálysértési eljárásról és a szabálysértési nyilvántartási rendszerről Эх цуввалж: http://net.jogtar.hu/jr/gen/hjegy_doc.cgi?docid=A1200002.TV

нийцэж байгаа эсэхийг шалгах, мөн зөрчлийн бүртгэлийн тогтолцоонд хууль ёсны хяналт тавьж ажилладаг.

Дээрх байгууллага прокуророос тавьсан шаардлага хууль зүйн үндэслэлтэй гэж үзсэн бол хууль тогтоомж зөрчсөн үйлдэл, шийдвэрийг өөрчлөх, буцаах арга хэмжээ авах ба энэ тухай прокурорт мэдэгдэх үүрэгтэй.

Хэрэв Зөрчлийн алба прокурорын шаардлагыг хангаагүй тохиолдолд прокурор 30 хоногийн дотор хүчин төгөлдөр шийтгэвэрийн эсрэг орон нутгийн шүүхэд хандах бөгөөд энэ тухайгаа Зөрчлийн албанд мэдэгдэнэ. Мэдэгдэл хүлээж авсан Зөрчлийн алба 8 өдрийн дотор хэргийн холбогдох материалыг харьяаллын дагуу шүүхэд хүргүүлнэ.

Баривчлах шийтгэл оногдуулах шаардлагатай зөрчил шалган тогтоох ажиллагааны анхан шатанд орон нутгийн шүүхийн харьяалалд багтана. Харин зөрчилтэй холбоотой хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг өргөн хэрэглэдэг.

Хоёр. Оросын Холбооны Улс

ОХУ-д Захиргааны зөрчил шалган шийдвэрлэх журмыг Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуулиар¹⁶ зохицуулдаг. Хууль нь 2001 оны 12 дугаар сарын 20-нд Төрийн Думаар ёсчлогдон 2001 оны 12 дугаар сарын 26-ны өдөр ОХУ-ын зөвлөлөөр батлагдсан байна. Уг хууль нь ОХУ-ын Үндсэн хууль болон олон улсын хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, олон улсын гэрээнд үндэслэх бөгөөд хэрэв захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль олон улсын гэрээ, бусад дүрэмд нийцээгүй бол олон улсын хэм хэмжээ, дүрмийг баримтлана хэрэглэнэ гэж тусгагджээ. ОХУ 2016 онд Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуульдаа шинэчилсэн найруулга хийж 32 бүлэг, 32 заалттай болсон. Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуулийн зорилт нь иргэн, хүний эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, эрүүл ахуй, нийтийн ёс суртахуун, байгаль орчныг хамгаалах, төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд тогтоосон журам гаргах, нийгмийн аюулгүй байдал, эд хөрөнгө, төр нийгэм, хуулийн этгээд, хүний хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

Уг хуулийн 4 дүгээр зүйлд дараах үндсэн зарчмуудыг тусгажээ. Үүнд:

1. Захиргааны эрх зүйн зөрчил гаргасан этгээдэд хариуцлага оногдуулахдаа Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуульд заасан журмыг баримтлах;

2. Иргэнд захиргааны шийтгэлийг иргэнд оногдуулахдаа түүний санхүүгийн чадавхи, гэм буруугийн шинж байдал зэргийг харгалзан хариуцлагыг хүндрүүлэх болон хөнгөрүүлэх;

3. Захиргааны зөрчилд оногдуулах шийтгэлийг хуулийн этгээдэд хүлээлгэхдээ хуулийн этгээдийн хөрөнгө болон санхүүгийн байдал, зөрчлийн гэм буруугийн шинжийг харгалзан хариуцлагыг хүндрүүлэх эсхүл хөнгөрүүлэх;

4. Захиргааны эрх зүйн нэг зөрчилд нэг хариуцлага хүлээлгэх.

Захиргааны зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын оролцоог Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.7 дахь заалт болон Прокурорын тухай хуулиар зохицуулсан байна. Прокурорын тухай хууль нь

¹⁶ ОХУ-ын Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль. 2001 он

1992 оны 1 дүгээр сарын 17-нд батлагдсан бөгөөд тус хуульд Прокурор эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шаардлагыг тогтоосон хугацаанд заавал биелүүлэх үүрэгтэйг онцолсон байна¹⁷. Прокурорын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-т заасны дагуу прокурор болон түүний орлогч захиргааны зөрчил үйлдэгдсэн нь тогтоогдсон тохиолдолд дараахь арга хэмжээг хэрэгжүүлдэг. Үүнд:

-шүүх байгууллагын шийдвэрийн үндсэн дээр бус хууль бусаар захиргааны баривчлагдсан этгээдийг суллах;

-хуулийн зөрчлийг арилгах тухай санал оруулах гэх мэт.

ОХУ-ын Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуульд орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон төлөөллийн байгууллагууд хариуцагчаар татагдах боломжтой. Дээрх байгууллагуудын шийдвэр, үйл ажиллагаа хууль зөрчсөн бол иргэн прокурорт мэдэгдэх эрхтэй. Прокурор уг асуудлыг шалгаж үзээд үндэслэлгүй нь тогтоогдвол зөрчлийг нэн даруй арилгах шаардлага хүргүүлдэг байна. Уг шаардлагыг биелүүлэх хугацааг прокуророос тогтоох бөгөөд орон нутгийн байгууллага 10 хоногийн дотор прокурорын шаардлагыг хэлэлцэн хариу мэдэгдэнэ. Прокурорын санал гаргасан өдрөөс сарын хугацаанд хуульд заасан зөрчлийг /шалтгаан, нөхцөл/ арилгахаар тодорхой арга хэмжээ авч, түүнийг прокурорт мэдэгдэх үүрэгтэй. Мөн прокурор хуулийн этгээд болон албан тушаалтанд дахин зөрчил гаргахгүй байх талаар бичгээр сануулга өгдөг.

Захиргааны эрх зүйн зөрчилтэй холбоотой хэргийг байгууллага, албан тушаалтаны шалгах хугацаа 15 хоног байна. Шүүхээс захиргааны эрх зүйн зөрчилтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэх хугацаа 2 сар байх бөгөөд оролцогчдоос хүсэлт гаргавал нэмэлт мэдээлэл, нотлох баримт цуглуулах зорилгоор шүүгч 1 сар хүртэл хугацаагаар сунгаж болно. Хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл зөрчил үйлдэгдсэнээс хойш 60 хоногийн дотор эрх бүхий этгээдийн дээд шатны байгууллага болон шүүхэд хандана.

Захиргааны зөрчилд хариуцлага оногдуулах эрх бүхий этгээд нь байцаагч байна. Байцаагч нь дотроо Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын байцаагч, Хөдөлмөрийн байцаагч, Замын эргүүлийн алба, Насанд хүрээгүй хүүхдийн хэргийн байцаагч, Байцаагчийн комисс, Москва хотын захиргааны замын байцаагч, Дансны төлөлтийн байцаагч, Улсын галын албаны байцаагч, Ажлын албаны байцаагч гэх мэт үйл ажиллагааны чиглэлээр ажиллана.

Улсын байцаагч болон цагдаагийн албан хаагч тухайн захиргааны зөрчил гаргасан этгээд, хуулийн этгээдэд торгуул бусад албадлагын арга хэмжээ ноогдуулж тус арга хэмжээг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн тохиолдолд дээд шатны байгууллага болон албан тушаалтанд хандаж тус шийтгэвэрийн хуудсыг хэвээр үлдээсэн бол захиргааны хэргийн дагнасан шүүхэд гомдол гаргана. Тус шүүхийн гаргасан тогтоол өмнөх байгууллага, албан тушаалтны процесс ажиллагаатай адил шийдвэр гаргавал харьяалах дээд шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

Прокурор ахлах байцаагчийн гаргасан тогтоол, шийдвэрт захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль, бусад хуулийг зөрчсөн эсэхэд ахлах байцаагч, бусад дээд албан байгууллага, анхан шатаар шийдэгдсэн шийдвэрийг давж заалдаж болно.

¹⁷ ОХУ-ын Прокурорын тухай хуулийн 9.1, 22, 27, 30, 33 дугаар зүйл

Зөрчилд шийтгэл оногдуулсан шийдвэрт давж заалдах шатны шүүхэд гомдол гаргахад дараах дарааллыг баримтална. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид уг хуулийн 25.2-25.5 дугаар зүйлд хохирогч, иргэний болон хуулийн этгээдийн төлөөлөгч, өмгөөлөгч, гэрчийн хүсэлтээр прокурор дараах байдлаар давж заалдаж болно. Үүнд:

-Шүүгчийн шийдвэрийг дээд шатны шүүхэд;

-Хамаарал бүхий этгээд (collegiate body) харьяалах дүүргийн шүүхэд дамжуулах;

-Байцаагчийн гаргасан шийдвэрийг дээд албан (superior body) тушаалтан эсхүл харьяалах дүүргийн шүүхэд;

-ОХУ-ын хуультай холбоотой бусад этгээдийн шийдвэрийг тухайн харьяалах шүүхийн шийдвэрийг тус тус давж заалдаж болно гэж заасан. Тухайлбал, байцаагчийн гаргасан шийдвэрийг дүүргийн шүүхэд давж заалдаж болно. Дүүргийн шүүхийн шийдвэрт гомдолтой бол дээд шүүхэд (upper court), бүс нутгийн шүүх болон бусад хамаарагдах шүүхэд заалдаж болно. Харин бүс нутгийн шүүх болон бусад хамаарах шүүхийн шийдвэрийг дахин заалдах боломжийг хуульд нарийвчлан тусгаагүй байна. ОХУ-ын Москва хотын шүүх, Мужийн шүүх, Хязгаарын шүүх, Республикийн дээд шүүхүүдэд Дээд шүүх, Автономит мужийн, Автономит тойргийн шүүх, эсэргүүцэл гаргах, гомдол өгч болно.

Албаны этгээд /байцаагч/, дээд шатны албан тушаалтны гаргасан тогтоолтыг зөрчил гаргагч хүн зөвшөөрөхгүй бол харьяалагдах шүүх, дээд шатны шүүхэд гомдолоо гаргаж болно. Шүүхэд гаргасан гомдлыг шүүхэд ирсэн өдрөөс 1 сарын дотор хянаж шийдвэр гаргана. Зөрчлийн хуулийн 30.2 дугаар хэсэгт зааснаар зөрчлийн хэргийн шийдвэрийг дээд шүүх, ахлах байцаагч, болон зөрчил хянан шийдвэрлэх шүүхээр давж заалдана. Шүүгчийн зөрчлийн шийтгэл оногдуулсан шийдвэрийг тухайн давж заалдах өдөртөө дээд шүүхэд өргөн барьж болно. Зөрчлийн шийтгэл оногдуулсан шийдвэрийг Зөрчлийн 30.5 дугаар зүйлд заасан хугацаан дотор давж заалдана. Иргэн, хуулийн этгээд зөрчлийн шийдвэрийг хүлээн авсан хоногоос 10 хоногийн дотор давж заалдаж болно.

Гурав. Бүгд Найрамдах Казахстан улс

БНКУ нь 2014 оны 07 дугаар сарын 05-ны өдөр 53 бүлэг, 920 зүйл анги бүхий "Захиргааны эрх зүйн зөрчил"-ийн тухай хуулийг баталж, 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан. БНКУ-ын "Захиргааны эрх зүйн зөрчил"-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлд энэ хуулийн зорилгыг тодорхойлсон байх ба "Иргэн, хувь хүний хууль ёсны ашиг сонирхол, эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, эрүүл аюулгүй орчинд амьдрах баталгааг хангах, байгаль орчин, нийгмийн ёс суртахуун, хуулийн этгээдийн ашиг сонирхол, хуулиар баталгаажуулсан эрхийг хамгаалах, төрийн байгууллага, эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм журмыг дагаж мөрдүүлэх, нийгмийн аюулгүй байдлыг хангах, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуулиар захиргааны хариуцлагад тооцох үндэслэл, зарчмыг тогтоох, ямар үйлдлийг зөрчилд тооцох, зөрчил гаргасан этгээдэд ямар төрийн байгууллага, албан тушаалтан, ямар шийтгэлийг, ямар журмаар оногдуулах асуудлыг зохицуулдаг. Тухайлбал, уг хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх

хэсэгт “Захиргааны шийтгэл гэж зөрчил гаргасан этгээдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах болон зарим эрхийг хасах тухай хууль тогтоомжоор олгогдсон эрх бүхий байгууллага, албан тушаалтан, шүүхийн зүгээс авч хэрэгжүүлж буй албадлагын арга хэмжээ мөн” гэж заасан. Мөн захиргааны шийтгэл нь зөрчил гаргасан этгээдийг хүмүүжүүлэх, хууль журмыг сахих, хүндэтгэх байдлыг дээшлүүлэх, зөрчил гаргагч болон бусад этгээдийг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн байх ба хувь хүн, хуулийн этгээдийн нэр хүндэд халдах, доромжлох, бие махбодь, сэтгэл санааны хохирол учруулах зорилго агуулахгүй гэж заажээ.

Тус улсын Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль дахь зарим онцлог заалтаас дурдахад, энэ хуулийн 74 дүгээр зүйлд Бүгд Найрамдах Казахстан улсын иргэншлийг авахад саад учруулсан албан тушаалтан хуулийн этгээдийн хууль бус үйлдэл, эс үйлдэлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний тенгегээр торгууль ногдуулдаг. Харин энэ үйлдлээ 1 жилийн хугацаанд давтан үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 60 дахин нэмэгдүүлэх хэмжээний тенгегээр торгодог. Харин хуулийн 73 дугаар зүйлд гэр бүлийн харилцаан дахь зарим хууль бус үйлдлийг зөрчилд тооцохоор тусгасан бөгөөд тухайлбал, “хүнийг зүй бусаар хараах, басамжлан доромжлох, гэрийн эд хогшлыг эвдэж сүйтгэсэн, гэр бүл ахуйн харилцаанд гарсан, тэдний амгалан тайван байдлыг алдагдуулсан, хүндэтгэлгүй хандсан зэрэг эрх зүйн зөрчил гаргасан этгээдэд, хэрэв энэ үйлдэл нь гэмт хэргийн шинж агуулаагүй 3 хүртэлх хоногийн хугацаанд захиргааны баривчилгаанд татдаг, хэрэв энэ үйлдлээ 1 жилийн дотор давтан үйлдвэл 10 хоног баривчилдаг бол 2-оос дээш удаа энэ төрлийн зөрчил гаргасан этгээдэд хөдөлмөрийн хөлсний сарын доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү тенгегээр торгууль ногдуулах шийтгэл оногдуулдаг” байна.

Захиргааны зөрчилтэй холбогдуулан гаргасан шийдвэр хувь хүн, хуулийн этгээдийн Бүгд Найрамдах Казахстан улсын Үндсэн хууль болон бусад хуулиар баталгаажсан хууль ёсны ашиг сонирхол, эрхийг зөрчсөн гэж үзвэл тухайн шийдвэрийн аль нэг хэсгийг эсхүл бүхэлд нь давж заалдах боломжтой ба өргөдлөө шүүхэд гаргана.

Захиргааны зөрчил гаргасан этгээдэд хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу дараах төрлийн шийтгэл оногдуулахаар хуульчилсан байна. Үүнд:

1. Сануулах;
2. Торгох /хувь хүнд нэг өдрийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 23 500 дахин, албан тушаалтанд 700 дахин, аж ахуйн нэгжид 1000 дахин, томоохон хуулийн этгээдэд 2000 дахин нэмэгдүүлсэн хэмжээтэй дүйцэхүйц хэмжээний торгууль ногдуудаг/;
3. Зөрчил үйлдсэний үр дүнд олж авсан эд хөрөнгө, эд мөрийн баримт эсхүл зөрчил үйлдсэн зүйлийг хураан авах;
4. Зөрчил гаргахад хэрэглэсэн эд зүйл, багаж хэрэгслийг хураан авах;
5. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх хасах /1 сараас 2 жил хүртэл/;
6. Тусгай зөвшөөрөл хураах, тодорхой үйл ажиллагаа явуулахыг зогсоох /6 сар хүртэл хугацаагаар/, данс битүүмжлэх;
7. Үйл ажиллагаа эрхлэхийг хориглох эсвэл зогсоох /10 хоног хүртэл/;

8. Хууль бусаар барьсан болон баригдаж байгаа барилгыг албадан буулгах;

9. Захиргааны баривчилгаа /30 хоног хүртэл/, баривчилгааны хугацааг 3 цагаас хэтрэхгүй хугацаагаар сунгаж болно гэж заасан.

Үүнээс үзэхэд захиргааны эрх зүйн зөрчил гаргасан этгээдэд оногдуулсан хамгийн хүнд шийтгэл нь захиргааны баривчилгаа бол хуулийн этгээдийн хувьд их хэмжээний торгууль ногдуулах эсхүл үйл ажиллагааг нь зогсоох, зарим тохиолдолд тодорхой үйл ажиллагаа явуулах лиценз, эд хөрөнгө хураах зэрэг зохицуулалт оруулсан байна.

Прокурор нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх ажиллагаа хуулийн тогтоомжийн хүрээнд хийгдэж байгаа эсэхийг шалгадаг. Прокурор зөрчил илрүүлээд протокол /тогтоол/ үйлдсэний дараа 3 хоногийн хугацаанд, байгууллага, албан тушаалтай хүнд, шүүх бичгээр авч үзэж хянуулах, зөрчлийг арилгуулахаар явуулна. Захиргааны эрх зүйн зөрчил гаргасан этгээдийн гэм буруутай үйлдлийн тухай өөрийн саналаа эрх бүхий байгууллага байгууллага, шүүхэд бичнэ.

Прокурор өөрийн санаачлагаар захиргааны эрх зүйн зөрчил гаргасан хувь хүн, хуулийн этгээдэд хэрэг үүсгэдэг. Прокурорт гомдлоо тогтоосон хугацаанд гаргаж прокурорын хяналтын ажиллагааны үед захиргааны шийтгэл оногдуулах үйл ажиллагааг түр түдгэлзүүлнэ. Зөрчлийн хэрэгт нэмэлт шалгалт явуулах зорилгоор тусгай эрх бүхий албан тушаалтан, байгууллагад бичгээр хандах, прокурорын хууль ёсны шалгалтын үед захиргааны шийтгэл оногдуулах тухай тогтоол гүйцэтгэх ажиллагааг зогсоох эрхтэй байдаг. Шалгалтын үр дүнгээр зохих байгууллагад эсэргүүцэл бичих, тогтоолыг цуцлах, өөрчлөх зэрэг эрх хэмжээтэй байна.

Захиргааны эрх зүйн зөрчилтэй холбоотой прокурорын гаргасан тогтоолыг эс зөвшөөрвөл дээд шатны прокурорт 3 хоногийн дотор гомдол гаргадаг. Захиргааны эрх зүйн зөрчлийн хэрэгт БНКУ-ын Ерөнхий прокурор, түүний орлогч, аймгийн прокурор, түүнтэй адилтгах прокурор хяналтын журмаар шалгалт явуулахаар шүүгчид шаардлага хүргүүлж болно.

Захиргааны эрх зүйн зөрчлийн (827 дугаар зүйл) хэргийг хөтөлж, шийдвэр гаргах байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэлд дээд шатны байгууллага, албан тушаалтан, дүүргийн болон түүнтэй адилтгах захиргааны дагнасан шүүхэд гомдол мэдүүлж болно. Эрх бүхий албан тушаалтан гаргасан шийдвэрийнхээ үндэслэл, баримтыг нотлох үүрэг хүлээнэ. Шийдвэр гаргасан албан тушаалтанд өөрийн гаргасан шийдвэрт холбогдох гомдлыг авч хянуулахаар даалгахыг хориглоно.

Хууль ёсны ашиг сонирхол, эрх зөрчигдсөн өдрөөс хойш 2 сарын дотор гомдлоо дээд шатны байгууллага, шүүхэд хандах эрхтэй. Захиргааны эрх зүйн зөрчилд татагдсан этгээдийг баривчлах, прокурор хэрэг үүсгэх тогтоол гаргах, хэргийн оролцооны үеэс өмгөөлөгч ямар ч шатанд хууль ёсны эрхийг хамгаалах зорилготой орж болно.

Хүний гэм буруутай үйлдлийг нь нотолж чадаагүй байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийн улмаас учирсан хохирлоо барагдуулах асуудлаар албан ёсны уучлал бичгээр гүйж шийдвэр гаргана. Сэтгэл санааны хохирол

учруулсан тохиолдолд хохирлыг мөнгөн хөрөнгөөр нөхөн төлөх бөгөөд энэ тухай нэхэмжлэлийг иргэний хэрэг шүүн таслах ажиллагааны журмаар явуулна. Шүүх, байгууллага, албан тушаалтны гэм буруутай үйлдлээс болж учирсан хохирлыг БНКУ-ын төсвөөс гаргана.

Төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, шийдвэр Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, хэм хэмжээний эрх зүйн актыг зөрчсөн гэж үзвэл түүнд эсэргүүцэл бичнэ. Прокурорын эсэргүүцлийг календарны өдрийн 10 хоногийн хугацаанд байгууллага, албан тушаалтан хянаж үзэх ёстой. Тогтоосон хугацаанд прокурорын тогтоолыг гүйцэтгээгүй бол хуулиар заасан хариуцлага хүлээнэ. Прокурор хуульд заасан бусад тохиолдолд захиргааны эрх зүйн зөрчлийг арилгах хэрэг үүсгэн шалгалт явуулж болно.

Дүүргийн, түүнтэй адилтгах захиргааны хэргийн төрөлжсөн шүүгч захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хэргийг шалгаж хянадаг. Дүүрэг хоорондын төрөлжсөн шүүхийн шүүгч насанд хүрээгүй хүүхдийн хэргийг хуулийн 435, 436.3, 438.3, 440.4-5 442.3, 448 заалтуудаар хянадаг. Төрийн байгууллага, албан тушаалтан шүүгчийн тогтоолд заасан хугацаанаас илүү хууль бусаар баривчилсан этгээдийг нэн даруй суллах үүрэгтэй. Захиргааны эрх зүйн зөрчлийн оролцогчдын хэнийг ч гутаан доромжлох, эрүү шүүлт тулгаж болохгүй.

Байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрч шүүхэд гомдол гаргаж болно. Тус шүүхийн шийдвэр мөн адил гарсан тохиолдолд давж заалдах шатны шүүхэд хандах эрх нь нээлттэй. Захиргааны баривчилгаа 30 хоног хүртэлх хугацаатай байна. Мөн онц байдал зарласан үед 45 хоног хүртэлх хугацаагаар баривчилж болно. Захиргааны баривчилгааг 14 нас хүрээгүй хүүхэдтэй эх, жирэмсэн эмэгтэй, 18 нас хүрээгүй хүүхэд, 1-2 зэрэглэлийн хөгжлийн бэрхшээлтэй хүн, 58 наснаас дээш насны эмэгтэй хүн, 60 настай эрэгтэй хүнд хэрэглэж болохгүй. Захиргааны түр саатуулах хугацааг захиргааны баривчилгааны хугацаанд тооцно.

Дөрөв. Гүрж улс

Гүрж улсын парламентаас Захиргааны зөрчлийн тухай хуулийг 1985 онд баталжээ. Уг хууль нь 5 хэсэг, 32 бүлэг, 314 зүйлээс бүрдэнэ. Захиргааны зөрчлийн тухай хуулийн зорилт нь эд хөрөнгө, нийгэм, эдийн засаг, улс төрийн болон иргэдийн эрх ашиг, эрх чөлөө, аж ахуйн нэгж, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад нийгмийн хэв журмыг сахих, иргэний эрх ашгийг хүндэтгэх явдал болно.

Олон улсын байгууллагын зүгээс Гүрж улсын Захиргааны зөрчлийн тухай хуулийн зарим зохицуулалтад ихээхэн шүүмжлэлтэй ханддаг байна. Энэ нь Хүний эрхийн тухай европын конвенцийн 6 дугаар зүйлд заасан "шударгаар шүүлгэх эрх"-ийн талаар хуульд тодорхой тусгаагүйтэй холбоотой.

Зөрчил гаргасан болон гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шалган шийдвэрлэх процесс ижил төстэй хуульчлагдсан нь ял оногдуулах ажиллагааны процессын ялгамжтай байх зарчимд үл нийцсэн гэж үзэж байжээ. Өөрөөр хэлбэл жижиг зөрчил

үйлдсэн этгээдийг эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн эдгээдтэй ойролцоо түвшинд шалгах явдал¹⁸ нь зөрчил гаргагчийн эрхийг дордуулж байгаа гэж тайлбарласан байна.

Гүрж улс 2014 онд Захиргааны зөрчлийн тухай хуульдаа шинэчлэл хийж олон шинэлэг зохицуулалтыг нэвтрүүлсэн байна. Энэ хүрээнд өмнө зөрчил гаргасан этгээдэд цагдан хорих хугацаа 90 хоног байсныг 15 хоног болгон өөрчилсөн зэрэг олон улсын эрх зүйн зарчимд нийцсэн эерэг хандлагатай хууль болсон гэж үнэлэгдэх болжээ.

Захиргааны зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд прокурорын оролцоо ямар байх талаар хуульчилсан. Захиргааны зөрчлийн тухай хуулийн 238 дугаар зүйлд зааснаар прокурор захиргааны зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавих¹⁹ бөгөөд хэргийн материалтай танилцах, эрх бүхий албан тушаалтны оногдуулсан арга хэмжээнд хуулийн дагуу хяналт тавих, захиргааны зөрчлийн талаарх шүүхийн шийдвэрт гомдол гаргах, эсэргүүцэл бичих зэрэг хуульд заасан бусад үүргийг хэрэгжүүлнэ. Мөн захиргааны зөрчлийг шалгах явцад гэмт хэргийн шинжтэй болох нь тогтоогдвол холбогдох материалыг прокурорын байгууллага болон мөрдөн байцаах байгууллагад шилжүүлнэ.

Гүрж улсын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 272 дугаар зүйлийн 272.1 дэх хэсэгт эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг давж заалдах журмууд доорх байдлаар тусгасан. Үүнд:

-Иргэн захиргааны зөрчил оногдуулсан шийдвэр давж заалдах гомдол, прокурор эсэргүүцэл бичиж болно. Гомдол, эсэргүүцлийг шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор тухайн эрх бүхий албан тушаалтнаар дамжуулан дээд шатны албан тушаалтанд гаргана.

-Эрх бүхий албан тушаалтан захиргааны шийтгэлийг өөрчилсөн тохиолдолд уг шийдвэрийг дээд албан тушаалтанд эсвэл дүүргийн (хотын) шүүхэд давж заалдаж болох ба тухайн шийдвэр эцсийн байна.

-Эрх бүхий албан тушаалтан захиргааны шийтгэлийг анхааруулах хэлбэрээр мөн илтгэх хуудас бичилгүйгээр оногдуулсан тохиолдолд дээд шатны албан тушаалтанд давж заалдаж болно. Эрх бүхий албан тушаалтан захиргааны шийтгэлийг өөрчилсөн тохиолдолд уг шийдвэрийг дээд албан тушаалтанд эсвэл дүүргийн (хотын) шүүхэд давж заалдаж болох ба тухайн шийдвэр эцсийн байна.

-Захиргааны зөрчилтэй холбоотой гаргасан шийдвэрийг тухайн шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргаж болно. Энэ тохиолдолд 3 хоногийн дотор тухайн давж заалдаж буй албан тушаалтанд шийдвэрийг бусад бичиг баримтын хамт илгээх үүрэгтэй.

-Хэрэв захиргааны торгууль оногдуулсан шийдвэрийг давж заалдаж байгаа тохиолдолд төлбөр авах зохицуулалттай. Торгох шийтгэлийн хувьд захиргааны зөрчлийн шийдвэр гарснаас хойш 10 хоногийн дотор давж заалдаж болно.

Гомдол, эсэргүүцэл бичих явцад эрх бүхий албан тушаалтнаас шалтгаалан хуулиар тогтоосон хугацаа хэтэрсэн бол хугацааг дахин сэргээж тогтоодог байна. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 251 дүгээр зүйлд баримт бичиг хураах,

¹⁸ Зөрчил гаргасан этгээдийг 90 хүртэл хоног цагдан хорих эрхтэй байна.

¹⁹ Administrative Offences of Code of Georgia, Article 238

нэгжлэг хийх, баривчлан саатуулсан тохиолдолд энэ талаар эрх ашиг нь зөрчигдсөн этгээд прокурор, эсхүл удирдах албан тушаалтанд давж заалдах гомдол гаргаж болдог.

Прокурорын эсэргүүцлийг шүүх хуралд авч хэлэлцэх хүртэл захиргааны зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг түр түдгэлзүүлнэ. Прокурорын эсэргүүцлийг хэлэлцсэний дараа захиргааны зөрчлийн шийдвэрийг 7 хоногийн дотор хохирогч болон прокурорт мэдэгдэнэ.

Гүрж улсад захиргааны зөрчлийг дүүргийн захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэнэ. Гүржийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн дагуу дүүрэггүй зохион байгуулалттай хотод хотын шүүх, дүүрэгтэй хотод дүүргийн шүүх байна. Давж заалдах шатны шүүх нь дүүргийн, мужийн шүүхийн шийдвэртэй холбогдсон гомдлыг давж заалдах шатны журмаар хянан хэлэлцэнэ. Мөн зөрчлийн хэрэг зохицуулах дотоод хэргийн байгууллагууд (agencies of internal affairs), улсын мэргэжлийн хяналтын байгууллага (state inspection agencies) болон эрх бүхий албан тушаалтан (officials) тухайн зөрчлийг шийдвэрлэнэ.

Захиргааны зөрчлийн хэрэг болох хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, аж үйлдвэр, эрчим хүчний үйлдвэр, аж ахуй, нэгжийн үйл ажиллагааны захиргааны зөрчлийн хэрэг дүүргийн (хот) шүүхэд хамаарна. Тээврийн хэрэгслийн жолооч замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм зөрчих, тусгай хамгаалалттай газрын захиргааны зөрчлийг дотоод хэргийн байгууллагад хэлэлцдэг. Нутгийн өөрөө удирдах газрын нийтийн тав тухтай байдлыг хангах, барилгын материал хог хаягдлыг устгах, далайн боомтын ачаа ачих, буулгах, хадгалахтай холбоотой захиргааны зөрчлийг Нутгийн өөрөө удирдах байгууллага тус тус хэлэлцдэг.

Захиргааны зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 279 дүгээр зүйлд захиргааны зөрчил шалган шийдвэрлэх шүүх болон удирдах албан тушаалтанд (superior agency of internal affairs) давж заалдах бүрэн эрхтэй байхаар тусгажээ. Прокурорын эсэргүүцлээр эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг дээд шатны албан тушаалтанд давж заалдаж болно.

Дээд шатны албан тушаалтны шийдвэрийг дүүргийн шүүхэд, дүүргийн шүүх хэлэлцсэн шийдвэрийг давж заалдах шатны шүүхэд гаргах бөгөөд анхан шатны шүүхийн шийдвэр хууль ёсны дагуу эсэхийг шалгаж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана. Үүнд: Зөрчил оногдуулсан шийдвэрийг хүчингүй болгох, хэвээр үлдээх, өөрчлөх зэрэг багтана. Дүүргийн шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол 30 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд хандана. Давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байна.

Дээрх улс орнуудын эрх зүйн зохицуулалтын хувьд дараах нийтлэг шинж байна, үүнд, зөрчил гаргасан этгээдийн эрх чөлөөнд халдах буюу баривчлах шийтгэл оногдуулах асуудлыг зөвхөн шүүх шалган тогтоох, шийдвэр гаргах эрхтэй байна. Прокурор зөрчилтэй холбоотой гаргасан шийдвэрт ерөнхий хяналт тавих, шаардлагатай тохиолдолд зөрчлийн албанаас гаргасан шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх асуудлаар давж заалдах шатны байгууллагад мэдэгдэл, хүсэлт гаргах эрхтэй. Үүнээс гадна зөрчлийн бүртгэлийн тогтолцоонд хяналт тавих

үүрэгтэй, мөн шуудан, харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан илгээсэн илгээмж, захидал хураан авах зөвшөөрөл олгох эрхтэй байна.

Дэлхийн ихэнх оронд гэмт хэргийн шинжтэй ихэнх үйлдэлд 1-60 хоногийн хугацаатай баривчлах ялыг оногдуулж байгаа нь захиргааны шинжтэй зөрчилд оногдуулсан баривчлах шийтгэлтэй адилтгаж ойлгож болохоор байна.

ХОЁР.БАРИВЧЛАХ ШИЙТГЭЛИЙГ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ /2015-2020 /

2.1.Баривчлах байрны чиг үүрэг, хэрэгжилтэд хийсэн шинжилгээ

Монгол Улсад эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхээс гаргасан шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгуулан хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд биелүүлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6.4-т Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараахь шийдвэрийг үндэслэн явуулна:

6.4.1.торгох шийтгэл оногдуулсан шүүгчийн шийтгэх хуудас;

6.4.2.зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, тээврийн хэрэгсэл, уналгыг хураах, эсхүл түүний үнийг гаргуулан хураан авах тухай шийдвэр;

6.4.3.хохирол, нөхөн төлбөр гаргуулах тухай шийдвэр;

6.4.4.албадан эмчилгээ, албадан сургалтад хамруулах тухай шүүхийн шийдвэр;

6.4.5.баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэр;

6.4.6.гадаадын иргэнийг саатуулах тухай шүүхийн шийдвэр;

6.4.7.шүүхээс гүйцэтгэх хуудас олгосон бусад байгууллага, албан тушаалтны зөрчлийн хэргийн талаархи шийдвэр гэж заажээ.

Эндээс үзэхэд баривчлах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хүрээнд багтаж байна.

Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь дараах онцлог шинжтэй байдаг.Үүнд:

1.Шийтгүүлсэн этгээд зөрчлийн хэргийн талаархи хуулийн хүчин төгөлдөр шийдвэрийг хууль болон шийтгэл, албадлагын арга хэмжээ оногдуулах тухай шийдвэрт өөрөөр заагаагүй тохиолдолд даруй биелүүлэх үүрэгтэй.

2.Зөрчлийн хэргийн талаархи шийдвэрийг шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтан, хэрэв шүүх гаргасан бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэтгэнэ.

3.Зөрчлийн хэргийн талаархи шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бол тухайн шийдвэрийг гаргасан байгууллага, албан тушаалтан гүйцэтгэх ба шийдвэр гүйцэтгэгчийн эрх эдлэхгүй.

4.Шийтгүүлсэн этгээдэд холбогдуулан гарсан хэд хэдэн шийдвэрийг тус тусад нь гүйцэтгэнэ.

5.Зөрчлийн тухай хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр оногдуулсан баривчлах шийтгэлийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэтгэнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дараах нийтлэг шаардлага тавигддаг.

А.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, үзэл

бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоож болно.

Б.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх тохиолдолд үндэслэлийг тухайн хүн, хуулийн этгээдэд мэдэгдэх, уг ажиллагаатай холбогдон үүсэх эрх, үүргийг тайлбарлах, хүндэтгэлтэй харьцах, өөрийн шаардлагыг үндэслэлтэй, ойлгомжтой хэлбэрээр илэрхийлэх үүрэгтэй.

В.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч бусдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрийг нь доромжлох, албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцыг хууль бусаар ашиглах, зохих зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулахыг хориглоно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хууль ёсны шаардлагыг хүн, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй ба үл биелүүлсэн, эсхүл хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан хүн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Баривчлах байрны бүтэц, тогтолцоо, чиг үүрэг:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төв нь үйл ажиллагаандаа Үндсэн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль Монгол Улсын олон улсын гэрээ, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон Баривчлах байрны дотоод журмыг удирдлага болгоно.

Шүүхийн шийтгэврээр оногдуулсан баривчлах шийтгэлийг нийслэлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын харьяа "Баривчлах төв"-д, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын харьяа "Баривчлах байр"-д эдлүүлж байна. Баривчлах төв нь хуулийн этгээдийн эрх эдэлнэ.

Баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагаа нь дараах онцлог шинжтэй байна.

1.Шийтгэлийн зорилгоос хамааран баривчлах байрны чиг үүрэг нь тодорхойлогдож байна. Тухайлбал, Зөрчлийн тухай хуульд зааснаар "шийтгэлийн зорилго нь хүн, хуулийн этгээдийг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, зөрчил үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, шударга ёсыг тогтооход оршино" гэжээ. Шийтгэлийн зорилготой уялдан баривчлах шийтгэл эдлүүлэх ажиллагааны зорилго нь:

-дахин зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх

-зөрчил үйлдсэн этгээдэд хуулиар тогтоосон нөхцөл, журам бүхий тусгай зориулалтын байранд саатуулах

-нийгэмшүүлэх болон цээрлүүлэх арга хэмжээний зохистой харьцааг тогтоох зэрэг байна.


Эцсийн дүнд нийгэмд шударга ёсыг тогтоон, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн ардчилсан нийгмийн үнэт зүйлийг төлөвшүүлэхэд оршиж байна.

2.Баривчлах шийтгэлийг зөвхөн зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулсан шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр оногдуулж байна.

3.Баривчлах шийтгэлийг хуулиар эрх олгогдсон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон Цагдаагийн байгууллага гүйцэтгэж байна.


ШШГЕГ-ын харьяа Баривчлах төвд 2015-2020 оны хооронд шүүхээс оногдуулсан баривчлах шийтгэл эдлүүлсэн хүний тоог авч үзвэл, 2015 онд-6278, 2016 онд-3031, 2017 онд-5159, 2018 онд-4356, 2019 онд 7815 хүн шийтгэл эдэлсэн байна.

Зураг 8. Баривчлах төвд 2015-2019 оны хооронд саатуулагдсан этгээдүүдийн судалгаа




Дээрх баривчлагдсан этгээдүүдийг хүйсийн байдлаар нь судлан үзвэл дийлэнх нь эрэгтэй хүн байх ба эмэгтэйчүүдийн эзлэх хувь нь 2015 онд-8%, 2016 онд-6%, 2017 онд-5%, 2018 онд-5%, 2019 онд-4,5% нь байжээ.

Зураг 9. Баривчлах төвд 2015-2019 онд саатуулагдсан этгээдүүдийн хүйсийн судалгаа




Түүнчлэн сүүлийн 3 жил 15 улсын 70 иргэн саатуулагдсан байна.

Зураг 10. Гадаад улсын харьяат саатуулагдсан этгээдүүдийн тоон үзүүлэлт




Зураг 11. Саатуулагдсан этгээдүүдийн харьяат улсын судалгаа




Баривчлах төвд насанд хүрээгүй 2015 онд-15, 2016 онд-0, 2017 онд-18, 2018 онд-28, 2019 онд-42 хүн шийтгэл эдэлсэн байна.

Зураг 12. Баривчлах төвд 2015-2020 оны хооронд саатуулагдсан насанд хүрээгүй этгээдийн судалгаа



Зөвхөн 2019 онд баривчлах шийтгэл эдэлсэн Улаанбаатар хотын харьяат 7815 этгээдийг дүүргээр нь ангилан авч үзвэл Баянзүрх дүүргийн харьяат 2466 буюу 31.5%, Сонгинохайрхан дүүргийн харьяат 1286 буюу 16.4%, Баянгол дүүргийн харьяат 980 буюу 12.5%, Хан-Уул дүүргийн харьяат 1055 буюу 13.4%, Сүхбаатар дүүргийн харьяат 910 буюу 11.6%, Чингэлтэй дүүргийн харьяат 844 буюу 10.7%, Багануур дүүргийн харьяат 182 буюу 2.02%, Багахангай дүүргийн харьяат 7 буюу 0.08%, Налайх дүүргийн харьяат 85 буюу 1.8%-ийг эзэлж байна.


Зураг 13. Баривчлагдсан Улаанбаатар хотын харьяат иргэдийн дүүргийн судалгаа /2019 он/



2019 онд баривчлах шийтгэл эдэлсэн этгээдийг харьяаллаар нь хувааж үзвэл Налайх, Багахангай, Багануур, Хан-Уул, Баянзүрх дүүргээс 4020 буюу 51.4%, Сонгинохайрхан, Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй дүүргээс 3795 буюу 48.6%-ийг эзлэж байна.


Судалгааны явцад баривчлагдсан 452 этгээдээс урьд баривчлах шийтгэл эдэлж байсан эсэх талаар судалгаа авахад 363 хүн буюу 80,3% нь урьд баривчлагдаж байгаагүй, 89 хүн буюу 19,6 нь өмнө баривчлах шийтгэл эдэлж байсан хүмүүс байлаа.

Зураг 14. Баривчлагдсан этгээдүүдийн давтан баривчлагдсан талаарх судалгааны дүн



Судалгаанд оролцогчдын үйлдсэн захиргааны зөрчилийн төрлөөр нь ангилан авч үзвэл 329 буюу 72,7% нь гэр бүлийн хүчирхийлэл, 50 буюу 11,6% нь замын хөдөлгөөний дүрэм зөрчих, 26 буюу 5,7% нь хулгайлах, 23 буюу 5% нь танхайрах, 14 буюу 3,0% нь олон нийтийн газарт зүй бусаар авч явах буюу мансуурах болон бусад зөрчил үйлдсэн хүмүүс байв.


Зураг 15. Судалгаанд оролцогчдийн үйлдсэн зөрчлийн судалгаа



Түүнчлэн судалгаанд хамрагдсан 452 этгээдийн баривчлах шийтгэлийн үр нөлөөг та хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуултад 247 хүн буюу 54,6 ямар ч үр


нөлөөгүй, 144 хүн буюу 31,8% нь дунд зэрэг, 61 хүн буюу 13,4% нь сайн үр нөлөөтэй байна гэж хариулжээ.

Зураг 16.Баривчлагдсан этгээдээс авсан баривчлах шийтгэлийн үр нөлөөнд хийсэн судалгааны дүн



Баривчлах төвд ажиллаж буй 41 алба хаагчаас баривчлах шийтгэлийн үр нөлөөг та хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуултад 31 алба хаагч буюу 75,6% баривчлах шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдох хууль тогтоомжийг өөрчлөх шаардлагатай, 9 алба хаагч буюу 21,9% нь ямар ч үр нөлөө алга, сайн үр нөлөөтэй гэж үзсэн алба хаагч байхгүй байна.

Зураг 17.Алба хаагчаас авсан баривчлах шийтгэлийн үр нөлөөнд хийсэн судалгааны дүн



2.2.Баривчлагдсан этгээдийн эрх зүйн байдалд хийсэн шинжилгээ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Баривчлах байрны дотоод журамд баривчлагдсан этгээдийн эрх зүйн байдлыг тогтоож өгчээ.

Нэг. Баривчлагдсан этгээдийн эрх, үүрэг:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 146.1-т “Баривчлагдсан этгээд нь баривчлах шийтгэл эдлэх хугацаандаа баривчлах байрны захиргаа, түүний алба хаагчийн хяналтад байх бөгөөд энэ хуулийн 210.1.1, 210.1.2, 210.1.3, 210.1.5, 210.1.9, 210.1.10, 210.1.11, 210.1.12, 210.1.13, 210.1.15-д заасан эрх эдэлж, энэ хуулийн 211 дүгээр зүйлд заасан үүрэг хүлээнэ” гэжээ.

Хүснэгт 7.Баривчлагдсан этгээдийн эрх, үүрэг холбогдох хууль, журамд туссан байдал

д/д	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгагдсан байдал	Баривчлах байрны дотоод журамд туссан байдал
<i>Нэг. Баривчлагдсан этгээдийн эрх /хоригдлын эрх/:</i>		
1.	210.1.1.хорих ял эдлэх нөхцөл, журам, эрх, үүрэг, хязгаарлалтын талаар мэдээлэл авах; 210.1.2.хорих ангийн захиргаагаар дамжуулан өөрт холбогдох асуудлаар аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах; 210.1.3.өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авах; 210.1.5.эмнэлгийн тусламж авах; 210.1.9.хорих байгууллагын алба хаагч, эрх бүхий албан тушаалтны зүгээс хүнлэг харьцах, эсхүл хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилж харьцахгүй байхыг шаардах; 210.1.10.хувийн аюулгүй байдлаа хамгаалуулах; 210.1.11.өөрөө зөвшөөрсөн эсэхээс үл хамааран эрүүл мэндэд нь эрсдэл учруулж болзошгүй аливаа туршилтаас ангид байх; 210.1.12.энэ хуульд заасан журмын дагуу зөвшөөрөгдсөн тоо, хэмжээний хоол, хүнсний бүтээгдэхүүн, ахуйн болон нэн тэргүүний бусад зүйл худалдан авах; 210.1.13.шашны зан үйл үйлдэх; 210.1.15.хуваарилагдан очсон хорих ангийн байршил, холбоо барих мэдээллийн талаар гэр бүлийн гишүүнд мэдэгдэх.	Зургаа.Баривчлагдсан хүний эрх, үүрэг 6.1.Баривчлагдсан хүн дараах эрхийг эдэлнэ: 6.1.1.баривчлах төв /байр/-ийн нөхцөл, журам, өөрийн эрх, үүргийн талаар мэдээлэл авах; 6.1.2.хувийн аюулгүй байдлаа хамгаалуулах; 6.1.3.баривчлах төв /байр/-ийн ахуй нөхцөл, бусад асуудлаар гомдол, хүсэлт гаргах; 6.1.4.хууль, эрх зүйн туслалцаа авах; 6.1.5.эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах; 6.1.6.ахуйн хэрэгцээний эд зүйл худалдан авах; 6.1.7.хориглосноос бусад ном, сонин сэтгүүл, хэвлэл ашиглах;
<i>Хоёр.Баривчлагдсан этгээдийн үүрэг /хоригдлын үүрэг/:</i>		
2.	211.1.Хоригдол дараахь үүрэг хүлээнэ: 211.1.1.хорих ангид мөрдөх хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн эрх бүхий албан тушаалтнаас баталсан дүрэм, журам, хорих байгууллага, алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг заавал биелүүлэх; 211.1.2.хорих байгууллагаас тогтоосон цагийн хуваарьт үйл ажиллагааг мөрдөх;	6.2.Баривчлагдсан хүн дараах үүрэг хүлээнэ: 6.2.1.баривчлах төв /байр/-ийн дотоод журмыг чанд сахин мөрдөх; 6.2.2.албан хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

<p>211.1.3.хорих байгууллагын алба хаагчаас даалгасан ажлыг заавал гүйцэтгэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журмыг чанд сахих;</p> <p>211.1.4.тогтоосон журмын дагуу зохион байгуулж байгаа сургалтад хамрагдах;</p> <p>211.1.5.эрүүл мэндээ хамгаалах, эмчийн зөвлөгөө, шаардлагыг биелүүлэх, хуурамчаар болон санаатайгаар өвчилсөн, эрүүл мэнд, бие эрхтэндээ гэмтэл учруулсан бол холбогдох зардлыг төлөх;</p> <p>211.1.6.эзэмшиж байгаа эд хөрөнгө, хөдөлмөрийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглах, эвдэж гэмтээхгүй байх;</p> <p>211.1.7.гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд уриалах, өдөөн хатгах, зохион байгуулах идэвхтэй үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байх;</p> <p>211.1.8.хорих байгууллагын алба хаагч, эрх бүхий албан тушаалтан, бусад хоригдол болон хорих байгууллагад байгаа бусад хүнтэй хүндэтгэлтэй харьцах;</p> <p>211.1.9.эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг сахих.</p> <p>211.2.Хорих ангид суулт хийх, өлсгөлөн зарлах, хоригдол хөдөлгөөнт утас ашиглах, хадгалах болон бэлэн мөнгө, валют, үнэт зүйл ашиглах, хадгалахыг хориглоно.</p> <p>211.3.Хоригдол энэ хуульд заасан эрхээ эдлэхдээ энэ хууль, хорих ангийн дотоод журам болон бусад хоригдол, хорих ангийн алба хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх үүрэгтэй.</p> <p>211.4.Хорих ял эдэлж байгаа гадаадын иргэн энэ зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээхийн зэрэгцээ гадаад хэргийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын консулын асуудал хариуцсан нэгжээр дамжуулан өөрийн улсын Дипломат төлөөлөгчийн газрын ажилтантай уулзах, харилцах эрхтэй.</p>	<p>6.2.3. эрүүл ахуй, ариун цэвэр сахих;</p> <p>6.2.4.өөрт эзэмшүүлсэн эд зүйлсэд ариг гамтай хандах;</p> <p>6.2.5.зохион байгуулж буй сургалтанд тогтмол хамрагдах;</p>
--	--

Дээрхээс хүснэгтээс харахад баривчлагдсан этгээдийн эрх, үүргийг хоригдолтой адилтгасан нь ойлгомжгүйгээр барахгүй, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан хоригдлын эрхийг эдлэх боловч дахин Баривчлах байрны дотоод журмаар мөн адил эрх эдлэх нь тодорхойгүй байдал үүсгэж байна.

Хоёр.Баривчлах байрны ахуй нөхцөл:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 147 дугаар зүйлийн 147.1."Баривчлагдсан этгээд нь Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 24.1, 24.4-д заасан ахуйн хангамжаар, энэ


хуулийн 231.6-д заасан хэмжээний илчлэгтэй хоол, хүнсний зүйл болон хувцас, хэрэгцээтэй үедээ хэрэглэх ундны усаар хангагдана” гэж заажээ.

Хүснэгт 8.Баривчлах байрны ахуй нөхцөл холбогдох хууль, журамд туссан байдал

<p>Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд туссан байдал</p>	<p>Баривчлах байрны дотоод журамд туссан байдал</p>
<p>24.1.Хоригдсон этгээд нь ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөл, унтаж амрах боломжоор хангагдана.</p> <p>24.5.Хоригдсон этгээд нь аллага, хүчирхийлэл, садар самууныг сурталчилснаас бусад ном, сонин, сэтгүүлийг хорих өрөөндөө байлгаж болно.</p>	<p>2.2.Баривчлах төв /байр/ нь агааржуулах төхөөрөмжтэй байх ба байгалийн болон ердийн гэрэлтүүлэгтэй, салхивчтай байна.</p> <p>2.3.Баривчлах төв /байр/-д нэг хүнд ноогдох зай талбайн хэмжээ нь 2.5м²-с багагүй байна.</p> <p>Долоо.Баривчлагдсан хүний ахуй хангамж, үйлчилгээ</p> <p>7.1.Баривчлагдсан хүний бие, өрөөнд дараах эд зүйл байлгахыг зөвшөөрнө:</p> <p>7.1.1.тухайн улирлын хувцас.дотуур хувцас;</p> <p>7.1.2.ариун цэврийн хэрэгсэл /оо, сойз, гар нүүрийн болон эдийн саван, алчуур, сахлын машин, жижиг хэмжээтэй 1 үйлдэлтэй хумсны хутга, нүүр, гарын тос, хуурай, нойтон салфетка, ариун цэврийн цаас, эмэгтэй хоригдлын хувьд ариун цэврийн хэрэглэл, гоо сайхны хэрэгсэл/;</p> <p>7.1.3.хучлага, гудас, ор хөнжлийн даавуу;</p> <p>7.1.4.эрүүл ахуйн шаардлага хангасан хоёр килограмм хүртэлх гурилан бүтээгдэхүүн;</p> <p>7.1.5.эмчийн бичгээр зөвшөөрсөн мансууруулах, тайвшруулахаас бусад эм /тоо, ширхэг, нэрийг дурьдсан байна/-ийг сувилагчид хадгалуулан, шаардлагатай үед жорын дагуу авч хэрэглэх;</p> <p>7.1.6.аллага, хүчирхийлэл, садар самууныг сурталчилснаас бусад сонин, ном, сэтгүүл 5-с дээшгүй, тэмдэглэлийн дэвтэр, хуванцар гадартай тосон бал тус бүр 1 ширхэг;</p> <p>7.2.Энэ журмын 7.1-д зааснаас бусад эд зүйлсийг баривчлагдсан хүний бие болон өрөөнд байлгахыг хориглоно.</p> <p>7.3.Баривчлах төв /байр/ нь эрүүл ахуйн шаардлага хангасан нийтийн халуун усны өрөөтэй байна.</p> <p>7.4.Баривчлагдсан хүнийг долоо хоногт нэг удаа усанд орох боломжоор хангана.</p> <p>7.5.Халуун усанд ороход шаардагдах ариун цэврийн хэрэгсэл/ савангаас бусад/-ийг баривчлагдсан хүн өөрөө хариуцана.</p> <p>7.6.Баривчлагдсан хүний өөрийнх нь хүсэлтээр буюу ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын дагуу түүний үсийг засна;</p> <p>7.7.Баривчлагдсан хүнд олгож буй хучлага, гудас, ор дэвсгэрийн хэрэгслийг угааж, ариутгасан байна.</p> <p>7.8.Энэ журмын 7.1.3-т зааснаас бусад эд зүйлийг баривчлагдсан хүн өөрөө хариуцна.</p>


Судалгаанд оролцсон 452 баривчлагдсан этгээд баривчлагдан этгээдийн эрхийг хангах ажлыг та хэрхэн дүгнэж байна вэ? гэсэн асуултанд 228 хүн буюу 50,4% нь сайжруулах шаардлагатай, 146 хүн буюу 32,3% нь муу, 78 хүн буюу 17,2% нь хангалттай сайн гэж хариулжээ.

Зураг 18. Баривчлагдсан этгээдүүдээс авсан эрхийн баталгааны чиглэлээрх судалгааны дүн



Судалгаанд оролцсон 452 баривчлагдсан этгээд баривчлах байрны нөхцөл, журам таны хэрэгцээ шаардлагыг хангаж байна уу? гэсэн асуултанд 151 хүн буюу 33,4% нь муу, 78 хүн буюу 17,2% нь сайн, 223 хүн буюу 49,3% нь хангахгүй байна гэж хариулжээ.

Зураг 19. Баривчлагдсан этгээдүүдээс авсан баривчлах байрны нөхцөл, журмын талаарх судалгааны дүн




Гурав. Баривчлагдсан этгээд бусадтай харилцах:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 146.3-т "Баривчлагдсан этгээд 7 хоногт нэг удаа 1 цаг хүртэл хугацаагаар бусадтай уулзалт хийж, нэг удаа илгээмж авч, нэг удаа захидал илгээж болно", 146.4-т "Баривчлагдсан этгээд өдөрт 1 цагаас доошгүй хугацаагаар гадаалах, биеийн тамирын дасгал хийх болон 7 хоногт нэг удаа 5 минутаас ихгүй хугацаагаар утсаар ярьж болно", холбогдох зардлыг өөрөө хариуцна гэжээ.

Баривчлагдсан хүн нь ажлын 5 хоногт 1 удаа, 1 цагаас ихгүй хугацаагаар бусадтай уулзах, 1 удаа илгээмж авах, 1 удаа захидал илгээж болно. Нийгмийн ажилтны зөвшөөрлөөр 7 хоногт 1 удаа 5 минутаас ихгүй хугацаагаар утсаар ярьж

болно. Уулзалтыг баривчлах төв /байр/-ийн даргын баталсан хуваарийн дагуу дарга, дэд даргын зөвшөөрлөөр ээлжийн даргын хяналтад зохион байгуулна. Баривчлагдсан хүн нь 1 цагаас дээшгүй хугацаагаар гэр бүлийн гишүүн, найз нөхөдтэйгээ уулзаж болох бөгөөд харуул хамгаалалтын ажилтан байнгын хяналт тавих ба хориотой эд зүйл дамжуулахыг хориглоно. Харуул хамгаалалтын ажилтан нь уулзалтаар хүлээн авсан эд зүйлд үзлэг хийж, энэ журмаар зөвшөөрсөн эд зүйлийг баривчлагдсан хүнд хүлээлгэн өгөх, зөвшөөрснөөс бусад эд зүйлсийг уулзалтаар ирсэн хүнд буцаан өгч, тэмдэглэл үйлдэнэ.

Зураг 20. Баривчлагдсан этгээдүүдээс 2015-2019 онд ар гэртэйгээ түр уулзалт хийсэн судалгаа



Баривчлах төв /байр/-ийн даргын баталсан хуваарийн дагуу баривчлагдсан хүнийг өдөрт 1 цагаас багагүй хугацаагаар гадаалуулж, биеийн тамирын дасгал хийлгэх ба хэт халуун, хүйтэн зэрэг цаг агаарын хүндрэлтэй үед гадаалуулах эсэхийг төв /байр/-ийн дарга шийдвэрлэнэ.

Дөрөв. Баривчлагдсан этгээдийн цай, хоол:

Баривчлагдсан хүнд өдөрт 2 удаа халуун хоол, гурван удаа цай, нэг удаа гурилан бүтээгдэхүүн өгөх бөгөөд баривчлагдсан нэг хүнд ногдох хоногийн хоолны илчлэг нь 2800 килокалориос багагүй, 0.5 литр байх ба хэрэгцээт үедээ уух ундны усаар хангагдана. Баривчлагдсан хүнд хоногт олгож буй хоолны дээжийг улирал тутамд шинжилгээнд өгч, илчлэгийг тодорхойлуулах бөгөөд хууль тогтоомжид заасан хэмжээнд хүрээгүй бол нэмэгдүүлэх арга хэмжээ авна. Хоолны илчлэг тодорхойлуулсан баримтыг Баривчлах төв /байр/-ийн санхүүд хадгална.

Эмч нь хоол бэлтгэх, боловсруулах, олгох явц, хүнсний хадгалалт, хамгаалалт, гал тогоо, хоолны хэрэгслийн ариун цэвэр, цэвэрлэгээ, эрүүл ахуйн шаардлагад өдөр тутам хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, хоолны дээжийг хадгалан, 72 цагийн дараа бүртгэл хөтлөн устгана. Албаны тогооч нь хоолны орц, амт чанар, түүнчлэн баривчлагдсан хүн бүрт хоол олгогдож байгаа эсэхэд хяналт тавих ба хамгаалалтын ажилтнууд хоол олгох үед байлцана. Баривчлах төв /байр/-ийн, гал тогоонд баривчлагдсан хүнд нэг өдөрт олгогдох хүнсний орц, 7 хоногийн хоолны цэсийг ил байрлуулдаг байна.

Баривчлах төв болон байрны захиргаанаас дараах төрлийн төлбөрт үйлчилгээг баривчлагдсан хүнд үзүүлж болно. Үүнд:

1. төлбөрт өрөөнд байрлуулах;

2.захиалгаар хоол, хүнсний бүтээгдэхүүн, ариун цэвэр, ахуйн хэрэглээний зүйлс, ном, сонин, сэтгүүл зэргийг худалдаалах.

Судалгаанд оролцсон 452 баривчлагдсан этгээд баривчлах байрны хоолны чанар, хүртээмжийн шаардлагыг тань хангаж байна уу? гэсэн асуултанд 31 хүн буюу 6,8% нь хүртээмжтэй сайн, 174 хүн буюу 38,4% нь сайжруулах шаардлагатай, 247 хүн буюу 54,6% нь муу гэж хариулжээ.


Зураг 21.Баривчлагдсан этгээдээс авсан хоолны чанар, хүртээмжийн талаарх судалгааны дүн



Тав.Баривчлагдсан этгээдийн гаргасан гомдол, хүсэлтийг хянан шийдвэрлэсэн байдал:

Баривчлагдсан хүн нь баривчлах төв /байр/-ийн нөхцөл байдал болон алба хаагчдын зан, харилцааны талаар гомдол, хүсэлт гаргаж болно. Баривчлах төв /байр/-ийн нийгмийн ажилтан нь гомдол, хүсэлт гаргасан хүнтэй биечлэн уулзаж, энэ талаар төв /байр/-ийн даргад танилцуулж, шийдвэрлүүлнэ.

Зураг 22.Баривчлагдсан этгээдүүдээс авсан алба хаагчдын харьцааны талаарх судалгаа



ШШГЕГ-ын харьяа Баривчлах төвийн захиргаанд баривчлагдсан этгээд, тэдний ар гэрээс гаргасан өргөдлийг судлан үзэхэд 2015 онд баривчлагдсан этгээд-25, ар гэр-18, нийт 43, 2016 онд баривчлагдсан этгээд-2, ар гэрээс-5, нийт 7, 2017 онд баривчлагдсан этгээд-6, ар гэр-23, нийт 19, 2018 онд баривчлагдсан этгээд-240, ар гэр-15, нийт 255, 2019 онд баривчлагдсан этгээд-154, гэр бүлийн гишүүдээс-29, нийт 183 өргөдөл, хүсэлт гаргасан байна.

Зураг 23.Баривчлах шийтгэл эдлүүлэхтэй холбоотой гаргасан өргөдлийн судалгаа /2015-2019/



2.3.Баривчлагдсан этгээдүүдийн дунд явуулж буй нийгэмшүүлэх болон зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд хийсэн шинжилгээ

ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/129 тоот тушаалаар баталсан “Нийгмийн ажлын аргачилсан заавар”-т зааснаар хорих байгууллагын нийгмийн ажил гэж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 219 дүгээр зүйлийн 219.1 дэх хэсэгт зааснаар хоригдол нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход нь дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг хэлнэ гэжээ. Дээрх тодорхойлолтоос харахад энэхүү заавар нь зөвхөн гэмт хэрэг үйлдэн хорих ял шийтгэгдэн хорих ял эдэлж буй хоригдолд хамаарахаар байна.

Баривчлах байр, төв буюу баривчлагдсан этгээдийн дунд явуулах нийгэмшүүлэх ажил нь зан үйлд нөлөөлөх сургалт болон сэтгэл зүйн үйлчилгээ гэсэн үндсэн чиглэлийн хүрээнд явагдана.

Зөрчлийн хуулийн тусгай ангид өөрөөр заагаагүй бол шүүх баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэн хүнд албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно. Албадан сургалтыг баривчлах шийтгэлийг эдэлж байх хугацаанд эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ. Албадан сургалт **арван цагаас тавин цагийн** хугацаатай байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 147 дугаар зүйлийн 147.5-т Баривчлах байр нь баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулна гэжээ. Баривчлах байрны дотоод журамд зааснаар баривчлах төв /байр/ нь сургалтын танхимтай байх бөгөөд шүүхийн шийтгэвэрт заасан хугацаагаар албадан сургалтад хамруулна, сургалт нь баривчлагдсан хүний зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх бөгөөд хөтөлбөрийн дагуу явагдана, сургалтыг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болохоор заасан байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн А/73 тоот тушаалийн хавсралтаар батлагдсан “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр”, “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам”-ын хүрээнд баривчлах байранд албадан сургалтыг зохион байгуулж байна.

Хүснэгт 9.Зан үйлд нөлөөлөх сургалтын үйл ажиллагааны харьцуулалт

д/д	Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх арга зам
Нэг. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам:		
1.	Журмын зохицуулах харилцаа:	Энэхүү журмаар хорих ял болон захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдэд албадан сургалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.
2.	Албадан сургалтын зорилго, чиглэл:	Албадан сургалт нь шийтгэл хүлээсэн этгээдийн зан үйлд нөлөөлөх, гэмт хэрэг, зөрчил давтан үйлдэхээс урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийг ойлгуулахад чиглэсэн байна.
3.	Албадан сургалтын	Нийслэлд захиргааны журмаар шийтгэл хүлээсэн этгээдэд

	зохион байгуулалт:	Баривчлах төв, орон нутагт захиргааны журмаар шийтгэл хүлээсэн этгээдэд Цагдаагийн байгууллага тус тус зохион байгуулна. Сургалт хариуцсан ажилтан, багш шийтгэл хүлээсэн этгээдийн зөрчлийн шинж байдлаас хамаарч сургалтын төлөвлөгөөг боловсруулах бөгөөд Баривчлах төв, Цагдаагийн байгууллагын нэгжийн дарга баталж, хяналт тавина.
4.	Албадан сургалтын төрөл, хугацаа:	Албадан сургалт нь дараах төрөлтэй байна: 1.ганцаарчилсан; 2.бүлгийн; 3.бусад. Албадан сургалтын 1 цагийг 60 минутаар тооцох бөгөөд үргэлжлэх хугацаа нь өдөрт 4 цагаас дээшгүй, долоо хоногт 16 цагаас доошгүй байна.
5.	Албадан сургалтад тавигдах шаардлага	Албадан сургалт дараах шаардлагыг хангасан байна: 1.ганцаарчилсан болон бүлгийн сургалт явуулах танхимтай байх; 2.оролцогчдыг сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан байх; 3.бясалгалын өрөөтэй байна. Оролцогчийн үйлдсэн гэмт хэрэг, зөрчлөөс хамаарч албадан сургалтыг ялгамжтай байдлаар зохион байгуулна.
6.	Албадан сургалтад хамрагдах оролцогчийн эрх, үүрэг	Албадан сургалтад хамрагдах оролцогч дараах эрх эдэлнэ: 1.сургалтын үргэлжлэх хугацаа, ач холбогдлын талаар мэдээлэл авах; 2.сургалттай холбоотой ном, сэтгүүлийг авч ашиглах; 3.гадаадын иргэн, харааны болон сонсголын бэрхшээлтэй этгээдийн хүсэлтээр хэлмэрч, орчуулагчийг оролцуулах; Албадан сургалтад хамрагдах оролцогч дараах үүрэг хүлээнэ: 1.албадан сургалтын журмыг дагаж мөрдөх; 2.албадан сургалтын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандаж, сургалтад бүрэн хамрагдах; 3.сургалтын ажилтан, алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх 4.сургалтын хэрэглэгдэхүүнийг зориулалтын дагуу ашиглах. 5.оролцогч дахин гэмт хэрэг, зөрчил гаргавал түүнээс үүдэн гарах үр дагавар, хор уршгийн талаар ойлголт эзэмшүүлсэн байх.
7.	Сургалтын ажилтны эрх, үүрэг	Сургалтын ажилтан нь дараах эрхийг эдэлнэ: 1.сургалтад оролцогчдод хууль ёсны шаардлага тавих; 2.албадан сургалтад хамрагдаж буй этгээдийг үнэлж, дүгнэх; 3.аюулгүй байдлаа хангуулах. Сургалтын ажилтан нь дараах үүрэг хүлээнэ:

		<p>1.сургалтыг хөтөлбөрийн хүрээнд батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулах;</p> <p>2.албадан сургалтад хамрагдсан оролцогчийн үнэлгээ, сургалт явуулсан тухай тайланг хорих анги, баривчлах төв, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нэгжийн даргад тус тус хүргүүлнэ;</p> <p>3.албаны болон оролцогчийн хувийн мэдээллийг бусдад задруулахгүй байх;</p> <p>4.оролцогчтой хувийн харилцаа тогтоохгүй байх;</p> <p>5.албадан сургалт дууссаны дараа оролцогчоос сургалтын талаарх санал авах;</p>
8.	Байгууллагын эрх, үүрэг	<p>Эрх бүхий байгууллага нь дараах эрх, үүрэг хүлээнэ:</p> <p>1.сургалтын орчин бүрдүүлж, аюулгүй байдлыг хангах;</p> <p>2.оролцогчдыг албадан сургалтад бүрэн хамруулах;</p> <p>3.оролцогч үүргээ биелүүлээгүй бол холбогдох арга хэмжээг авах;</p> <p>4.сургалтын талаар нэгдсэн тоо бүртгэл хөтөлж, сургалтын тайлан мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлнэ;</p> <p>5.сургалтын талаар гадаад, дотоод байгууллагатай харилцах</p>
9.	Албадан сургалтад хамруулах	<p>Эрх бүхий байгууллагын ажилтан /нийгмийн ажилтан, сэтгэл зүйч сургалтын ажилтан/ албадан сургалтад хамрагдах шийтгэл хүлээсэн этгээдийг 24 цагийн дотор бүртгэлд хамруулж, түүнд сургалтад хамрагдах талаар танилцуулж, баталгаажуулна. Сургалтын ажилтан албадан сургалтад хамрагдах шийтгэл хүлээсэн этгээдийн сургалтад хамрагдаж буй байдал, түүний оролцоо, ирцийн талаар тэмдэглэл үйлдэнэ. Албадан сургалтыг шүүхээс оногдуулсан шийтгэл, ялын хугацаанд багтаан явуулна.Албадан сургалтад хамрагдах оролцогчийн талаарх бүртгэлийг нийслэлд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, Баривчлах төв, аймаг, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн Цагдаагийн байгууллага хариуцан хөтөлнө.</p>
10.	Албадан сургалтад хамруулж дууссанд тооцох	<p>Сургалтын ажилтан дараах үндэслэлээр албадан сургалтад хамруулж дууссанд тооцно:</p> <p>1.шүүхээс тогтоосон цагийн албадан сургалтад хамрагдсан;</p> <p>2.албадан сургалтад хамрагдах шийтгэл хүлээсэн этгээд нас барсан,</p> <p>3.гэмт хэрэг үйлдэж, шүүхийн шийтгэх тогтоол гарсан;</p>
11.	Хүлээлгэх хариуцлага	<p>Албадан сургалтыг хэрэгжүүлж буй алба хаагч энэхүү журмыг зөрчсөн бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Цагдаагийн байгууллагын тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>Албадан сургалтад хамрагдах шийтгэл хүлээсэн этгээд албан тушаалтны хууль ёсны шаардлага, шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй бол Зөрчлийн тухай хуульд /Захиргааны харицлагын тухай хууль/ заасны дагуу</p>

		хариуцлага хүлээлгэнэ. Сургалт явуулах байгууллага, албан тушаалтан гэрээнд заасан үүргийг биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцална.
Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр:		
1.	Хөтөлбөрийн үндэслэл	Захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдэд албадан сургалт явуулах, эрхийг нь хязгаарласан орчинд сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэсэн сургалтыг зохион байгуулж, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх нь нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцэх болно.
2.	Хэрэгцээ, шаардлага	Захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийн зан үйл, сэтгэл зүйн чиг хандлагад нөлөөлөх, дахин хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хариуцлагатай, ухамсарт иргэн болж төлөвшүүлэх, хүмүүжүүлэхийн тулд зан үйлд нөлөөлөх хөтөлбөр боловсруулж, сургалт явуулах шаардлагатай.
3.	Зорилго	Захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн тогтвортой байдал, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, өөрийгөө тайвшруулах чадвартай, амьдралын эерэг хандлага, зөв дадал, бодол санаатай иргэн болгон төлөвшүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.
4.	Удирдлага, зохион байгуулалт	Хөтөлбөрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын харьяа нэгжүүд хариуцан зохион байгуулна. Сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллаж болох ба дээрх байгууллагууд нь хорих ял болон захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийг сургах нөхцөлөөр ханган, тэдэнд дэмжлэг үзүүлж, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сургалтад идэвхтэй оролцуулах үүргийг тус тус гүйцэтгэнэ.
5.	Сургалтын хөтөлбөрийн зорилт	Хөтөлбөрийн зорилгыг хангах ажлын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. 1. оролцогчийн зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулах; 2. шүүхээс албадан сургалтад хамруулахаар заасан хугацааг харгалзан сургалтыг явуулах; 3. албадан сургалт явуулах орчин нөхцөлийг бүрдүүлэх; 4. сургалт явуулах алба хаагчдыг мэргэшүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиг үүрэг бүхий алба хаагчдын ур чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн сургалтад тус тус тогтмол хамруулах; 6. оролцогчид сэтгэл зүйн болон амьдрах ухааны боловсрол олгон зөв бодол санаа, өөрийгөө хөгжүүлэх чадвартай, эерэг сэтгэлгээтэй болгох;

		<p>7.сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, амьдралын эрүүл хэв маяг, хэм хэмжээг төлөвшүүлэх;</p> <p>8.сургалтын явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах.</p>
6.	Сургалтын алсын хараа	<p>Сургалтын алсын хараа нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, тогтоомжоор хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц байна. Үүнд:</p> <p>1.сургалтын үйл ажиллагаа бодит үр дүнтэй байх;</p> <p>2.сургалтыг явуулах алба хаагч нь мэдлэг чадвартай, мэргэшсэн байх;</p> <p>3.алба хаагчийн мэдлэгийг ур чадвар болгон хувиргах замаар байгууллагын ажлыг тодорхой үр дүнд хүргэх.</p> <p>4.Сургалтад хамрагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх замаар гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх.</p>
7.	Сургалтын хэлбэр, хэрэглэгдэхүүн	<p>Сургалтын хэлбэр:</p> <p>1.ганцаарчилсан сургалт;</p> <p>2.бүлгийн сургалт;</p> <p>3.хосолсон сургалт гэсэн хэлбэртэй байна.</p> <p>Сургалтыг дараах хэрэглэгдэхүүн, техник хэрэгслийг ашиглан зохион явуулна:</p> <p>1.компьютер;</p> <p>2.проектор;</p> <p>3.ном, гарын авлага, бусад материал;</p> <p>4.хөгжим, дүрс бичлэг;</p> <p>Бясалгалын сургалтын өрөө, байрыг эрүүл ахуйн болон бусад шаардлага хангахаар тохижуулах.</p>
8.	Сургалтын төрөл	<p>Зан үйлд нөлөөлөх сургалт нь дараах төрлүүдтэй байж болно:</p> <p>1.Сэтгэл зүйн сургалт:</p> <p>а.архинд донтолт, болон түүний хор уршгийн талаар;</p> <p>б.хүчирхийлэл үйлдэх зан үйлийг хэрхэн зохицуулах;</p> <p>в.уур бухимдлыг хэрхэн зохицуулах, стрессийг даван туулах;</p> <p>г.харилцах ур чадвараа дээшлүүлэх;</p> <p>д.бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх;</p> <p>е.өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх;</p> <p>ё.хүчирхийллээс үүдэх хүүхдийн сэтгэл зүйн асуудал, сөрөг үр дагавар;</p> <p>ж.гэр бүлийн сэтгэл зүйг төлөвшүүлэх.</p> <p>2.Эрх зүйн сургалтыг Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор явуулна.</p> <p>3.Бясалгалын сургалтыг эрх бүхий байгууллагын даргын тушаалаар баталсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, явуулна.</p>

		4.Тухайн оролцогчийн зан үйлийн өөрчлөлтөд тохирсон сэтгэл зүйн сургалтыг эрх зүйн сургалттай хослуулан явуулна. Оролцогчийн хувийн байдал, үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжийг харгалзан тэдний сэтгэл зүйн онцлогт тохирсон хэд хэдэн сургалтыг хослуулан явуулна. Сургалтыг хослуулан явуулахдаа хамтран ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлж болно.
9.	Хөтөлбөрт тусгагдсан сургалтын хугацаа	Баривчлагдсан оролцогчийн зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрт тусгагдсан сургалтыг шүүхээс тогтоосон албадан сургалтын цагтай уялдуулан харилцан адилгүй тогтоож болно.
10.	Сургалт тус бүрийн үргэлжлэх хугацаа хичээлийн цаг /60 минут/	Сэтгэл зүйн сургалт-16-41 Эрх зүйн сургалт-5-10 Бясалгалын сургалт-2-5 Сургалтын нийт цаг-23-56 цаг Нэг удаагийн ганцаарчилсан болон бүлгийн сургалтын үргэлжлэх дундаж хугацаа 45 минутаас ихгүй байна. Харин шаардлагатай тохиолдолд бүлгийн сургалтыг 90 минутаас ихгүй байхаар явуулна.
11.	Сургалтын санхүүжилт	Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ. 1.улсын төсөв; 2.төрийн болон төрийн бус байгууллагын санхүүжилт; 3.байгууллагын дотоод орлого.
12.	Хөтөлбөрийн хүрэх үр дүн	Хөтөлбөрийн үр дүнг тооцохдоо зан үйлийг өөрчлөх хосолмол-онолын загварыг ашиглан зан үйлийн өөрчлөлтийн үе шатыг оновчтой тодорхойлж, хөтөлбөрийн эхэн болон төгсгөлд үнэлсэн үнэлгээг харьцуулан гаргана. Зан үйл өөрчлөгдөх дараах 5 үе шатыг харгалзан үзнэ. 1.бодолгүй байх үе; 2.бодож эргэцүүлэх үе; 3.бэлтгэл үе; 4.үйлдэл хийх үе; 5.хэвших үе. Оролцогчийн зан үйлд илрэн гарах үр дүн: 1.бусдад хор хохирол учруулсан зан үйлдээ дүгнэлт хийж, өөрийн буруутай үйлдлийг ухамсарласан байх; 2.эрсдэлтэй зан үйлийг бууруулах, зохицуулах, засч сайжруулахад чадварыг эзэмшсэн байх; 3.зан үйлээ өөрчлөх итгэл үнэмшил нэмэгдэх, эрсдэлгүй шинэ зан үйлд суралцах оновчтой шийдвэр гаргах, өөрийгөө дайчлан ажиллах чадварыг эзэмшсэн байх; 4.уур бухимдлаа хянах, бууруулах, зохистой илэрхийлэх арга замд суралцсан байна; 5.өөрийгөө бодитойгоор үнэлж, бусдад зөв зохистойгоор илэрхийлж сурах, өөртөө зөв хандаж, нийгмийн нөлөөлөл дунд биеэ зөв авч явах арга замд суралцсан байна,

		Оролцогч нь зан үйлд нөлөөлөх сургалтад бүрэн хамрагдаж, гэр бүлийн хүчирхийллээс ангид байх ухамсар суусан байна.Этгээд нь зан үйл нөлөөлөх албадан сургалтад бүрэн хамрагдсанаар сургалт дуусгавар болж, үр дүнд хүрсэн байна.
--	--	--

ШШГЕГ-ын даргын 2019 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А/110 дугаар тушаалаар батлагдсан “Сэтгэл зүйн ажлын заавар”-ын зорилго нь хоригдол, хоригдсон болон баривчлагдсан этгээд /цаашид “хоригдогч” гэх/-ийн сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэн мэргэжлийн үйл ажиллагааны дараалал, арга, хэлбэр, хэрэгжүүлэх аргачлалыг тодорхойлж, сэтгэл зүйчийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулахад оршино гэжээ.

Түүнчлэн тус зааварт баривчлах төвийн сэтгэл зүйч:


1.Сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай баривчлагдсан этгээдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгч үр дүнгийн талаар удирдлагад танилцуулах;

2.Баривчлагдсан этгээдийн сэтгэлийн хөдөлгөөний тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн үйлчилгээ үзүүлэх;

3.Албадан сургалтыг нийгмийн ажилтан, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.


Судалгаанд хамрагдсан 452 этгээд Баривчлах байрнаас зохиож буй албадан сургалтын үр нөлөөг та хэрхэн үнэлж байна вэ? асуултад 123 нь буюу 27,2% нь үр нөлөө сайтай, 202 нь буюу 44,6% нь хангалтгүй, 28% нь ямар ч үр нөлөөгүй гэж хариулжээ.

Зураг 24. Албадан сургалтын үр нөлөөний талаарх судалгаа



Түүнчлэн албадан сургалтыг хэрхэн явуулах нь зүйтэй гэж үзэж байна вэ? гэсэн асуултад мэргэжлийн багш нараар заалгах гэж 252 буюу 55,7%, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг өөрчлөх гэж 61 буюу 13,4%, одоо явуулж буй сургалтын чанарыг сайжруулах гэж 139 буюу 30,7% нь үзжээ.


Зураг 25.Албадан сургалтын үр дүнг дээшлүүлэх талаарх санал




2.4.Баривчлагдсан этгээдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хийсэн шинжилгээ

Баривчлах байр, төв нь анх ирсэн баривчлагдсан хүнд эрүүл мэндийн үзлэг хийж, халдвартай, хүнд өвчтэй хүн илэрвэл бусдаас тусгаарлан нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэгт шилжүүлнэ.

Зураг 26.Баривчлах төвөөс яаралтай түргэн тусламж 103 дугаарын утсанд холбогдсон дуудлагын тоо



Зураг 27.Баривчлах төвөөс Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд дуудлага өгсөн тоо




Орон нутаг дахь баривчлах байранд дээрх төрлийн өвчтэй хүн ирвэл цагдаагийн байгууллага баривчлагдсан хүнийг нарийн мэргэжлийн эмнэлэгт үзүүлэх, эмнэлэгт хэвтэх шаардлагатай бол харуул хамгаалалтыг хариуцна.

Баривчлах төв нь эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх хэсэг /их эмч, бага эмч, сувилагч/-тэй байх ба эмнэлгийн үзлэг хийх, анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх зориулалтын тоног төхөөрөмж, өрөө тасалгаатай байна. Баривчлах төв /байр/-д шинээр ирсэн хүнийг хүлээн авч байгаа эмч /сувилагч/ хүн нэг бүрт эрүүл мэндийн үзлэг хийж, карт нээн ажиллана. Баривчлагдсан хүний эрүүл мэндийн картанд тухайн хүний биеийн өндөр, жин, даралт, биед нь ил гэмтэл, шарх, сорви бий эсэхийг үзэж, суурь өвчний түүх, биеийн өвчин, зовиур байгаа эсэхийг тэмдэглэнэ.

Баривчлагдсан хүн нь хүссэн үедээ эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч болох ба төв /байр/-ийн эмч, сувилагч урьдчилан сэргийлэх үзлэгийг 7 хоногт 1 удаа нэгдсэн шугамаар хийнэ.


Зураг 28.Баривчлагдсан этгээдүүдэд эрүүл мэндийн тусламж үзүүлсэн тоо



Баривчлах төв /байр/-ийн эмч нь баривчлагдсан хүний эмчилгээнд шаардлагатай эмийг зөвхөн нэг өдөр хэрэглэх хэмжээгээр зөвшөөрөх ба хэрэглэж байгаа эсэхэд болон өвчний явц, эмийн үйлчлэлд хяналт тавина. Мансууруулах болон хүчтэй цочролд оруулж болзошгүй эм хэрэглэхийг хориглоно.

Баривчлагдсан хүн нарийн мэргэжлийн эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх бол түүний гэр бүлийн гишүүнд даруй мэдэгдэж, энэ тухай бүртгэнэ. Баривчлагдсан хүний эмнэлэгт хэвтсэн хоногийг шийтгэл эдэлсэн хугацаанд тооцохгүй бөгөөд баривчлагдсан хүн нь төв /байр/-д өөрийн зардлаар ирэх үүрэгтэй.


Зураг 29.Баривчлагдсан этгээдүүдээс гадна эмнэлэг хэвтсэн тоо



Баривчлагдсан хүн нь баривчлах төв /байр/-д өөрөө хүрэлцэн ирээгүй тохиолдолд эрэн сурвалжилж албадан ирүүлнэ.

Баривчлагдсан этгээд нас барсан тохиолдлыг Монгол Улсын иргэдийн 1000 хүн тутам дахь дундаж нас баралт 5-5.5 байдаг ба үүнийг Баривчлах төвд /жилд дунджаар 3000-6000 орчим хүн байсан гэж үзвэл/ нас барсан иргэдтэй харьцуулсан судалгаа хийж үзэхэд дараах үзүүлэлттэй байна.

Зураг 30.Баривчлагдсан этгээдээс нас барсан байдлыг улсын дундажтай харьцуулсан байдал



2.5.Баривчлагдсан этгээдэд тавих хяналт, хамгаалалтын үйл ажиллагаанд хийсэн шинжилгээ

Баривчлагдсан этгээд нь баривчлах шийтгэл эдлэх хугацаандаа баривчлах байрны захиргаа, түүний алба хаагчийн хяналтад байна. Дээрх хяналтыг хэрэгжүүлэхэд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн болон хуулиар хориглоогүй бусад тоног төхөөрөмжийг ашиглаж болно.

Баривчлах төв болон баривчлах байр нь баривчлах шийтгэлийг эдлүүлэх зориулалтын өрөө, тасалгаа, харуул хамгаалалт бүхий барилга байгууламжтай байх бөгөөд баривчлагдсан этгээдийн байрлах өрөө нь олон улсын стандартад заасан шаардлагыг хангасан байна.

Практикт баривчлах байр нь хорих байгууллагын төрөл, бүтцийн нэг хэсэг мөн эсэх тал дээр маргаантай асуултууд байдаг. Энэ нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд баривчлагдсан этгээдийн эрх зүйн байдал нь хорих байгууллагын нөхцөл, журамтай адилтгасан байдлаар зохицуулсантай холбоотой юм. Тухайлбал, “баривчлагдсан этгээдийг энэ хуулийн 208.1, 208.2-т заасны дагуу тус тусад нь байрлуулах бөгөөд баривчлах байрны нөхцөл болон бусдын эрүүл мэндэд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхээс бусад тохиолдолд баривчлагдсан этгээдийг ганцаарчлан хорихыг хориглоно” гэжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 208 дугаар зүйлийн 208.1-т “Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны болон эмэгтэй, эрэгтэй хоригдлыг тусад нь ял эдлүүлнэ”, 208.2. “Бусдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчтэй хоригдлыг бусад хоригдлоос тусгаарлан ял эдлүүлнэ” гэсэн нь баривчлагдсан этгээдийг гэмт хэрэг үйлдсэн хоригдолтой адил байдлаар зохицуулахыг оролдсон байна.

Баривчлагдсан хүнийг төв /байр/-ийн даргын шийдвэрээр ереенд хуваарилж, харуул хамгаалалтын ажилтан баривчлагдсан хүнийг хуваарилагдсан ереенд хүргэж, хучлага, дэвсгэр олгоно. Баривчлагдсан хүний ерөөг дараах үндэслэлээр солих буюу дахин хуваарилж болно.Үүнд:


1.эрүүл мэндийн шаардлагаар;

2.баривчлах төв /байр/-д гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор;

3.баривчлагдсан хүний эсхүл өмгөөлөгчийн бодит үндэслэл бүхий хүсэлтээр.

Судалгаанд оролцсон 452 баривчлагдсан этгээдээс өрөөнд хуваарилахдаа ямар үзүүлэлтийг харгалзах нь зүйтэй вэ? гэсэн асуултанд 147 нь буюу 32,5% нь үйлдсэн зөрчлийн төрлөөрөө нэг өрөөнд байх, 119 нь буюу 26,3% өөрсдийн хүсэлтийг нь харгалзан өрөөнд хувиарлаж байх, 186 нь буюу 41,1% хүний хувийн байдлыг харгалзан өрөөнд байвал зүгээр гэсэн хариулт өгсөн байна.

Зураг 31. Баривчлах өрөөнд хувиарлах талаарх санал асуулгын дүн



Баривчлагдсан хүний аюулгүй байдлыг баривчлах төв /байр/-ийн ээлжийн бүрэлдэхүүн хариуцна. Баривчлагдсан хүний амь нас, эрүүл мэнд, эрх чөлөөнд аюул заналхийлэл учирч болзошгүй тохиолдолд ээлжийн дарга аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авна.


Баривчлах төв нь байнгын харуул хамгаалалттай байна. Ээлжийн дарга, харуул хамгаалалтын ажилтан нь утсан болон радио холбоо, хүн нэг бүрийн тусгай хэрэгслээр хангагдана. Баривчлах төв /байр/ нь гэрэлтүүлэг, дохиолол, дүрс бичлэгийн хэрэгсэлтэй байх бөгөөд хамгаалалтын үйл ажиллагаанд албаны нохой ашиглаж болно. Баривчлах төв /байр/-д шүүгч, прокурор, эрх бүхий албан тушаалтан, түргэн тусламжийн эмчээс бусад гадны хүн оруулахыг хориглоно.

Харуул хамгаалалтын ажилтан нь байранд гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, цагийн хуваарийг мөрдүүлэх, түүнчлэн байрны болон баривчлагдсан хүний аюулгүй байдлыг хангана. Баривчлах төв /байр/-ийн харуул хамгаалалтыг өдөр тутмын болон хүч нэмэгдүүлсэн хамгаалалт гэсэн төрлөөр зохион байгуулна.

Баривчлагдсан хүний зүгээс танхайрах, догшин авирлах, бусадтай зодолдох, эмх замбараагүй байдал үүсгэх, халдан довтлох зэргээр бусдын амь нас, эрүүл мэндэд илтэд хохирол учруулж болзошгүй үйлдэл хийсэн, оргох, оргохоор завдсан зэрэг зайлшгүй нөхцөл байдлын үед харуул хамгаалалтын ажилтан хууль, журамд заасны дагуу нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэж болох ба хэрэглэсэн тухай тэмдэглэл үйлдэж, төв /байр/-ийн даргад танилцуулна.


Баривчлах төвд 2015 онд-246, 2016 онд-174, 2017 онд-150, 2018 онд-144, 2019 онд-253 удаа төлөвлөгөөт болон гэнэтийн үзлэг, нэгжлэг хийсэн байна.

Зураг 32. Баривчлах төвд 2015-2020 оны хооронд хийгдсэн үзлэг, нэгжлэгийн судалгаа



Түүнчлэн үзлэг, нэгжлэгийн хүрээнд баривчлагдсан этгээдээс 2015 онд-235, 2016 онд-51, 2017 онд-45, 2018 онд-693, 2019 онд-140 хориотой эд зүйлс хураан авчээ.

Зураг 33. Баривчлах төвд 2015-2020 оны хооронд хийгдсэн үзлэг, нэгжлэгийн хүрээнд хураагдсан хориотой эд зүйлсийн судалгаа



Баривчлах байр нь тусгаарлах тасалгаатай байх бөгөөд түүнд шилжүүлэх журмыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 230.1, 230.2-д заасанд нийцүүлэн баривчлах байрны дотоод журмаар тогтооно. Үүнд:

1. Баривчлагдсан этгээдийн амь нас, эрүүл мэндэд аюул учирч болзошгүй гэх хангалттай үндэслэл байгаа бол даруй урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүрэгтэй.

2. Баривчлагдсан этгээдийн амь нас, эрүүл мэндэд бусад этгээдийн хууль бус үйлдлийн улмаас хохирол, хор уршиг учрах хангалттай үндэслэл байгаа бол ээлжийн даргын шийдвэрээр хоригдлыг 72 цаг хүртэл хугацаанд тусгаарлах тасалгаанд шилжүүлнэ. Шаардлагатай тохиолдолд хорих ангийн даргын шийдвэрээр уг хугацааг дахин 72 цагаар сунгаж болно.

2.6.Баривчлах байрны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтад хийсэн шинжилгээ

Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д зааснаар “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно”²⁰ хэмээн хуульчилсан нь Прокурорын байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг тодорхой хүрээнд тусгайлан өөрийн гэсэн өвөрмөц байр суурь бүхий байгууллага болгожээ. Манай улсын хувьд Прокурорын байгууллага нь хуулиар олгогдсон эрх хэмжээнд хамаарах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хяналтын чиг үүрэг голлох байр суурийг эзэлдэг. Прокурорын хяналт нь нэг талаас төрийн хяналт, нөгөө талаас эрүүгийн процессын буюу мэргэжлийн хяналт байдаг онцлогтой.

Прокурорын хяналт нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэлтэй зэрэгцэж оршдог шүүх эрх мэдлийн төрийн үйл ажиллагааны бие даасан нэг хэлбэр бөгөөд энэ тухай Прокурорын байгууллагын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д: “Прокурорын байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий, хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага мөн.”²¹ гэж тодорхойлон зааж өгсөн. Прокурорын шаардлагыг хуульд прокуророос хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх явцад илэрсэн зөрчил дутагдал, гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцлийг арилгуулах зорилгоор бичсэн хугацаатай үүрэг юм. Прокурорын шаардлагыг дээд шатны прокурор бичих эрхтэй. Шаардлагыг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, гаргасан зөрчил, түүний шалтгаан нөхцлийг нэн даруй арилгах арга хэмжээ авч, 15 хоногийн дотор бичгээр прокурорт мэдэгдэх үүрэгтэй байдаг.

Ийнхүү прокурорын шаардлага нь хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт, шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагааны явцад хуулийг нэг мөр хэрэглэх, хүний эрхийг зөрчихгүй байх, хуулийг дээдлэх баталгаа болж өгдөг.

Баривчлах төв нь 2015 онд прокурорын байгууллагаас 2, мэргэжлийн хяналтын байгууллагаас 1, 2016 онд прокурорын байгууллагаас 3, онцгой байдлын байгууллагаас 1, 2017 онд прокурорын байгууллагаас 2, мэргэжлийн хяналтын байгууллагаас 1, 2019 онд прокурорын байгууллагаас 1 шаардлага, мэдэгдэл авсан байх ба шаардлагад дараах зөрчлүүд заагджээ.

Хүснэгт 10.Баривчлах төвд 2015-2020 оны хооронд хийгдсэн хяналт, шалгалт, түүнд илэрсэн зөрчил, дутагдлын судалгаа

Д/д	Заагдсан зөрчил	Холбогдох журам, заавар
2015 онд		
Прокурорын байгууллага:		
1.	Баривчлах шийдвэр биелүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.4	Ээлжийн дарга нь баривчлагдсан этгээдийг хүргэж ирсэн албан тушаалтныг байлцуулан

²⁰ Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он

²¹ Прокурорын байгууллагын тухай хууль.УБ. 2017 он

	дэх заалтыг зөрчсөн.	шүүгчийн шийдвэрт заасан этгээд мөн эсэхийг иргэний үнэмлэх эсхүл иргэний бүргэлийн лавлагаа, жолооны үнэмлэх, гадаад паспорттай тулган, шийтгэврийн бүрдлийг шалгана. Бичиг баримт шийтгэврийн бүрдэл дутуу, зөрчилтэй бол хүлээж авахгүй
2.	Баривчлах шийдвэр биелүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.5 дахь заалтыг зөрчсөн.	Баривчлагдсан этгээдийг хүлээн авах үед ээлжийн дарга энэ журмын 4.2.1-4.2.12-т заасан бүртгэлийг хөтөлж, баривчлагдсан этгээдийг согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг согтуурлын зэрэг хэмжигч багажаар шалгаж тэмдэглэл хөтлөн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2014 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/146 дугаар тушаалаар баталсан "Ялтан, хоригдогсдын зургийн сан бүрдүүлэх, гэрэл зураг авах аргачлал"-ын дагуу түүний гэрэл зургийг авч, зургийн сан бүрдүүлнэ.
3.	Баривчлах шийдвэр биелүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.9 дэх заалтыг зөрчсөн.	Баривчлагдсан этгээдийг хүлээн авахдаа харуул хамгаалалтын ажилтан түүний хувцас, эд зүйл, биед үзлэг, нэгжлэг хийх бөгөөд биедээ байлгахыг зөвшөөрснөөс бусад эд зүйлс илэрвэл энэ тухай тэмдэглэл хөтлөн байрны захиргаа түр хураан авч, байрнаас гарахад нь баривчлагдсан этгээдэд хүлээлгэн өгнө.
4.	Өвчтөнд хэрэглэсэн зүү, тариурыг аюулгүй хайрцагт цуглуулаагүй, эмнэлгийн халдвартай, энгийн хог хаягдлыг ангилдаггүй, ариутгалын бодис хэрэглэдэггүй, гар угаах угаалтуургүй.	Баривчлах шийдвэр биелүүлэх журмын 9.2-д "Баривчлах төв болон байрны эмч нь баривчлагдсан этгээдийн биед үзлэг, оношлогоо, эмчилгээ хийх эмнэлгийн багаж хэрэгслээр хангагдсан өрөөтэй байна."
5.	Баривчлах төвд байрлаж байгаа этгээдүүдэд өдөрт 2 удаа 500 граммаас багагүй хэмжээтэй халуун хоол, нэг удаа гурилан бүтээгдэхүүн, гурван удаа цай өгөх гэсэн заалт хэрэгжээгүй.	Баривчлах шийдвэр биелүүлэх журмын 8.7-д "Баривчлагдсан этгээд нь Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 23.1-д заасан шаардлагыг хангасан хоолоор хангагдана. Баривчлагдсан этгээдэд өдөрт хоёр удаа 500 граммаас багагүй хэмжээтэй халуун хоол, нэг удаа гурилан бүтээгдэхүүн, гурван удаа цай өгөх ба нэг удаад олгох цай 1-1.5 литр байна."
6.	Тус баривчлах төв нь нэг хүнд ногдох талбай тогтоосон хэмжээнд хүрэхгүй "Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг	"Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль"-ийн 24.2-д "Хорих байрны өрөө нь нэг хүнд 2, 5 ба түүнээс дээш хавтгай дөрвөлжин метр талбай ногдохоор байна."

	биелүүлэх тухай хууль"-ийн заалтыг зөрчсөн.	
7.	Нийгмийн ажилтан дэслэгч Д.Уянга нь баривчлагдсан этгээдүүдэд сургалт явуулах хөтөлбөр, төлөвлөгөөг санаачлан боловсруулж, тус төвийн даргаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаагүй.	Баривчлах шийдвэр биелүүлэх журмын 10.2-д 10.2.Сургалт нь зөрчил гаргагчийн зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх бөгөөд баривчлагдсан этгээдийн гаргасан зөрчлөөс нь хамаарч зөрчил гаргагчийн хамрагдах сургалтын хөтөлбөрийг боловсруулна.
8.	Баривчлах шийдвэр биелүүлэх журмын 10 дугаар зүйлийн 10,3 дах" заалтыг зөрчсөн.	Баривчлагдсан этгээдийг сургах ажлыг тухайн Баривчлах төв болон байрны нийгмийн ажилтан, сэтгэлзүйч хариуцна.
9.	Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"-ын 5 дугаар зүйлийн 5.7.6 дах" заалтыг зөрчсөн.	Нийгмийн үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх чиглэл бүхий дараах байгууллагуудтай хамтран ажиллана: а/ нийгмийн даатгалын газар б/ нийгмийн халамж үйлчилгээний газар, в/ иргэний бүртгэлийн байгууллага, г/ цагдаагийн байгууллага, д/ хөдөлмөр зуучлалын төв, е/ сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг байгууллагууд ё/ төрийн бус байгууллагууд
10.	"Нийгмийн ажлын заавар"-ын 3 дугаар зүйлд заасан заалтыг огт хэрэгжүүлээгүй.	Гурав. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба дахь нийгмийн ажилтны явуулах судалгаа
11.	"Нийгмийн ажилтны ажлын заавар"-ын 7 дугаар зүйлд заасан Нийгмийн ажилтнуудын хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайланг улирал тутам 12 төрлийн шалгуураар үнэлж, дүгнэх ажлыг тус төвийн удирдлага зохион байгуулаагүй орхигдуулсан.	
Мэргэжлийн хяналтын байгууллага:		
12.	Баривчлах байранд засвар яаралтай хийж, нөхцлийг сайжруулах арга хэмжээ авах, байрны эрүүл ахуйн дүгнэлт гаргуулах, нэг хүнд ноогдох талбайг тооцож саатуулагдсан этгээдийг байрлуулах.	
13.	Баривчлагдсан этгээдийг шаардлага хангасан цэвэр гудас, орны бүтээлэг, хөнжил, цагаан хэрэглэлийг тогтмол угааж нар салхинд тавьж цэвэрлэж байх.	
14.	Гудас, орны бүтээлэг, дэвсгэр, цагаан хэрэглэлийг тогтмол угааж нар салхинд тавьж цэвэрлэж байх.	
15.	Баривчлагдсан этгээдийг хувийн ариун цэвэр сахих боломж, нөхцөлөөр хангах, усны хангамж, хүрэлцээг нэмэгдүүлэх, гар угаах саван алчуур, шүдний сойз, оогоор хангах, Баривчлах байрны орчинд өдөр тутмын халдваргүйтгэл хийж хэвших.	
16.	Тусгаарлах өрөөнд ор тавих, агааржуулах системээр хангах.	
17.	Эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх эм, тариа, ороох боох материалын хангамж хүрэлцээг нэмэгдүүлэх.	
18.	Баривчлах байранд дотоод хяналтын нэгж, ажилтан томилж, дотоод хяналтын журам батлан хэрэгжүүлж ажиллах.	

19.	Хоолны илчлэг хэмжээг нэмэгдүүлж хууль, журамд заасан хэмжээнд хүргэх, өдөрт 2 удаа халуун хоол олгох.	
20.	Гал тогооны газарт түүхий болон бэлэн болсон хүнсний бүтээгдэхүүнийг зөв хадгалах, цай чанадаг халуун тогоог сольж, шинэчлэх.	
21.	Хоол хийж байгаа дотор махан таташийг шинжилгээнд хамруулж, баталгаа дүгнэлт гаргуулсны дараа хүнсэнд хэрэглэх, хаяг шошготой.	
2016 онд		
<i>Прокурорын байгууллага:</i>		
22.	2015.12.31-ний шөнө төвд байрлаж байсан Пунцаг овогтой Батмөнхийг Баривчлах төвийн захиргаа өөрийн байгууллагын уурын зуухны галчаар 24 цагийн хугацаагаар ажиллуулж байгаа боловч түүнийг хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгслээр хангаагүй байгаа нь ШШГТХ-ийн 120 дугаар зүйл, Хууль зүйн сайдын тушаалаар батлагдсан “Баривчлах шийдвэр биелүүлэх журам”-ын холбогдох заалтуудыг зөрчсөн.	
23.	Баривчлах төвийн үйл ажиллагаатай танилцах явцад захиргааны зөрчил гаргаж шүүхийн шийдвэрээр баривчлах шийтгэвэр эдэлж байгаа Г.Батмөнхийг Баривчлах төвийн хориотой бүсийн гадна байрлах байранд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 125.2-т зааснаар 3,6 жилийн хорих ял эдэлж байгаа ялтан Б.Идшинноровтой нэг өрөөнд хорьсон.	
24.	Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэж, хорих ялаар шийтгэгдсэн ялтан Б.Идшинноровыг захиргааны зөрчил гаргаж баривчлагдсан этгээдүүдтэй хамт хорьж байгаа нь хүний эрхийг ноцтой зөрчсөн асуудал болсон байх тул буруутай этгээдэл хариуцлага тооцож, ялтан Б.Итшинноровыг Хорих 401 дүгээр ангийн хориотой бүсэд татан оруулж, хариу мэдэгдэх.	
25.	“Баривчлах шийдвэр биелүүлэх журам”-ын 3.4 дэх хэсэгт заасныг зөрчиж энэхүү журамд заагаагүй бичиг баримтаар баривчлагдсан этгээдийг хүлээн авсан. Тухайлбал, СХД-ийн 9-р хорооноос баривчлагдсан Г.Батбаяр, Б.Насанжаргал, Ш.Галтхүү нарыг дээрх журамд заасан бичиг баримтгүй, Цагдаагийн хэлтсийн жижүүрийн шуурхай албаны дардастай зэрэг бүхий баримтаар хүлээн авсан байна.	“Ээлжийн дарга нь баривчлагдсан этгээдийг хүргэж ирсэн албан тушаалтныг байлцуулан шүүгчийн шийтгэвэрт заагдсан этгээд мөн эсэхийг иргэний үнэмлэх, эсхүл, иргэний үнэмлэхийн лавлагаа, жолооны үнэмлэх, гадаад паспорттай тулган, шийтгэврийн бүрдлийг шалгана. Баримт бичиг, шийтгэврийн бүрдэл дутуу, зөрчилтэй бол хүлээн авахгүй” гэсэн
26.	Баривчлах шийдвэр биелүүлэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэгт заалт тус төвийн хэмжээнд бүрэн хэрэгжээгүй, тоо бүртгэгч, ахлах дэслэгч Н.Наран нь баривчлах шийтгэл эдлэгчдийн зургийг авч	“Баривчлагдсан этгээдийг хүлээн авах үед ээлжийн дарга энэ журмын 4.1.1-4.2.12-т заасан бүртгэлийг хөтөлж, баривчлагдсан этгээдийн согтуурлын зэрэг хэмжигч багажаар шалгаж тэмдэглэл хөтлөн ШШГЕГ-ын даргын “Ялтан хоригдогсдын зургийн сан бүрдүүлэх, гэрэл зураг авах аргачлал”-ын дагуу түүний гэрэл зургийг авч, зургийн сан бүрдүүлнэ”.

	компьютерт хадгалсан боловч тэдгээрийн гэрэл зургийг хувийн хэрэгт нь хавсаргадаггүй, дээрх аргачлалын дагуу гэрэл зургийн сан бүрдүүлээгүй.	
27.	Дүүргийн прокурорын газраас тус төвийн үйл ажиллагаатай танилцах явцад Баривчлах шийдвэр биелүүлэх журмын 8.8-д заасан "Баривчлагдсан этгээдийг хэрэгцээтэй үед нь ундны усаар хангана" гэсэн заалт хэрэгжээгүй байгаа нь баривчлах шийтгэл эдэлж буй хүмүүсийн эрхийг зөрчсөн байна. Баривчлагдсан этгээдүүдийг 5 өрөөнд хуваарилан байрлуулж байгаа бөгөөд тэдгээр өрөөнүүдийн хаалгыг гадна талаас нь байнга цоожилж, зөвхөн хоолонд оруулах, тоо авах, бие засуулах, салхинд гаргах үед хаалгыг нээж, бусад хугацаанд байнгын цоожтой байлгаж байгаа нь тэдний хэрэгцээ шаардлагатай үедээ ундны ус уух ямар ч боломжгүй байна. Энэ байдал нь жирийн дэглэмтэй хорих ангиас ч илүү хатуу дэглэмд шийтгэл эдэлж байна гэж ойлгогдохоор байгаа бөгөөд тус төвийн нийгмийн ажилтан болон удирдах ажилтнууд нь хууль, журамд заасан эрхийг хангуулах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаагүй байна.	
28.	Хууль зүйн сайдын 2014 оны А/227 дугаар тушаалаар батлагдсан "Баривчлах шийдвэр биелүүлэх журам"-д заасан баривчлагдсан этгээдийг хүлээн авах тухай заалтыг зөрчиж Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр 2016.03.04-ний өдөр ахуйн хүрээний зөрчлийн учир 7 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл эдэж байсан Ц.Энхжаргал гэх эмэгтэйг ирэхэд 2ш гар утас хураан авсан боловч тэмдэглэл үйлдэлгүйгээр өөртөө харгалж байсан.	
29.	Баривчлах шийтгэл эдэлж буй эмэгтэйчүүд байрладаг 5-р өрөөний таазны хавтан 2016.03.07-ны өдрийн 03.00 цагийн орчимд нурж, таазнаас шороо, чулуу, 2 тооны тагтаа шувуу зэрэг зүйлс унаж. их хэмжээний тоос, тоосжилт үүссэн тул тэнд байрлаж байсан 5 хүнийг тухайн шөнө үүрэг гүйцэтгэж байсан ээлжийн бүрэлдэхүүн еөр өрөөнд шилжүүлэн байрлуулж аюулгүй болгосон бөгөөд уг өрөөг 2 хоногт багтаан засварлаж, хүмүүсийг буцаан байрлуулсан байна.	
30.	Баривчлах байранд байгаа агааржуулах төхөөрөмж нь байнгын дуу чимээ ихтэй, агааржуулагчийнх нь нүхнүүдээр байнга ус гоожиж байдаг, байрлагч нарын хэрэглэж байгаа хучлага, дэвсгэр нь бохир, хир тоос ихтэй, түүнийг угааж, ариутгах төхөөрөмж байхгүй байгаа нь "Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх журам"-ын 24.1-24.4-ийг зөрчсөн.	<p>24 дүгээр зүйл. Ахуйн хангамж</p> <p>24.1.Хоригдсон этгээд нь ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөл, унтаж амрах боломжоор хангагдана.</p> <p>24.2.Хорих байрны өрөө нь нэг хүнд 2, 5 ба түүнээс дээш хавтгай дөрвөлжин метр талбай ногдохоор байна.</p> <p>24.3.Хорих байр нь агааржуулах төхөөрөмжтэй байна.</p> <p>24.4.Хоригдсон этгээдэд хорих байрны захиргаанаас хучлага, дэвсгэр, аяга, халбага тавьж олгоно.</p>

31.	Шалгалтын явцад баривчлагдсан этгээдүүдтэй уулзаж, ярилцахад тэдний зарим нь бие өвдөөд эм тариа өгөөч гэхэд нь дууссан гээд өгдөггүй гэх ба зарим эмч, сувилагч нарын зан харьцаа, үйлчилгээний чанар хангалтгүй байгаа талаар санал, гомдол гаргаж байна. Тухайлбал, тус төвийн сувилагч, ахлах ахлагч Дашгэнцмаа нь баривчлагдсан этгээдүүдтэй хатуу ширүүн харьцдаг, тэднийг элдэв үгээр дайрч доромжилдог зөрчил нэг бус удаа гаргасан гэжээ. Энэхүү байдалд албаны шалгалт явуулж тогтоох зайлшгүй шаардлагатай байна.	
32.	Шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй байгаа 25 этгээдийг нэн даруй олж, баривчлах шийдвэрийг нөхөн эдпүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	
33.	Баривчлах байранд байрласан хугацааны шууд зардлыг төлөөгүй суллагдсан иргэдийн асуудлыг шүүхээр шуурхай шийдвэрлүүлэх, өөр бусад боломжит арга хэрэгсэл ашиглаж зардлыг төлүүлэхэд анхаарч ажиллах.	
34.	Баривчлагдсан этгээдийн ахуй нөхцөл, ялангуяа өрөө тутмын ариун цэврийн хэрэгслээр хангаж ажиллах.	
Онцгой байдлын байгууллага:		
35.	Байгууллагын хэмжээнд тохиолдож болзошгүй гамшгийн төрлүүд дээр урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах талаар гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг албан ёсоор байгуулж, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, эрсдлийг бууруулахад чиглэсэн сургалт дадпагыг мэргэжлийн албадтай хамтарч зохион байгуулах.	
36.	Үйл ажиллагааны онцлогт тохирсон өдөр тутмын галын аюулгүй байдлаа хангах талаар дотоод журам боловсруулж мөрдөх, галын аюулгүй байдлын өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлэх албан тушаалтан, галын бүлгэмийг албан ёсоор томилж, галын аюулгүй байдлын дотоод хяналтыг сайжруулах.	
37.	Захиргаа, шалган нэвтрүүлэх, хорих байр, сургалтын тахим, уурын зуух зэрэг барилга байгууламж нь 1960-аад онд баригдсан гэх боловч тодорхой зураг төсөлгүй, барилга, байгууламжийн хийц, бүтээц, цахилгаан байгууламжийн ашиглалтын төлөв байдалд мэргэжлийн хяналтын барилгын болон цахилгаан байгууламжийн улсын байцаагчийн дүгнэлт гаргуулж дүгнэлтийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлэх, мөн уурын зуухны барилга, нам даралтын зуухны ашиглалтанд дүгнэлт гаргуулж, мэргэжлийн машинист ажиллуулах.	
38.	Галын автомат дохиоллын болон дотор гал унтраах системийг дээрх норм дүрмийн дагуу шинээр төвлөж хийх.	
39.	Гал түймэр, бусад ослын үед аврах, нүүлгэн шилжүүлэх схемийг шаардлагын дагуу хийж, нийт гарц, хаалгууд дээр болзошгүй ослын үед нүүлгэн шилжүүлэлтийн үеийн шаардлагад нийцүүлж харагдахуйц байдлаар гэрлэн тэмдлэг байруулах.	
2017 онд		
Прокурорын байгууллага:		
40.	Баривчлах байранд эрэгтэйг эмэгтэйгээс тусад нь байрлуулж байгаа боловч 18 насанд хүрээгүй этгээдийг насанд хүрэгчдээс тусад нь байрлуулдаггүй.	Баривчлах шийдвэр биелүүлэх журмын 2.3-д "Байранд эрэгтэйг эмэгтэйгээс, 18 насанд хүрээгүй этгээдийг насанд хүрэгчдээс тусад нь байрлуулна."
41.	Захиргааны журмаар баривчлах төвийн харуул	Баривчлах шийдвэр биелүүлэх журмын 7.1. "Захиргааны журмаар баривчлах төвийн

	хамгаалалтын дараах бүрэлдэхүүнтэй байна. Ээлжийн дарга, шалган нэвтрүүлэх харуул, даалгавар гүйцэтгэгч харуул, холбоочин, телекамерын хяналтын ажилтан, сувилагч гэсэн бүрэлдэхүүнтэй зохион байгуулах гэж заасан байхад холбоочин нь хоногийн харуул хамгаалалтын бүрэлдэхүүний томилгоонд багтаагүй.	хоногийн харуул хамгаалалт дараах бүрэлдэхүүнтэй байна: 7.1.1.ээлжийн дарга; 7.1.2.шалган нэвтрүүлэх харуул; 7.1.3.даалгавар гүйцэтгэгч харуул; 7.1.4.холбоочин; 7.1.5.телекамерын хяналтын ажилтан /операторчин/; 7.1.6.сувилагч.
42.	Тус төв нь нэг хүнд ногдох талбайн хэмжээ стандартын дагуу бол 145-148 хүн хүлээж авах хүчин чадалтай байхад 81 этгээд илүү авч байрлуулсан. 1 орон дээр 2 хүн унтаж байгаа нь "Сэжигтэн яллагагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль"-ийн 24.1, 24.2 заалтыг зөрчсөн.	24 дүгээр зүйл. Ахуйн хангамж 24.1.Хоригдсон этгээд нь ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөл, унтаж амрах боломжоор хангагдана. 24.2.Хорих байрны өрөө нь нэг хүнд 2, 5 ба түүнээс дээш хавтгай дөрвөлжин метр талбай ногдохоор байна.
43.	Тус төвийн яаралтай тусламжийн хэсэгт их эмч байхгүй, бага эмч, сувилагч нарын ажлын байрны тодорхойлолт нь ижил, сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлэх чиглэлтэй их эмчийн удирдлагагүйгээр эм өгч, эмчилгээ хийж байгаа нь Эрүүл мэндийн тухай хуулийн 28.4.3 дахь заалтыг зөрчсөн.	"үйл ажиллагаандаа эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын стандарт, технологи, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх удирдамжийг мөрдөж ажиллах"
44.	Эмнэлгийн мэргэжилтнүүд нь Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж оношилгоо эмчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын стандарт технологи, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх удирдамжийг мөрдөж хэвшээгүй.	
45.	Эмнэлгийн хүчин төгөлдөр анхан шатны маягтаар хангагдаагүй, үзлэгийн картыг үнэн зөв хөтлөөгүй, үндсэн оношийг өвчний олон улсын ангиллын кодоор ангилаагүй.	
46.	Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэсэгт ажиллаж байгаа бага эмч, сувилагч нар яаралтай тусламжийн чиглэлээр сургалтанд хамрагдаагүй, эмнэлэг үйлчилгээнд мөрдөн ажиллах стандарт, эмнэлзүйн удирдамжийн хэрэгжилтийн байдал тавигдах дотоод хяналт тогтмолжоогүй, үр дүнг тооцон ажиллаж хэвшээгүй.	
47.	Мэргэжлийн хяналтын байцаагчийн авсан арчдасын шинжилгээгээр ажилтан болон байрлагч нарын хоолны таваг, усны төмөр болон хуванцар савнаас нян	

	илэрсэн, баривчлагдсан этгээд хувийн ариун цэвэр сахих боломж нөхцлөөр бүрэн хангагдаагүй, дотор байрлах ариун цэврийн өрөөг байрлагч нарт байнга ашиглуулдаггүй, гадна 00-д бороо цаснаас хамгаалах саравч байхгүй, хооллох ширээ сандалгүй, хувцас хэрэглээ угаах, индүүдэх боломжгүй, төвийн хэмжээнд ахуйн хэрэглээний 1 угаалгын машин байгаа нь шаардлага хангахгүй байна.	
Мэргэжлийн хяналтын байгууллага:		
48.	Тус төвийн хүлээн авах, яаралтай тусламжийн хэсэгт яаралтай тусламжийн чиглэлээр мэргэшсэн их эмч, сувилагч ажиллуулаагүй.	
49.	Тусламж үйлчилгээний чанарт тавигдах дотоод хяналтыг эрчимжүүлж, үр дүнг тооцон ажиллах, эмч мэргэжилтний үүрэг хариуцлагыг өндөржүүлэх.	
50.	Эмнэлгийн мэргэжилтнүүдэд Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, оношлогоо эмчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын стандарт технологи, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх удирдамжийг судлуулах, эрх зүйн мэдлэг олгох тасралтгүй сургалтыг зохион байгуулж ажиллах.	
51.	Эмнэлгийн хүчин төгөлдөр анхан шатны маягтаар хангах, эмчийн үзлэгийн бүртгэл, үйлчлүүлэгчийн амбулаторын болон эмчилгээний картыг үнэн зөв, оношийг товчлохгүй өвчний ангилал, стандарт шаардлагын дагуу бичих, эмч нарын ажлын хариуцлагыг өндөржүүлэх.	
52.	Баривчлах төвийн ачааллыг хэтрүүлэн хүн байрлуулахгүй байх.	
53.	Баривчлах төвийн гал тогооны газрын эрүүл ахуйн стандартын шаардлагыг хангуулах, аяга тавагны угаалга, ариутгалыг чанартай хийх, усны савыг тогтмол цэвэрлэж ариутгаж байх, хоолны нэр төрлийг олшруулан, шим тэжээлтэй хоол хүнсээр байрлагч нарыг хангах.	
2019 онд		
Прокурорын байгууллага:		
54.	Баривчлах байранд эрэгтэй хүнийг эмэгтэйгээс тусад нь байрлуулж байгаа боловч 18 насанд хүрээгүй этгээдийг насанд хүрэгчдээс тусад нь байрлуулаагүй	Баривчлах шийдвэр биелүүлэх журмын 2.3-д "Байранд эрэгтэйг эмэгтэйгээс, 18 насанд хүрээгүй этгээдийг насанд хүрэгчдээс тусад нь байрлуулна."
55.	Баривчлах төвийн хоногийн харуул хамгаалалтын бүрэлдэхүүнд дүрс бичлэгийн хяналтын ажилтан, холбоочин ажиллуулахгүй байгаа нь "Баривчлах байрны дотоод журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.1.2, 1,3-т заасныг зөрчиж байна.	
56.	Тус төв нь 330м.кв талбай бүхий 2 давхар 24 өрөө бүхий объектод үйл ажиллагаа явуулж, нэг өрөөний хэмжээ өргөн нь 3.47 м, урт 5.87 м буюу нийт 20.368 м.кв, нэг өрөөнд дунджаар 8-9 этгээдийг байрлуулан, 220 хүнийг хүлээн авах чадалтай байх ба 2019 оны 01 дүгээр сарын 28-ны байдлаар 238 этгээд байрлаж байна.	Баривчлах байрны дотоод журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3-т заасан "1 хүнд оногдох талбайн хэмжээ 2,5 м.кв байна".

57.	Шинэ байранд үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш тусгаарлах тасалгаагүй байгаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасныг зөрчсөн.	144.5.Баривчлах байр нь тусгаарлах тасалгаатай байх бөгөөд түүнд шилжүүлэх журмыг энэ хуулийн 230.1, 230.2-д заасанд нийцүүлэн баривчлах байрны дотоод журмаар тогтооно.
58.	Баривчлах төвд шүүхийн шийтгэврээр баривчлах шийтгэл оногдуулсан этгээдүүдийг Цагдаагийн байгууллага, эрх бүхий албан тушаалтнаас хэрхэн хүлээлгэн өгч байгааг үзэж танилцахад, “Баривчлах байрны дотоод журам”-д заасны дагуу баривчлагдсан этгээдийн бичиг баримтын бүрдэл дутуу, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн зэрэг шалтгаанаар хүлээж аваагүй тохиолдол 13 гарсан байх ба тухайн этгээдүүдийн шийтгэлийг бүрэн эдлүүлэх асуудлаар прокурорт мэдэгдэж, холбогдох арга хэмжээг авч ажиллах.	

2.7.Баривчлагдсан этгээдийн төлбөр төлөлтөд хийсэн шинжилгээ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 148 дугаар зүйлд “Баривчлагдсан этгээдийн баривчлах байранд байсан хугацааны шууд зардлын хэмжээг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална”, “баривчлагдсан этгээдийг аж ахуй нэгж, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан хөдөлмөрлүүлж болно” гэжээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2018 оны 4 дүгээр сарын 6-ны А/63,70 дугаар тушаалаар батлагдсан “Баривчлагдсан этгээдийг баривчлах байранд байсан хугацааны шууд зардлын хэмжээг тооцох журам”-д төлбөр төлөх асуудлыг зохицуулж өгчээ. Өнөөдрийн байдлаар баривчлагдсан этгээд нэг хоногт 3800 төгрөг буюу нэг сар саатуулагдан гэж үзвэл 114.000 төгрөгний зардлыг төлөх тооцоотой байна.


Нэг.Баривчлагдсан этгээдийг баривчлах байрнаас гарахад дараахь зардлыг байрны шууд зардалд оруулан тооцно.

- 1.дулаан, цахилгаан хэрэглүүлэх;
- 2.халуун хоол, цайгаар үйлчлэх;
- 3.автомашинаар хүргэх, тээвэрлэх;
- 4.карт баримт бичиг хөтлөх;
- 5.усанд оруулах;
- 6.фото зураг авах;
- 7.хувцас угаалга;
- 8.утсаар яриулах;
- 9.нэрийн дансны үйлчилгээ үзүүлэх.
- 10.үс авах, засах.

Хоёр.Баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийг баривчлах байранд хүлээн авсан огноо, цагаас эхлэн шууд зардлыг тооцно.

Судалгаанд оролцсон 452 баривчлагдсан этгээдээс байрны төлбөр төлөх нөхцөлийн талаарх саналыг авахад 181 хүн буюу 40% нь төлбөр үнэтэй, 179 хүн буюу 39,6% нь хөдөлмөр эрхэлж төлбөрөө төлөх хүсэлтэй, 92 хүн буюу 20,3% нь боломжийн гэж хариулсан байна.

Зураг 34.Баривчлах байрны төлбөрийн талаарх санал асуулгын дүн




Гурав. Баривчлах байрны орлогыг төсвийн байгууллагын төрийн сангийн бүртгэлийн дансанд төвлөрүүлэн зарцуулна.

Сүүлийн 5 жилийн хугацаа буюу 2015-2020 оны хооронд 26387 баривчлагдсан этгээдээс 18176 баривчлагдсан этгээд буюу 68.88% нь баривчлах байранд байрлах

хугацааны шууд зардал болох 364,572,292 төгрөг төлснийг улсын төсөвт төвлөрүүлсэн бөгөөд 8211 баривчлагдсан этгээд буюу 31.12% нь баривчлагдсан хугацааны шууд зардал болох 180,054,098 төгрөгийг төлөлгүйгээр суллагдсан байна.


Зураг 35. Баривчлах шийтгэл эдлэгсдээс төлбөр төлсөн байдлын судалгаа




Дөрөв.Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т заасны дагуу тухайн тайлант хугацаанд баривчлагдсан этгээдийн шууд зардлын тооцоог баривчлах байрны санхүүгийн албан тушаалтан Төсвийн тухай хуульд заасан хугацаанд орлого зарлагыг тооцож дээд шатны төсвийн эрх захирагчид хүргүүлж, жил бүрийн төсөвт тусгана.

- 2015 онд 4558 баривчлагдсан этгээд буюу 72.6% нь 54,359.550 төгрөгийг;
- 2016 онд 1574 баривчлагдсан этгээд буюу 52% нь 20,883.210 төгрөгийг;
- 2017 онд 3150 баривчлагдсан этгээд буюу 61% нь 48,477.200 төгрөгийг;
- 2018 онд 3538 баривчлагдсан этгээд буюу 81.22% нь 56,033.589 төгрөгийг;
- 2019 онд 5356 баривчлагдсан этгээд буюу 68.53% нь 184,818,743 төгрөг төлсөн.

Зураг 36.Төлбөр төлөлтийн хувь



Зураг 37.Төлбөр төлөлтийн мөнгөн дүн




Тав.Баривчлагдсан этгээдийн нэг хоногийн шууд зардалд үнийн өсөлт нөлөөлөхүйц өөрчлөлт гарсан бол тухай бүр шууд зардлын хэмжээг шинэчлэн батална.


Зургаа.Баривчлагдсан этгээд баривчлах төв болон байранд байсан хугацааны зардлаа төлөх чадваргүй, эсхүл төлөхөөс зайлсхийсэн бол тухайн этгээдээр албадан хөдөлмөр хийлгэж төлүүлнэ. Харин

- 2015 онд 1720 баривчлагдсан этгээд буюу 27.4% нь 25,285.900 төгрөгийг;
- 2016 онд 1457 баривчлагдсан этгээд буюу 48% нь 21,112.250 төгрөгийг;
- 2017 онд 2009 баривчлагдсан этгээд буюу 39% нь 23,846.600 төгрөгийг;
- 2018 онд 689 баривчлагдсан этгээд буюу 18.78% нь 18,006.075 төгрөгийг;
- 2019 онд 2336 баривчлагдсан этгээд буюу 31.47% нь 91,803,273 төгрөгийг төлөөгүй байна.

Зураг 38.Төлбөр төлөөгүй этгээдүүдийн судалгаа



Зураг 39.Төлбөр төлөөгүй мөнгөн дүнгийн судалгаа



Долоо.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 148 дугаар зүйлийн 148.2-т заасны дагуу баривчлагдсан этгээдийг аж ахуй нэгж, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан хөдөлмөрлүүлж болох ба хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг "Хоригдлын хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээ, суутгал хийх журам"-ыг баримтлан тооцно. Баривчлагдсан этгээдийн хөдөлмөрийн хөлсийг баривчлах байрны дансанд төвлөрүүлэн зохих төлбөр, суутгалыг хийж үлдэгдэл мөнгийг нэрийн дансанд нь төвлөрүүлнэ.

Найм.Баривчлагдсан этгээд баривчлах байранд байсан хугацааны шууд зардлыг төлөөгүй буюу албадан хөдөлмөрлүүлсний хөлс шууд зардалд хүрээгүй

эсхүл биеийн эрүүл мэндийн болон бусад шалтгаанаас хөдөлмөр хийгээгүй бол баривчлах төвийн захиргаа төлбөрийн хэмжээг өөрт нь танилцуулж гарын үсэг зуруулан, харьяалах шүүхэд нэхэмжлэл гаргаж, шийдвэрлүүлнэ.

Ес.Шууд зардлаас дараахь баривчлагдсан этгээдийг эрх бүхий байгууллагын тодорхойлолтоор чөлөөлнө:

-60 ба түүнээс дээш насны асран хамгаалах хүнгүй, амжиргааны баталгаажих түвшнээс доогуур;

-эрх бүхий байгууллагаас хугацаагүйгээр хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх хугацааг тогтоосон бол;


Зардлыг чөлөөлөх тохиолдолд Баривчлах байрны нийгмийн ажилтан энэ журмын 5.5-д заасан этгээдээс гаргасан хүсэлт, тухайн орон нутгийн засаг захиргааны, баривчлах байрны эмч, эмнэлгийн болон шаардлагатай бусад байгууллагын тодорхойлолт, үндэслэл бүхий баримт бичгийг судалж, саналаа тухайн нэгжийн даргад танилцуулна. Нэгжийн дарга баривчлагдсан этгээдээс гаргасан хүсэлт, нийгмийн ажилтан, эрүүлжүүлэх, саатуулах байрны эмчийн гаргасан саналыг үндэслэн зардлаас чөлөөлөх эсэхийг шийдвэрлэнэ. Зардлаас чөлөөлж шийдвэрлэсэн тохиолдолд тушаал гаргана.

Арав.Баривчлагдсан этгээд шууд зардлаа төлөх чадваргүй нь өдөр тутам тогтоосон хэмжээгээр хооллох, бусдын адил нөхцөлд шийтгэлээ эдлэхэд нөлөөлөхгүй.

Арван нэг.Баривчлагдсан хүнийг баривчлах төв /байр/-ийн ахуй үйлчилгээнд болон аж ахуйн нэгж, байгууллагад гэрээний үндсэн дээр ажиллуулж болно.Аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр ажиллуулахдаа прокурорын зөвшөөрлөөр, харуул хамгаалалттай хөдөлмөрлүүлнэ.Баривчлагдсан хүнийг хөдөлмөрийн хуульд заасан заасан цагаар ажиллуулна. Баривчлагдсан хүнийг гэрээний үндсэн дээр ажиллуулж буй аж ахуйн нэгж, хуулийн этгээд нь ажлын хөлсийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүйгээр тооцон олгох ба гэрээнд хийж гүйцэтгэх ажил, ажлын хөлс, цаг хугацаа, тээврийн зардал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилга өгөх, ажлын багаж, хувцсаар хангах зэргийг тусгана.

Судалгаанд оролцсон 452 баривчлагдсан этгээдээс баривчлагдсан хугацаандаа ажил хөдөлмөр эрхлэх хүсэлтэй юу? гэсэн асуулга авахад 171 хүн буюу 37,8% нь шаардлаггүй, 281 хүн буюу 62,1% нь хөдөлмөр эрхлэх хүсэлтэй гэж хариулсан байна.

Зураг 40.Ажил, хөдөлмөр хийх хүсэл, сонирхлын судалгаа



Баривчлагдсан хүнийг ажлын талбар, байр хооронд хүргэх, ажил хийж байх үед оргож зугатах, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх үүргийг баривчлах төв /байр/-ийн харуул хамгаалалтын ажилтан хариуцна. Баривчлагдсан хүний хөдөлмөрийн хөлсийг төв /байр/-ийн дансанд төвлөрүүлж, суллагдах үед зохих суутгалыг хийн, үлдэгдлийг өөрт нь олгоно. Баривчлагдсан хүнээр хөдөлмөрийн хортой нөхцөлд тооцогдсон ажил хийлгэхийг хориглоно. Харуул хамгаалалтын зохих шаардлага хангагдаагүй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журам биелэгдээгүй, эмчийн тодорхойлолтоор баривчлагдсан хүний эрүүл мэндийн байдал тэнцэхгүй тохиолдолд хөдөлмөрт гаргахгүй байхаар зохицуулсан байна.

3.1. Дүгнэлт

Судалгааны баг “Баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ” сэдэвт судалгааны ажилд Шүүхийн ерөнхий зөвлөл, Цагдаагийн Ерөнхий газар, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон түүний харьяа Баривчлах төвийн албан ёсны тайлан мэдээ, холбогдох хууль, журам, заавар, холбогдох материалыг уншиж танилцан ашигласнаас гадна баривчлагдсан 452 хүнээс анкетын аргаар, баривчлах төвд ажиллаж буй 41 алба хаагчаас баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлын талаар тодруулах ярилцлага хийж гүйцэтгэсний дүнд дараах дүгнэлтэд хүрлээ.

Монгол Улсад анх Засгийн газрын 1923 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 11 дүгээр хурлаар “Цагдан сэргийлэхийн эрх хэмжээний дүрэм”, “Цагдан цээрлүүлсэнийг зөрчсөнийг яллах хууль”-ийг анх баталсан ба “Цагдан цээрлүүлсэнийг зөрчсөнийг яллах хууль”-д захиргааны журам зөрчсөн, тухайн үедээ эрүүгийн хэргийн шинжгүй зөрчилд арга хэмжээ авах анхны хууль бөгөөд захиргааны зөрчлийн хүнд, хөнгөнийг харгалзан 1-15 хоног хорих, 1-15 төгрөгөөр торгууль ногдуулахаар заасан хэв журам сахиулах, хэрэг зөрчилтэй тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн эрх зүйн акт байжээ. Ийнхүү Цагдаагийн байгууллага анх захиргааны журмаар баривчлах, нийгмээс тодорхой хугацаагаар тусгаарлан шийтгэл оногдуулдаг үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хууль /1992.11.27/ батлагдан гарах хүртэл захиргааны хариуцлагыг янз бүрийн хууль тогтоомж, эрх зүйн актаар хариуцлага хүлээлгэж байсан иржээ. 1920-1990 он хүртэлх хугацаанд баривчлах шийтгэлийг голчлон архидан согтуурсан зөрчилд оногдуулж ирсэн нь нийгмээс архидан согтуурах явдалтай тууштай тэмцэж ирсний үр дүн байлаа.

Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 11-ны өдөр батлан гаргаж, мөн оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 2.1 дүгээр зүйлд “хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэнэ” гэж заажээ.”

Зөрчлийн тухай хууль нь 240 орчим хуулиар хориглож, хязгаарласан 1800 орчим үйлдэл, эс үйлдэхүйг нэгтгэсэн Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журмыг зөрчсөн тодорхой төрлийн захиргааны зөрчлүүд, тэдгээрийн бүрэлдэхүүн, зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх захиргааны шийтгэлийн төрөл, хэмжээг хуульчилж өгчээ. Зөрчил нь иргэдийн эрх зүйн ухамсар, хууль дээдлэх ёсны төлөвшилтэй шууд хамааралтай ухамсартай үйлдэл юм.

Нэг. Монгол Улсын хэмжээнд үйлдэгдэж буй зөрчил, түүнийг шийдвэрлэж буй байдал:

Монгол Улсын хэмжээнд 2015 онд-1.423.088 зөрчил, 2016 онд-1.037.970 зөрчил, 2017 онд-1.327.017 зөрчил, 2018 онд-1.698.178 зөрчил, 2019 онд-2.175.825 зөрчил үйлдэгдсэн байна. Энэ нь зөвхөн 2015 онд үйлдэгдсэн зөрчлийг 2019 оныхтой харьцуулахад 1,5 дахин өссөн үзүүлэлттэй байна. 2019 онд нийт үйлдэгдсэн зөрчлийн 73,3% нь Улаанбаатар хотод үйлдэгдсэн байна. Шүүхээс сүүлийн 15 жилийн байдлаар шийдвэрлэсэн захиргааны зөрчлийг судлан үзвэл жилд дунджаар 10,000-20,000 орчим хэрэг шийдвэрлэдэг байна.

Цаашид Монгол Улсын хэмжээнд жилд үйлдэгдэж буй зөрчлийн тоо улам өсөх хандлагатай байгаа нь иргэдийн архидан согтуурах, мансуурах бодисын хэрэглээ өссөн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд зөрчил, дутагдал тасрахгүй байгаатай холбож тайлбарлаж болох юм.

Хоёр. Баривчлах төв, байрны харьяалал, бүтэц, зохион байгуулалт:

Өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй Зөрчлийн тухай хуульд зааснаар 9 төрлийн зөрчилд баривчлах шийтгэл оногдуулж байгаа ба зөрчил үйлдсэн хүнийг долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар тусгай зориулалтын байранд саатуулахыг баривчлах шийтгэл гэнэ. Баривчлах шийтгэлийн агуулга нь зөрчил үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой нөхцөл, журам бүхий байранд саатуулахад оршино. Энэ шийтгэл нь нийгмээс тусгаарлах агуулгатай байдаг онцлогтой.

Шүүхийн шийтгэврээр оногдуулсан баривчлах шийтгэлийг нийслэлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын харьяа "Баривчлах төв"-д, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын харьяа "Баривчлах байр"-д эдлүүлж байна. Аймаг, орон нутгийн хэмжээнд шүүхээс жилд дунджаар 200-400 орчим хүнд баривчлах шийтгэл оногдуулж байгаагаас Архангай, Өвөрхангай, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Ховд зэрэг аймгуудад жил ирэх тусам өсч 400-1200 орчим хүнд баривчлах шийтгэл оногдуулдаг болжээ. Энэ нь аймгуудад өдөрт дунджаар 20-30, зарим аймгуудад 50-80 хүн баривчлагдах магадлалтай байна.

Зөрчлийн тухай болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хүрээнд баривчлах шийтгэлийг зөвхөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэтгэх ба цаашид тухайн чиг үүргийг аймаг, орон нутгийн байдлаар хэрэгжүүлэхэд баривчлагдсан этгээдийг саатуулах байр, алба хаагч, удирдлагын тогтолцоо гэсэн асуудал тулгарах болно.

Гурав. Баривчлах байрны чиг үүрэг:

ШШГЕГ-ын харьяа Баривчлах төвд 2015-2020 оны хооронд шүүхээс оногдуулсан баривчлах шийтгэл эдлүүлсэн хүний тоог авч үзвэл, 2015 онд-6278, 2016 онд-3031, 2017 онд-5159, 2018 онд-4356, 2019 онд 7815 хүн шийтгэл эдэлсэн байна.

Судалгаанд хамрагдсан 452 этгээдийн баривчлах шийтгэлийн үр нөлөөг та хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуултад 247 хүн буюу 54,6 ямар ч үр нөлөөгүй, 144 хүн буюу 31,8% нь дунд зэрэг, 61 хүн буюу 13,4% нь сайн үр нөлөөтэй байна гэж хариулжээ. Баривчлах төвд ажиллаж буй 41 алба хаагчаас баривчлах шийтгэлийн үр нөлөөг та хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуултад 31 алба хаагч буюу 75,6% баривчлах шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдох хууль тогтоомжийг өөрчлөх шаардлагатай, 9 алба хаагч буюу 21,9% нь ямар ч үр нөлөө алга, сайн үр нөлөөтэй гэж үзсэн алба хаагч байхгүй байна.

Судалгаанаас дүгнэж үзэхэд баривчлах шийтгэлийн үр нөлөө төдийлөн хангалтгүй байгаа ба улмаар холбогдох хууль, журмыг сайжруулах зайлгүй шаардлага байна гэж үзлээ.

Дөрөв. Баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагаанд хамаарах олон улсын болон үндэсний хууль тогтоомж:

Судалгааны ажлын хүрээнд Хүний эрхийн түгээмэл тунхаглал", Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, "Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц", "Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг

хамгаалах зарчмуудын цогц” гэсэн олон улсын баримт бичгийн агуулгыг Монгол Улсын Үндсэн хууль, Зөрчлийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Баривчлах байрны дотоод журмын хүрээнд харьцуулан судлан үзэхэд баривчлагдсан этгээдийн эрхийн асуудал хангалттай туссан гэж дүгнэлээ.

Тав.Баривчлагдсан этгээдийн эрх зүйн байдал:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 146.1-т “Баривчлагдсан этгээд нь баривчлах шийтгэл эдлэх хугацаандаа баривчлах байрны захиргаа, түүний алба хаагчийн хяналтад байх бөгөөд энэ хуулийн 210.1.1, 210.1.2, 210.1.3, 210.1.5, 210.1.9, 210.1.10, 210.1.11, 210.1.12, 210.1.13, 210.1.15-д заасан эрх эдэлж, энэ хуулийн 211 дүгээр зүйлд заасан үүрэг хүлээнэ” гэжээ. Дээрхээс баривчлагдсан этгээдийн эрх, үүргийг хоригдолтой адилтгасан нь ойлгомжгүйгээр барахгүй, хоригдлын эрхийг эдлэх боловч дахин Баривчлах байрны дотоод журмаар мөн адил эрх эдлэх нь тодорхойгүй байдал үүсгэж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 147 дугаар зүйлийн 147.1.“Баривчлагдсан этгээд нь Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 24.1, 24.4-д заасан ахуйн хангамжаар, энэ хуулийн 231.6-д заасан хэмжээний илчлэгтэй хоол, хүнсний зүйл болон хувцас, хэрэгцээтэй үедээ хэрэглэх ундны усаар хангагдана” гэж заажээ.

Баривчлах шийтгэл нь “тусгай зориулалтын байранд саатуулахыг хэлнэ” гэсэн зарчимтай дээрх хуулийн зүйл, заалт зөрчилдөж байгаа ба “гэмт хэрэг үйлдсэн хоригдол-гэмт хэрэгт сэжиглэгдсэн хоригдогч”-той адилтгасан байдлаар зохицуулсан нь хуулийн давхардал, хийдлийг үүсгэж байна гэж үзлээ.

Зургаа.Баривчлагдсан этгээдүүдийн дунд явуулж буй зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд хийсэн шинжилгээ

Баривчлах байр нь баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сэтгэл зүйн, эрх зүйн, бясалгалын сургалтыг зохион байгуулж байна. Баривчлах байрны дотоод журамд зааснаар баривчлах төв /байр/ нь сургалтын танхимтай байх бөгөөд шүүхийн шийтгэвэрт заасан хугацаагаар албадан сургалтад хамруулна гэж заасан ба Баривчлах төв нь зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг үр дүнтэй зохион байгуулах зорилгоор 60-80 хүний багтаамжтай лекцийн заал, зөвлөгөө, тусламж үзүүлэх зориулалт бүхий өрөө тасалгааг орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр тоноглож сургалтын заал, танхимуудыг тохижуулсан нь туйлын чухал ач холбогдолтой ажил болжээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн А/73 тоот тушаалийн хавсралтаар батлагдсан “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр”, “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам”-ын хүрээнд баривчлагдсан хүний зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх бөгөөд хөтөлбөрийг төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлж байна.

Судалгаанд хамрагдсан 452 этгээд Баривчлах байрнаас зохиож буй албадан сургалтын үр нөлөөг та хэрхэн үнэлж байна вэ? асуултад 123 нь буюу 27,2% нь үр нөлөө сайтай, 202 нь буюу 44,6% нь хангалтгүй, 28% нь ямар ч үр нөлөөгүй гэж хариулжээ. Дээрх судалгаа, зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам, хөтөлбөрт дүн шинжилгээ хийж үзэхэд хөтөлбөрийн агуулгыг өөрчлөх, мэргэжлийн багш, сургалтын байгууллагаар гүйцэтгүүлэн үр дүнг тооцдог тогтолцоонд шилжих шаардлага байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд 8211 баривчлагдсан этгээд буюу 31.12% нь баривчлагдсан хугацааны шууд зардал болох 180,054,098 төгрөгний баривчлах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шууд зардлыг төлөөгүй байгаа нь шийтгэлийн цээрлэлийн шинжийг үгүйсгэж байгаа ба төлбөрийг баривчлах шийтгэл эдэлж байх хугацаанд нь буюу төлүүлэх буюу хөдөлмөр эрхлүүлдэг тогтолцоонд шилжих шаардлагатай гэж үзлээ.

3.2.Зөвлөмж

Судалгааны үр дүн, дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжийг гаргалаа.

Нэг.Удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас баривчлах шийтгэлийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх хүрээнд аймаг, орон нутагт баривчлах шийтгэл гүйцэтгэх чиглэлээр бэлтгэл ажлыг /баривчлах байр, өрөө, алба хаагч, зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах материаллаг бааз, хамтын ажиллагаа/ хангахад чиглэсэн судалгааны ажлыг явуулах;

2.Баривчлах шийтгэлийг хорих, болон цагдан хорих ажиллагаатай холбон ойлгох асуудлыг нэг мөр болгон тусад нь “Баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх тухай хууль” болгон нөхцөл, журам, эрх үүрэг, сургалт, хөдөлмөртэй холбоотой бүх харилцааг зохицуулан хуульчлан өгөх;

3.Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг удирдан явуулах мэргэшсэн багш, сэтгэл зүйчдийг 50 хүнд-1 гэсэн орон тоотой байхаар зохион байгуулах.

Хоёр.Үйл ажиллагааны хүрээнд:

1.Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөг сайжруулах чиглэлээр мэргэшсэн сургалтын байгууллага, багш нараар түлхүү заалгах, сургалтын орчин үеийн арга хэлбэрийг ашиглан сургалтын чанарыг сайжруулах;

2.Баривчлах байрны дотоод журмыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлж, шийтгэлийн цээрлүүлэх шинжийг тодотгох;

3.Баривчлагдсан этгээдийг хөдөлмөрлүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд орон нутгийн засаг, захиргааны байгууллагатай хамтран ажиллан, төлбөр төлөлтийг нэмэгдүүлэх.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль, тогтоомж:

1. Үндсэн хууль.1992-01-13
2. Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/.2017-05-11
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /шинэчилсэн найруулга/.2017-06-09
4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /шинэчилсэн найруулга/.2016-12-22
5. Зөрчил шалган шийдвэрлэх тухай.2017-5-18
6. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай1999-01-07
7. Баривчлах байрны дотоод журам.2017-09-29
8. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам.2017-04-04
9. Сэтгэл зүйн ажлын заавар.2019-6-07

Ном, сурах бичиг:

1. Ч.Нямсүрэн, "Эрх зүйн онол" ерөнхий анги, УБ., 2016
2. Ж.Сүхбаатар, "Захиргааны эрх зүй", УБ., 2005
3. С.Долгорсүрэн, "Захиргааны хариуцлага", УБ., 2005
4. А.Лхагва.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй.УБ.2014
5. Б.Алтангэрэл.Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа:харьцуулсан судлал.УБ.2018 он

Судалгааны тайлан:

1. Хууль зүйн үндэсний хүрээлэн.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа: /харьцуулсан лавлагаа/.2017
2. Хууль зүйн үндэсний хүрээлэн.Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ.2018

Цахим хаяг:

1. www.mojha.gov.mn
2. www.cd.gov.mn
3. www.police.gov.mn